“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “САЛХИТЫН МӨНГӨ-АЛТНЫ УУРХАЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2025 он

ГАРЧИГ

1. Компаний үндсэн мэдээлэл танилцуулга, бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....1-2
2. Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....3
2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....3-8
2.2. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....9-11
2.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....12-13
2.4. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт.....14-16
2.5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт.....17-18
3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....19-22
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, ногоон байгууламж байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....23-26
4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....27-31
5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....31
6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....31-32
7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....33-35
8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....37-44
9. Орчны хяналт шалгалтын хөтөлбөрийн биелэлт.....45-50
10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....51-53
11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт.....54-55
12. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүгнэлт.....55-58
13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргааны хүснэгт.....58-59
14. Тайлангийн хавсралт..... 60
- БОМТ-ний хяналтын хуудас.....60-72
- Компаний гэрчилгээ.....73-74
- 2025 оны Аудитын үл нийцлийн тайлан.....75-84
- 2025 оны Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын тайлан.....85-162
- 2025 оны Ус ашиглалтын тайлан.....163-417
- 2025 оны Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан, ус, агаар, хөрсний усны хяналт шинжилгээний хариу.....418-667
-ТЭЗҮ, нөөц хүлээн авсан тушаал шийдвэр.....668-678

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ ТАНИЛЦУУЛГА, БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

/Баяжуулах үйлдвэр, ил уурхай/

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 133 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 49 дүгээр тогтоолоор “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийг стратегийн ач холбогдол бүхий мөнгөний ордуудыг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах чиг үүрэг бүхий “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 100% эзэмшлийн охин компани хэлбэрээр 2023 оны 07 дугаар сард үүсгэн байгуулсан.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн хүрээнд Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэл, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр шийдвэрээр Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхит” нэртэй 2887.85 га бүхий ашигт малтмал ашиглах ашиглалтын MV-021483 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайг “Эрдэнэс алт ресурс” ХХК-д олгосон. Монгол Улсын Засгийн Газар болон Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамны бодлогын хүрээнд улсын төсвийн тогтвортой эх үүсвэрийг шинээр бий болгох, салбарын нөөц боломжийг зохистойгоор ашиглах үүднээс “Салхит”-ын мөнгө-алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагааг боломжит богино хугацаанд цаг алдалгүй эхлүүлж, Монгол улсын эдийн засагт тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Эрдэнэс алт ресурс ХХК-тай нэгтгэх Эрдэнэс монгол ХХК-ний төлөөлөн удирдах зөвлөлийн 49 дүгээр тогтоол гарч Эрдэнэс алт ресурс ХХК болсон.

Түүнчлэн төрд ногдох өгөөжөөс Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль, түнийг дагаж мөрдөх журмын тухай хууль зэрэг хуулиар заасан тусгай чиг үүргийг мөрдлөг болгон ажиллаж байна.

<u>Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчим</u>

- Бизнесийн зөвлөгөө өгөх;

<u>Компанийн тусгай зөвшөөрөл</u>

- Дундговь аймгийн Гурвансайхан сумын Салхит нэртэй газарт орших 2,887.85 гектар талбайг хамарсан MV-021483 дугаартай Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл;

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2025 онд нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, уул уурхайгаас иргэдийн хүртэх өгөөжийг дээшлүүлэх, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль, түнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж байна.

Компанийн нэр:	“Эрдэнэс алт ресурс” Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
Үйл ажиллагааны чиглэл:	• Бизнесийн зөвлөгөө өгөх; • Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль зэрэг хуулиар заасан тусгай үүргийг мөрдлөг болгон хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
Компанийн хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар Дүүрэг 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 17, Блю Скай тауэр, 607 тоот. Утас: (976) 7535 1111 E-Майл: info@erdenesgold.mn Веб хуудас: www.erdenessilver.mn
Компанийн удирдлага:	Гүйцэтгэх захирал Э.Уганбаяр
Үүсгэн байгуулагдсан огноо:	2023 оны 07 дугаар сарын 05-ний өдөр
Орон тоо:	179
Салхит мөнгө-алтны ордын байршил:	Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт оршдог. Улаанбаатар хотоос урд зүгт 280 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн хойш 60 км-т, Гурвансайхан сумын төвөөс хойш 35 км зайд байрлана.
Талбайн хэмжээ:	2887.85 гектар (га)
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-021483
Хүчин чадал:	600 мян.тн
Нөөцийн хэмжээ:	600,000 тонн/жил хүдэр Ордын нийт нөөц-2,920.9 мян.тонн /982.87 тонн мөнгө, 1,353.7 кг алт/. Таамагласан нийт баялаг-4,649.6 мян.тонн

1.5. Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээ, тайлан:

Баяжуулах үйлдвэр нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар **505’350.51 тн** хүдэр боловсруулж **8,060.04** тн баяжмал үйлдвэрлэсэн байна.

2025 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

№	Үйлдвэрлэлийн мэдээ	2025 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар
1	Ил уурхайн нийт олборлосон хүдрийн материал буюу уулын цул /хөрс, хүдэр нийлсэн хэмжээ/ (мян/м3) Үүнээс:	**1,014,016.28 мян/м^3**
2	Боловсруулсан хүдэр (мян/тонноор)	**505,350.51 тн**
3	Үйлдвэрлэсэн баяжмал (мян/тонноор)	**8,060.04 тн**

БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, мян.төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед олборлолтын үйл ажиллагааг түр зогсоох	Уурхайн хэмжээнд	-	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг ханган ажилласан байна.	Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн өдрүүдэд уурхайн нийт хөдөлгөөнийг тухай бүр зогсоож аюулгүй ажиллагааг ханган ажилласан. Хүчтэй салхи шуурганаас үүдэлтэй олборлолтын үйл ажиллагааны түр зогсолт хийгдээгүй.
2	Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээний дагуу хяналт тавих	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тоосжилт, агаарын бохирдлоос сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангаж ажилласан байна.	Салхит уурхайгаас Чойр орох чиглэлийн замд нийт 3 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Мөн зам дагуух хог хаягдлыг тухай бүр цэвэрлэж Гурвансайхан сум, Дэлгэрцогт сумын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж ажилласан. Нийт 26 удаа хяналт тавьж ажилласан. Үүнээс гадна гадаад тээврийн технологийн зам болох Салхит уурхайгаас Дэлгэрцогт сумруу чиглэлтэй 60 км технологийн замыг зуны бороо ус элбэг байх үед, өвлийн улиралд цас ихтэй байх үеүдэд хусаж засварладаг. Бүтээгдэхүүн тээвэрлэх явцад хяналт тавих ажлыг давхар хийж гүйцэтгэдэг бөгөөд нийт 24 замын хяналтыг хийж гүйцэтгэсэн.
3	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа, арчилгааг хийх	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тоожилт, агаарын бохирдлоос сэргийлж ажилласан байна.	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд усалгааг тогтмол хийдэг. Уурхайн доторх болон дэд бүтцийн шугамын дагуух замуудыг дулааны улиралд өдөр бүр, түгээмэл ашиглагддаг замуудад өдөрт 2-3 удаа тоосжилт үүсэхээс сэргийлж усалгааг хийж гүйцэтгэдэг. Хүйтний улиралд дулаан өдрийг сонгон усалгааг хийж гүйцэтгэсэн. 2025 онд нийт

					3270 м^3 усыг зам талбайн усалгаанд зарцуулсан байна.
4	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Хөрсөнд нефтийн бүтээгдэхүүний бохирдол, нэвчилт, асгаралт үүсгэхгүй байх арга хэмжээг авч ажилласан байна.	“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн батлагдсан Байгаль орчны журмуудын хүрээнд нефтийн бүтээгдэхүүн саармагжуулах хэрэгслийг шатахуун станц дээр бүрэн байршуулсан. Одоогоор асгаралт үүссэн тохиолдол бүртгэгдээгүй. Туслан гүйцэтгэгч компаниудад чиглэл өгч, гүйцэтгэлийг газар дээр нь шалгаж тогтмол хяналт тавин ажилласан. Мөн хүнд машин механизмын авто засварын цех, зогсоол орчимд асгарсан бага хэмжээний тосыг хуримтлуулж саармагжуулах нүхийг бэлтгэсэн.

5	Тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон Олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлэх	Уурхайн машин, механизмууд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Холбогдох стандарт дүрэм журмын дагуу хяналт тавин ажилласан байна.	Холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу тээврийн хэрэгслүүдэдтэй холбоотой бичиг баримтын бүрдлийг хангуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажилласан.
6	Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Уурхайн машин, механизмууд Уурхайн машин, механизмууд	1’000’000	Техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж ажилласан байна.	Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 17 техник, Аглаг хангайн уулс ХХК-ийн 12 техник, хос жирэм ХХК 1 техник, Трү ти ар си ХХК 1 техник, Дулаан сэнтий ХХК 1 техник, Супер херо ХХК 1 техник, Онц цэвэрлэг булаг ХХК 1 техник, МН жойн ХХК 2 техник, Соёолон интернэшнл ХХК-ийн 12 техникт үзлэг оношилгоонд бүрэн хамруулсан бөгөөд нийт техникийн үзлэг шалгалтыг өдөр болгон үзлэгийн хуудсаар хийдэг. Засвар үйлчилгээг машин механизмын засварын цехэд тухай бүр хийж хэрэгжүүлж ажилласан.

7	Хүдэр бутлах хэсгээс үүсэх тоосжилтыг бууруулж ажиллах талаар туслан гүйцэтгэгч компаниудад шаардлага хүргүүлж ажиллах, тоосжилтыг бууруулж ажиллах	Баяжуулах үйлдвэр, ажилчдын хотхон, хаягдлын сан орчимд	105,000,000	Сар бүрийн гүйцэтгэлийг дүгнэх тайлангийн хурлаар чиглэл өгч, тоосжилтоос сэргийлж бууруулж ажиллана.	1 Салхины эрсдэл, тоосжилт, борооны шууд өртөлт өндөртэй нөхцөлд бусад уул уурхайн үйлдвэрийн ил тээвэрлэлт, конвейер дээр ашигладаг конвейерийн дээд хэсгийг бүрхэж хаадаг хаалт буюу ковероор конвейеруудаа хааж бүрэх хаалт суурилуулав. 2. Тоосжилтыг багасгах хамгийн энгийн бөгөөд хялбар арга нь ротортын тэжээлийн ам дээр эргэлийн ус өгөх ба энэ нь ротортын ам руу орж буй хүдэрт 1-3% ийн чийгийг нэмэх тул бутлалтын үеийн нунтаг тоосжилтоор алдагдаж буй хүдрийн бүтээлийг бодитоор багасгаж өгдөг.

					Үйлдвэрт ашиглагдсан эргэлтийн усаар ротортын тэжээлийн ам дээр хүдрийн чийгийг нэмэх зорилгоор 25мм-ийн диаметртэй усны уян шлангаар ус өгч ажиллаж байна.
8	Хүдрийн дунд овоолгын хэсэгт тоосжилтоос сэргийлэх салхины хаалт хийх	Баяжуулах үйлдвэрийн орчимд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тоосжилтоос сэргийлж бууруулж ажиллана	Нийт 6.35м өндөртэй, 70м-ийн урттай салхины хаалтыг салхины эсрэг чиглэлтэй буюу хойно болон баруун хойноос ирэх салхийг хаахаар байршилтайгаар төлөвлөж хийсэн. Салхины хаалт суурилуулсан байдал:

Нийт зарцуулсан төсөв			**106’000’000**		

2.2. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн үйл ажиллагаанд усыг зүй зохистой ашиглах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулан усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажилладаг. Уурхайн зүгээс усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах зорилгын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан.

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, мян.төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах, төлбөрийг төлөх	Уурхайн хэмжээнд	531’253’548 төгрөг **Тайлбар:** БОМТ-ний хэрэгжилтийн зардалд оруулаагүй	Ус ашиглах гэрээ, зөвшөөрлийг авч, ус ашигласны төлбөр тооцоог холбогдох хуулийн дагуу төлсөн байна.	Монгол Улсын “Усны тухай хууль”-ийн дагуу Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаатай 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ус ашиглуулах гэрээг байгуулсан. 2025 оны 11 дугаар сарын 01-ний байдлаар нийт **521’817’660.0** төгрөгийг Дундговь аймгийн Татварын хэлтэс, худалдаа хөгжлийн банкны 3220304720676 тоот дансанд төвлөрүүлсэн.

2	Хаягдал усны дүгнэлтийг гаргуулж, төлбөрийг төлөх, Хаягдал усны зөвшөөрөлд сунгалт хийлгүүлэх	уурхайн хэмжээнд		Хаягдал усны дүгнэлтийг гаргуулж тооцоог холбогдох хуулийн дагуу төлсөн байна.	Монгол улсын “Усны тухай хууль”-ийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр ус бохирдуулсны төлбөрийн гэрээг байгуулж, Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаанаас Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлын сунгалтыг авсан.
3	Усны бүх эх үүсвэрийг тоолууржуулах, орон нутгийн төрийн захиргааны болон бусад холбогдох байгууллагуудад хандаж, баталгаажуулах, нэмэлт тоолуур суурилуулах шаардлага үүссэн тохиолдолд суурилуулах	Уурхайн гүний худгууд, усан сангийн байгууламж	1’720’000	Орон нутгийн төрийн захиргааны болон бусад холбогдох байгууллагуудад хандаж, баталгаажуулсан байна.	Уурхайн гүний худгийг тоолууржуулж, ашиглалтын хэрэглээнд хяналт тавих, усны төлбөр хураамжийг бодитойгоор тооцох, үндсэн болон гэрээт компаниудын үйлдвэрлэлийн болон ахуйн бусад хэрэглээний ус ашиглалтыг бодитойгоор тооцох, хяналт тавих зорилгоор тоолууруудыг Гурвансайхан сумын байцаагч нартай тооцоо нийлсэн акт үйлдэж сар, улирал бүрээр тооцоог хийж ажилласан. 2025 онд нийт 7 ширхэг тоолуур авч хэрэглээнд ашигласан.
4	Өөрийн эзэмшлийн болон орчин тойрны гүний усны түвшин, ундарга хэмжих	Уурхайн гүний худгууд, малчдын хэрэглээний бэлчээрийн худгууд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Түвшинг хэмжсэн байна.	Усны түвшин хэмжигч ашиглан баяжуулах үйлдвэр №1-ийн үйл ажиллагаанд ашигладаг №4-р худаг, №6-р худаг, №7-р худаг, №8-р худаг, №12-р худаг, №13-р худаг болон Баяжуулах үйлдвэр №2-ийн үйл ажиллагаанд ашигладаг №1-р худаг, №2-р худаг, №3-р худаг, №5-р худаг, №9-р худаг, №10-р худаг, №14-р худгуудад долоо хоног бүрийн лхагва гаригт усны түвшин, ундаргын хэмжилтийг тогтмол хийсэн. Нийт 13 худагт 2025 онд 43 удаа ундарга болон түвшний хэмжилтийг хийсэн.
5	Өөрийн эзэмшлийн болон орчин тойрны гүний болон малчдын хэрэглээний гар худгуудад хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Өөрийн эзэмшлийн болон орчин тойрны худгуудад	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Ундны усны чанарыг тодорхойлох	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 1, 2, 3 4 дүгээр улирлын ус, хөрс, агаарын дээжүүдийг эрх бүхий итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж шинжлүүлж ажилласан. Тус ажлын хүрээнд хамтын оролцоот байгаль орчны мониторингийг хэрэгжүүлж нутгийн иргэн Б.Хонгорзулыг оролцуулж хамтран ажилласан.

					Ингэснээр нутгийн иргэдэд зөв, бодит мэдээлэл олгох цаашид хамтран ажиллахад үл ойлголцлын асуудал багасах давуу талтай. Орчны хяналтыг мэргэжлийн Нандин байгаль ХХК-аар хийлгүүлж гүйцэтгүүлсэн. ОХШХ-ийн биелэлт хэсэгт зардлыг оруулсан болно.
6	Хөрсний усны түвшинд өөрчлөлт гарч буй эсэхийг хянах хэмжилт хийх	Хяналтын цооногуудад	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Түвшинг хэмжсэн байна.	Усны түвшин хэмжигч ашиглан долоо хоног бүрийн лхагва гаригт усны түвшин, ундаргын хэмжилтийг тогтмол хийсэн. Мөн усны хяналтын 2 цооногийн хэмжилтийг өдөр бүр хийдэг бөгөөд датаг хуулж авахад хөрсний усны түвшин өмнөх онуудтайгаа харьцуулахад өссөн үр дүнтэй харагдсан.
			1’720’000		

2.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Олборлолт нэмэгдэх бүрт шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Шимт хөрсний чанарыг хамгаалсан байна.	Уурхайн хаягдлын овоолгыг тэлэх, зам талбай шинээр байгуулах, хаягдлын сан, тохижилт бүтээн байгуулалт, хүдрийн талбай бэлдэх ажлуудыг гүйцэтгэхээс өмнө шимт хөрсийг хуулахдаа стандартын дагуу хуулж шимт хөрсний овоолгод тээвэрлэж төвлөрүүлэх ажилд хяналт тавьж ажилласан. 2025 онд хүдэр олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор шимт хөрс хуулах зөвшөөрөл олгогдоогүй болно. №1 болон №2-р шимт хөрсний овоолгыг стандартын дагуу 5 метрээс хэтрэхгүй хэлбэршүүлж хадгалж байна.
2	Техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай (засварын цех)-д байрлуулж засах	-	500’000	Хөрсний бохирдлоос сэргийлэн ажилласан байна.	Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 17 техник, Соёолон интернэшнл ХХК-ийн 12 техник, Аглаг хангайн уулс ХХК-ий 9 техникт үзлэг шалгалтыг өдөр болгон үзлэгийн хуудсаар шалгадаг. Уурхайн засварын цех нь 30 метрийн урттай, 8 метрийн өргөнтэй, 6 метрийн өндөртэй сэндвичэн барилга байгууламжтай. Гадна болон дотор талбайн бетонон талбайтай. Компанийн батлагдсан журмуудын дагуу тогтмол хяналт тавин ажилладаг.
3	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт хуримтлал ихээр үүссэн тохиолдолд зөөвөрлөн хаяж байх	Уурхайн талбайд	Өөр бүлэгт зардлыг тооцсон	Ахуйн хог хаягдлыг холбогдох хуулийн дагуу ангилан ялгаж, тээвэрлэж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн	2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргатай Хог хаягдлын гэрээ байгуулсан. Гэрээний дагуу уурхайн хог хаягдлыг 2025 онд 1-р улиралд 9 удаа, 2-р улиралд 2 удаа, 3-р улиралд 5 удаа, 4-р улиралд 2 удаа буюу нийт 17 удаа тээвэрлэлт хийж 425 тн хогийг Гурвансайхан сумын хогийн цэгт асгах, зөөн тээвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Тус ажилд Гурвансайхан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч тогтмол хяналт тавьж хамтран ажилласан.

				байна.	
4	Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих	Уурхайн үйл ажиллагааны талбайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Холбогдох стандартын дагуу шимт хөрсийг хадгалах	Уурхайн хаягдлын овоолгыг тэлэх, зам талбай шинээр байгуулах, хаягдлын сан, тохижилт бүтээн байгуулалт, хүдрийн талбай бэлдэх ажлуудыг гүйцэтгэхээс өмнө шимт хөрсийг хуулахдаа стандартын дагуу хуулж шимт хөрсний овоолгод тээвэрлэж төвлөрүүлэх ажилд хяналт тавьж ажилласан. 2025 онд явган хүний зам хийх зорилгоор 1 удаагийн шимт хөрс хуулах зөвшөөрлийг олгож №1 шимт хөрсний овоолго дээр стандартын дагуу хэлбэршүүлж төвлөрүүлж ажилласан.
Нийт: 500’000 төгрөг					

2.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Хөрсний овоолго шинээр байгуулах, барилга бүтээн байгуулалт, газар шорооны ажил гүйцэтгэх бүрт ургамлан нөмрөг дарагдахаас сэргийлэх ажлыг зохион байгуулах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тээвэр, барилга бүтээн байгуулалтын нөлөөгөөр ургамлан нөмрөг доройтохоос сэргийлсэн байна.	Уурхайн хаягдлын овоолгыг тэлэх, зам талбай шинээр байгуулах, хаягдлын сан, тохижилт бүтээн байгуулалт, хүдрийн талбай бэлдэх ажлуудыг гүйцэтгэхээс өмнө шимт хөрсийг хуулахдаа стандартын дагуу хуулж шимт хөрсний овоолгод тээвэрлэж төвлөрүүлэх ажилд хяналт тавьж ажилласан. 2025 онд нийт 1 удаагийн шимт хөрс хуулах зөвшөөрлийг олгож №1-р шимт хөрсний овоолго дээр стандартын дагуу хэлбэршүүлж төвлөрүүлж ажилласан. №1 болон №2-р шимт хөрсний овоолгыг стандартын дагуу 5 метрээс хэтрэхгүй хэлбэршүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.
2	Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх, олон салаа замуудыг цэгцэлж, шаардлагагүй замуудыг хаах арга хэмжээ авах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тоожилтоос сэргийлж ажилласан байна.	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд усалгааг тогтмол хийдэг. Уурхайн доторх болон дэд бүтцийн шугамын дагуух замуудыг дулааны улиралд өдөр бүр, түгээмэл ашиглагддаг замуудад өдөрт 2-3 удаа тоосжилт үүсэхээс сэргийлж усалгааг хийж гүйцэтгэдэг. Хүйтний улиралд дулаан өдрийг сонгон усалгааг хийж гүйцэтгэсэн. 2025 онд нийт 3270 $м^3$ усыг зам талбайн усалгаанд зарцуулсан байна.
3	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах,	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авч ажилласан байна.	Асгаралтын журмын хүрээнд асгаралтыг удирдах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бэлтгэлийг хангаж ажилласан. Мөн асгарах эрсдэлтэй хаягдал тосны цэгийг стандартын журмын дагуу хяналт тавьж ажилласан. Одоогоор

	саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах				асгарсан зөрчил гараагүй болно.
4	Хяналтын талбай бүрт ургамлын судалгааг хийж гүйцэтгэх	Мониторингийн цэгүүдэд	1’000’000	Мониторингийн цэгүүдэд ургамлын бичиглэл хийж гүйцэтгэсэн байна.	Ургамлын судалгааг 2025 оны 6 дугаар сард талбайг бүрэн илтгэх боломжтой 17 цэгт, байнгын мониторингийн 6 цэгт судалгаагаар 25 овгийн 44 төрлийн 64 зүйл ургамал бүртгэгдсэн. Тус судалгааг мэргэжлийн компани болох “Нандин байгаль” ХХК-иар хийлгүүлсэн.
5	Зүйлийн бүрдлийг тодорхойлж, ургамлын бичиглэл хийх	Төслийн талбайд ойр орших ургамлын бүлгэмдлийн хяналтын цэгүүдэд	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөнд зардлыг тооцсон.	Мониторингийн цэгүүдэд ургамлын бичиглэл хийж гүйцэтгэсэн байна.	Судалгааны талбайн ургамлан нөмрөгийн Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/ бэлчээр, Сайрын хялганат/ ЦХ-I-1-1/бэлчээр, Харганат / ЦХ-I-3-1/ бэлчээр соргог, Сөөг бүхий сайрын хялганат/ ЦХ-I-1-1/ бэлчээр, Харгана - улалжит / ЦХ-I-3-1/ бэлчээр, Сайрын хялгана- алаг өвст / ЦХ-I-1-1/ бэлчээр, Дэрст / Н-III-3-5/ Дэрс – таанат /Н-III-3-4/Сайрын хялганат/ ЦХ-I-1-1/ бэлчээр, Сайрын хялгана- хазаар өвст / ЦХ-I-1-2/ бэлчээр, Дэрст /Н-III-3-5/ бэлчээр, Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/Дэрс – улалжит /Н-III-3-5/ бэлчээр сул талхлагдсан, Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/ бэлчээр, Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/ бэлчээр дунд, Таана – Монгол өвст бэлчээрийн талхлагдсан хувилбар / ЦХ-I-2-2/ улалжит бэлчээр их талхлагдсан байна. “Монгол орны улаан ном” (2013)-д орсон нэн ховор, ховор ургамлын зүйлүүд

					тэмдэглэгдээгүй. Мониторингийн цэгүүд нь бэлчээрийн нөлөөтэй, цаг уураас хамаарсан үндсэн бүлгэмдлүүд байна.
6	Ногоон байгууламжид зориулан тарьсан мод, сөөгний өвөлжилт, амьдрах чадварыг хянах, тооллого хийх	Уурхайн ногоон байгууламж байгуулсан нийт талбайд	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний зардлаас	Тооллого судалгааг хийж, амьдрах чадамжийг тодорхойлсон байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон эрдэнэс” төслийг байгуулах ажлыг 2021 онд эхлүүлсэн. Энэхүү төгөлд 2021 оноос 2025 он хүртэл 174,000.0 хайлаас мод тарьсан. Цаашид ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх ургамлын төрлийн зүйлийг олон болгох, Хаалтын нөхөн сэргээлтийн ажлын үндсэн бааз суурь болгох мод үржүүлгийн газар байгуулах ажлуудыг төлөвлөн ажиллаж байна. Тарьсан моднуудын амьдрах чадвар 90%-тай буюу сайн ургалттай байна.
Нийт: 1’000’000 төгрөг . Тус бүлэгтэй холбоотой зардлуудыг ОХШХ-ийн зардалд тооцсон.					

2.5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Уурхайн тээврийн зам дагуух арчилгаа тордолгоог, тогтмол хийж, замын тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу байршуулах	Уурхайн тээвэрлэлтийн зам дагуу	19’000’000	Сөрөг нөлөөллийг бууруулж ажилласан байна.	Гадаад тээврийн технологийн зам болох Салхит уурхайгаас Дэлгэрцогт сумруу чиглэлтэй 35 км технологийн замд нийт 7 тэмдэг, уурхайн технологийн зам дагуу 30 тэмдэг шинээр байршуулж ажилласан.
2	Туруутан амьтны тоо толгойг тогтоох нүүдэл шилжилтийг тодорхойлох	Их газрын чулууны БЦГ	500’000	Уурхай орчны бүсийн амьтдын тооллого, ажиглалт, мониторинг хийж тоо хэмжээ, тархалтыг тодорхойлох	Уулын туруутан амьтдын намрын тооллого судалгааг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны албан хаагчидтай хамтран хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнгээр янгир ямаа нь Их газрын чулууны уул, аргаль хонь нь Ерлөг ууланд арай олон тоогоор ажиглагдсан. Сүргийн бүтцийн ашиглалт нь аргаль, янгирын сүргийн бүтцийн эм бодгалийн тоо, залуу бодьгалийн тоо их байгаа нь цаашид өсөх хандлагатай байна. Энэ нь хамгааллын чухал үр дүн юм. Зэрлэг амьтдын цаашид тогтвортой өсөж байгаа, буурч байгаа нь жил бүрийн ажиглалтаар батлагдах учир энэхүү судалгааг олон жил таслахгүй хийх нь зэрлэг амьтдыг хамгаалахад асар том суурь судалгаа болж байгаа юм. Тус судалгааг үндэслэн цаг хүндэрсэн тохиолдолд биотехникийн арга хэмжээг авахаар төлөвлөн ажилласан.

3	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	Уурхайн талбайд	-	Шинээр газар ухах зөвшөөрлийг олгохгүй байна.	2025 онд уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд шинээр газар ухах зөвшөөрөл өгөөгүй.
4	Тарваганы тоо толгойн судалгаа хийх	Салхит уурхайгаас Дундговь аймгийн төв хүртэлх Мандал дэд станцын шугам дагуу	1,000,000	Тооллого, ажиглалт, мониторинг хийж тоо хэмжээ, тархалтыг тодорхойлох	Дундговь аймгийн Сайнцагаан сумын Хаалгын хад, Улаан худаг гэх газарт нутагшуулсан тарваганууудад байгаль хамгаалагч Б.Бат-Эрдэнэ, идэвхтэн байгаль хамгаалагч Ж.Дэлэг, Д.Гантөмөр нартай хамтран ажиглалт судалгааг хийж ажилласан. Нийт 20 гаран бүлийн 200 гаруй тоо ширхэг тарвага бүртгэгдсэн гэж үзсэн. Цаашид ЭАР ХХК нь 2026 онд камержуулах, мэргэжлийн компаниар нарийвчилсан судалгааг хийлгүүлэх шаардлагатай гэж үзэж ирэх оныхоо төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр болсон.
			20’500’000		

БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Орон нутгийн техникийн нөхөн сэргээлт

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Далай багийн нутаг дэвсгэрт байрлах “Хайрханы ар” нэртэй хууль бусаар ухагдаж эвдрэлд орсон, эзэн холбогдочгүй байгаа талбайд хэрэгжүүлэхийг санал болгосны дагуу 2025 онд 50,000,000 төгрөгөөр Алхими ХХК-аар техникийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж орон нутагт актаар хүлээлгэн өгсөн.

3.2. Уурхайн явцын нөхөн сэргээлт

2025 онд Салхит уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан 23,8 га талбайд 388,380.24 м3 уулын цулыг түрж тэгшилсэн бөгөөд хаягдлын овоолго 1, 2-ыг **11^0-16^0** градус налуужуулж явцын техникийн нөхөн сэргээлтийг Гранд сити ХХК хийж гүйцэтгэсэн. Уг ажилд **1,800,000,000**



төгрөгийг зарцуулсан.

1-р хөрсний овоолгын техникийн нөхөн сэргээлтийн зураг




2-р хөрсний овоолгын техникийн нөхөн сэргээлтийн зураг

3.3 Биологийн нөхөн сэргээлт

Шинэ эхлэл групп ХХК-иас 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Биологийн нөхөн сэргээлт /Салхит уурхай/-ийн үйлчилгээ үзүүлэх Дугаар № ЭАРХХК/20250101159 тоот гэрээний дагуу Салхит уурхайн 1 дүгээр отволны дээд талын хэсэгт 5 га талбайд нийт 7700 м^3 шимт хөрсний дэвсэлтийг ажлыг зохион байгуулсан. Сайжруулсан алтан харганыг 7 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд суулгацаар 15500, үрээр 20000 ширхэгийг тариалж, усалгаа, арчилгааг хийсэн. 2026 онд суулгацаар 14500, үрээр 30000 тарилт хийхээр төлөвлөсөн. Биологийн нөхөн сэргээлтийн ажилд нийт **893,107,000** төгрөг зарцуулсан.





БҮЛЭГ 4. ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ, НОГООН БАЙГУУЛАМЖ БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Тэрбум мод тарих” аяны хүрээнд Хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл” талбайд 40000 ширхэг хайлаас, мод тарина.	Уурхайн талбайд Уурхайд хуучин таригдсан мод бүхий талбайд нөхөн тарилт хийх, шинээр мод тарьсан байна.	70.000	Тэрбум мод тарих төлөвлөгөөний зардлаас 157,500,000	Үндсэн болон нийт туслан гүйцэтгэгч компаниудын идэвхи оролцоо, дэмжлэгтэйгээр хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдийн хүрээнд мод тарих ажлыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хийж хэрэгжүүлнэ.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор тайлант жилд “Эрдэнэс алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудтайгаа хамтран 73000 ширхэг хайлаас мод тарьснаас 2025 оны Хаврын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр 20000 ширхэг хайлаас мод, Намрын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдэд 53000 ширхэг хайлаас модыг тус тус Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д тарьсан.

2	Алтан Солин ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2025 оны 4 сараас 40,000 ширхэг 3 настай хайлаас модны суулгацыг хүлээн авч хашаа болон усалгаа арчилгааг шийдэн төгөл байгуулах	Өмнөх онуудад бойжуулсан суулгацыг хүлээн авч, тарих газруудыг Ойн газартай болон төсөл хэрэгжиж буй орон нутгийн захиргаатай харилцан тохиролцож шийдвэрлэсэн байна.	70.000	9,000,000	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран ажилллана.	Алтан солин ХХК-аас нийт 70,000 ширхэг суулгац, Түмэн форест ХХК-аас 3,000 ширхэг суулгацыг тус тус авч 2025 оны хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдэд тарилт хийж гүйцэтгэсэн.

3	Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д усалгааны систем, хашаа, бордоо, тоног төхөөрөмж зэрэг шаардалагатай зүйлсийг бэлтгэх	Дундговь аймагт мод үржүүлгийн талбайг шинээр байгуулах, шаардалагатай тоног төхөөрөмж, ажиллах хүн хүч, бусад дэд бүтцийн асуудлыг бүрэн төлөвлөж, бэлэн байдлыг хангасан байна	-	89,450,000	Үйл ажиллагаа явуулж буй орон нутагт, Салхит уурхайг болон бусад худаг ус, цахилгааны асуудал шийдвэрлэгдэх боломжтой газрыг түшиглэн байгуулна.	Уудам цав ХХК нь 2025 оны 11 дүгээр сарын 02-ноос 2025 оны 11 дүгээр сарын 12-ны хооронд 5 хүний бүрэлдэхүүн Салхит уурхайн бүсэд усалгааны систем нийлүүлж угсрах, суурилуулах, хамгаалалтын ногоон торон хашаа барих ажлуудыг гүйцэтгэсэн. Усалгааны системд шаардлагатай 25 тонны 1 ёмкось 1 ширхэг, 50 мм төмрөн турбо 600 м, 32 мм төмрөн турбо 400 м хоолой, 25-ын гагнадаг хаалт 65 ширхэг, дахин дамжуулах насос 1 ширхэг, Пи хатуу хоолой диаметртэй 25 мм 5000 метрийг уурхайн бүсэд тээвэрлэж, суурилуулж угсарсан. Мөн 800 метр ногоон торон хашаа, дахин дамжуулах носас, 270 ширхэг шон, 10 боодол чансааг уурхайд нийлүүлж барих ажлыг зохион байгуулж хүлээлгэн өгсөн. 
4	Мод үржүүлгийн 5 га талбайг хашаажуулж,	Мод тарьж ургуулахад шаардлагатай усны эх	7 га	19’300’000	Компанийн эзэмшлийн хүлэмжнүүдэд модны суулгац	Салхит уурхайд байгуулсан Эрдэнэс төгөл-ийг өргөтгөж, мод тарих талбайн газрын зөвшөөрлийг авч хашаажуулах ажлыг хийж

	гүний худаг гаргах, Өмнөх онуудад бойжуулсан суулгацыг тарих, хүлэмж барих	үүсвэрийг шийдвэрлэсэн байна.			тарьж	гүйцэтгэсэн. Нийт 2025 онд 20 га талбайг хашаалсан, түүний 7 га талбайд нь тарилтыг хийж гүйцэтгэсэн.
				275,250,000		

БҮЛЭГ 5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Их газрын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны албан хаагчдад байгаль хамгаалах ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авч, нийлүүлэх	Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны албан хаагчдад	6	55,000,000	Тоног төхөөрөмж худалдан авсан байх	Байгаль орчны дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны албан хаагчдад байгаль хамгаалах ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Үүнд: Зөөврийн компьютер 1 ширхэг, нисгэгчгүй дрон 1 ширхэг, шөнийн дуран 3 ширхэг, суурин старлинк 1 ширхэг, зөөврийн цахилгаан нөөцлүүр 1 ширхэг, нарны панелтай хяналтын камер 2 ширхэг
2	Зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулах, хамгаалах ажлын хүрээнд биотехникийн арга хэмжээг зохион	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Их газрын чулуу байгалийн цогцолборт газар	200 боодол	4’000’000	Судалгаа, биотехникийн арга хэмжээг авч ажилласан байна.	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөөнд тусгагдсан Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт нутагшдаг зэрлэг амьтдыг /аргаль, янгир/ идэш тэжээлийн хомсдолоос сэргийлэх биотехникийн арга хэмжээнд зориулан 200 боодол өвсийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгсөн.

	байгуулах					
3	Туруутан амьтны тоо толгойг тогтоох нүүдэл шилжилтийг тодорхойлох, амьтдын тоо толгойн мониторинг явуулах, ажиглалтын зурвас замналын судалгааны ажлыг Их газрын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Их газрын чулуу байгалийн цогцолборт газар	1 удаа	500’000	Туруутан амьтны тооллого судалгааг хамтран зохион байгуулсан байна.	Уулын туруутан амьтдын намрын тооллого судалгааг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны албан хаагчидтай 2025 оны 10-р сарын 17-19-ны өдрүүдэд уулын туруутан амьтдын тооллого, судалгааг хамтран хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнгээр янгир ямаа нь Их газрын чулууны уул, аргаль хонь нь Ерлөг ууланд арай олон тоогоор ажиглагдсан. Сүргийн бүтцийн ашиглалт нь аргаль, янгирын сүргийн бүтцийн эм бодгалийн тоо, залуу бодьгалийн тоо их байгаа нь цаашид өсөх хандлагатай байна. Мөн компаний веб сайтаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласан.

	ажиллах					
4	Өмнөх онуудад сэргээн нутагшуулсан тарваганууудыг ажиглалт судалгаагаар	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Их газрын чулуу байгалийн	1 удаа	500’000	Судалгааг хамтран хийсэн байна.	2019, 2021, 2022, 2024 онуудад нутагшуулсан тарваганууудад ажиглалт судалгааг Их газрын чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагч нартай хамтран 2 удаа хийж гүйцэтгэсэн.

	баталгаажуулах	цогцолборт газар				Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас ирүүлсэн тайлангаар Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын Өлзийт, Дөрвөлжин, Үзүүр хад, Хайрхан баруун тал, Адгийн бунхант, Шар малгайт, Сүвт хонд, Шавгын улаан зэрэг газруудад тарвага нутагладаг. Тарваганы ажиглалт судалгаагаар бие гүйцсэн 151 бодгаль, хотил 8 бодгаль, мөндөл 24 бодгаль, тодорхойгүй 9 бодгаль нийт 192 бодгаль нутаглаж байгааг тогтоож зурагжуулсан. Мөн ажиглалтын камер байршуулж зурагжуулж ажилласан.
5	Дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд Дундговь аймгийн Сайнцагаан сумын Далай багийн нутагт эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайн 3 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Дундговь аймгийн Дэлгэрцогт сум	3 га	50,000,000	Орон нутгийн ажлын хэсгээс 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй тусгах ажлуудын саналд тусгагдсаны дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.	Дундговь аймгийн Сайнцагаан сумын Далай багийн нутаг дэвсгэрт байрлах “Хайрханы ар” нэртэй хууль бусаар ухагдаж эвдрэлд орсон, эзэн холбогдочгүй байгаа талбайд хэрэгжүүлэхийг санал болгосны дагуу 2025 онд 50,000,000 төгрөгөөр Алхими ХХК-аар техникийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж орон нутагт актаар хүлээлгэн өгсөн.

НИЙТ ДҮН				**131’800’000**		

БҮЛЭГ 6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус ордын ашиглалтын лицензийн талбайд үйлдвэрлэлийн болон уурхайн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах (шилжүүлэх) арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй.

БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёл өв олдохыг үгүйсгүй. Тиймээс уурхайн үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн тохиолдолд сум, аймгийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлт
1	Тусгай зөвшөөрлийн талбайд байх Археологийн байгууламжуудыг хөндөж сүйтгэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллах бөгөөд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулна. 2025 онд Салхитын Зүүн эрлийн талбайд хайгуулын ажил хийхээр төлөвлөгдсөн тул тус талбайд хамаарна	Уурхайн орчимд	500 000	Илэрсэн тохиолдолд	Жилийн турш	Уурхайн техник, хүний үйл ажиллагааны нөлөөллийн улмаас анхны зохион байгуулалтаа алдаж устаж үгүй болох эрсдэлээс тогтмол сэргийлж, хяналт тавин ажилласны хүрээнд тохиолдол гараагүй болно. Археологийн судалгааны тайлангийн дагуу Археологийн байгууламжуудыг хөндөж сүйтгэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Геологи хайгуул, ашиглалт, барилг бүтээн байгуулалт, дэд бүтцийг өргөтгөх шинээр байгуулсан ажлуудыг хийж

						гүйцэтгэсэн. Туслган гүйцэтгэгч компаниудын удирдлага, ажилчдад ажил гүйцэтгэхээр ирэх үед нэгдсэн зааварчилгаа, сануулга зэргийг өгч гарын үсгээр баталгаажуулж ажилласан.
Нийт зарцуулсан төсөв			**500’000**			

БҮЛЭГ 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1 Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм	1 болон 2 дугаар баяжуулах үйлдвэрийг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэн орон нутаг болон улсын комисст 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн.
2	Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар		Дундговь аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу хийгдсэн хяналт шалгалтын хүрээнд газардуулгыг шалгасан зөрчил илэрсэн хэсгийг засаж сайжруулах үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаврын дагуу дутагдал арилгах төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хүргүүлсэн.
3	Барилга байгууламжуудийн зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцлүүдийг тусгах, уурхайг үерээс хамгаалсан	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар		Хаягдлын далангуудыг үерээс хамгаалах үерийн далан, суваг барих ажлыг 8 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд барьж 12 дугаар сард хийж гүйцэтгэсэн. Мөн үерийн усыг нөөцлөх цөөрмийг хийсэн.

	далан байгууламжтай болгох				
4	Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Гамшгаас хамгаалах тухай хууль	2025 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2025.09.23-ны өдөоДундговь аймгийн Онцгой байдлын газраар батлуулж ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны журмуудыг компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажилладаг.
5	Гадаргын усны урсацыг өөрчлөх, үерийн далан шуудуу татах, хүмүүст үерийн анхааруулга өгч хүний амь нас, дэд бүтцийг хамгаалах	Уурхайн хэмжээнд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Сургалт зохион байгуулсан байна.	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, Гамшгийн төлөвлөгөө, Аюулын үед ажиллах төлөвлөгөө, Компанийн галын аюулгүй байдлын дүрмийн танилцуулгыг Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн, Галын аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүд нийт ээлжээр ажиллаж буй ажилтнуудад давтамжтайгаар сургалт зохион байгуулж ойлголт мэдээллийг өгч ажилласан.
6	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)	Уурхайн хэмжээнд	500.000	Эрсдэлээс хамгаалсан байна.	Уурхайн ажлуудыг аюулгүй явуулахад шаардлагатай хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой журам, зааварчилгаануудыг ажилтан бүрт танилцуулж, журмын биелэлтэнд тогтмол хяналт тавьж ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хүрээнд компанийн зүгээс нийт ажилчдад хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн ханган ажилласан.
7	Химийн бодисыг зориулалтын агуулахад хадгалах, хамгаалах хэрэгсэл, материалыг	Баяжуулах үйлдвэр, Химийн бодисын	-	Аюултай хог хаягдлуудыг нэг цэгт төвлөрүүлэх,	Аглаг хангайн уулс ХХК нь 2025 онд Баяжуулах №1-р үйлдвэрт 5 нэр төрлийн химийн бодис “Соёолон интернэшнл” ХХК-ийн Баяжуулах №2-р үйлдвэрт 6 нэр төрлийн химийн

	зохих газруудад байрлуулах	агуулах, Лаборатори, Тэсрэх бодисын агуулах		стандартын дагуу хадгалах байрыг тохижуулах ажилд хяналт тавин ажилласан байна.	бодисуудыг технологийн горимын дагуу ангилан, тэмдэгжүүлж ашигласан. Мөн химийн бодисын агуулахад хаягжуулалт, тасалгаа, асгаралтын иж бүрдэл тавьж эмх цэгцтэй хураасан.
8	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах бүх арга хэмжээг авах	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламжууд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Гамшгаас хамгаалах тухай хууль	Галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрлийг 2025 оны 09 дүгээр сарын 23-нд гаргуулсан. Энэ онд 2025 онд галын аюул, гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх сургалтыг нийт 4 удаа зохион байгуулж ажилласан. Шатахуун түгээх станцын байрлал нь уурхайн автозасварын цехийн ойролцоо байрлалд байрладаг бөгөөд галын аюулаас хамгаалах хэрэгслүүдийг шинэчлэн байршуулсан. Гадна зам талбайг тэгшилж стандартын дагуу болгох болон бусад тохижилт сайжруулалт, засварын ажлуудыг тус онд нэмэлтээр хийж гүйцэтгэсэн., Галын аюулгүй байдлыг тусгай зориулалтын хэрэгслийг захиалж бүрдүүлэлт хийж, танхим тохижуулсан. Уг ажлын зардлыг төлөвлөгөөний биелэлтийн тайланд оруулж тооцоогүй болно. Мөн ISO 14001, 45001 нэвтрүүлэхээр ажиллаж байна.
			500’000		

БҮЛЭГ 9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах журмын дагуу хяналт тавин ажиллах	Уурхайн талбайд	Гэрээний зардлаар	Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах журмын дагуу хяналт тавин ажилласан байна.	Хог хаягдлын журмын дагуу туслан гүйцэтгэгч компаниудад тогтмол хяналт тавьж ажилласан. Баяжуулах №1-р үйлдвэрийг хариуцдаг “Аглаг хангайн уулс” ХХК нь 2025 онд “Түмэн эгшиг” ХХК-тай, Баяжуулах №2-р үйлдвэрийг хариуцдаг “Сёолон интернэшнл” ХХК нь “Түмэн эгшиг” ХХК, “Ариун хими” ХХК-тай, Шинжилгээний лабораторын үйл ажиллагааг хариуцдаг “Трү ти ар си” ХХК нь “Элемент” ХХК-тай аюултай хог хаягдал устгах гэрээг байгуулан хууль, стандартын дагуу устгах ажлыг зохион байгуулж ажилласан. 2025 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар Салхит уурхайн үйл ажиллагаанаас 41,178.0 кг аюултай хог хаягдлыг “Түмэн эгшиг” ХХК, “Элемент” ХХК, “Ариун хими” ХХК зэрэг мэргэжлийн байгуулагуудад гэрээний дагуу нийлж устгуулсан. 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргатай Хог хаягдлын гэрээ байгуулсан. Гэрээний дагуу уурхайн хог хаягдлыг 2025 онд 1-р улиралд 9 удаа, 2-р улиралд 2 удаа 3-р улиралд 5 удаа, 4-р улиралд 2 удаа буюу нийт 17 удаа тээвэрлэлт хийж 425 тн хогийг Гурвансайхан сумын хогийн цэгт асгах, зөөн тээвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Тус ажилд Гурвансайхан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч тогтмол хяналт тавьж хамтран ажилласан.
2	Дахин боловсруулах	Уурхайн талбайд	43’950’000	Мэргэжлийн байгууллагад	Баяжуулах №1, №2 дугаар үйлдвэрүүдээс гарч буй химийн бодисын сав баглаа боодол, Химийн лаборатори

	боломжтой болон аюултай хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагуудад хандаж тээвэрлүүлэх ажлыг зохион байгуулах			тушаах ажлыг зохион байгуулж, судалгааг хийсэн байна.	болон бусад үйл ажиллагаанаас гарч буй аюултай хаягдлууд: • Баяжмалын цамц-27,138.0 кг • Бодисын шууддай:1,260.0 кг • Химийн бодисын бочка:84 ш • Лабораторийн аюултай хог хаягдал12,780.0 кг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар Салхит уурхайн үйл ажиллагаанаас 41,178.0 кг аюултай хог хаягдлыг “Түмэн эгшиг” ХХК, “Элемент” ХХК, “Ариун хими” ХХК зэрэг мэргэжлийн байгуулагуудад гэрээний дагуу нийлж устгуулсан. Харин туслан гүйцэтгэгч нийт аж ахуйн нэгж байгууллагуудаас гарсан 24 тн хаягдал ажилласан тос маслыг “Об ойл индастриал” ХХК, 766 ширхэг хаягдал дугуйг дахин боловсруулах үйлдвэр болох “Цүүгэл оюу” ХХК-д шилжүүлсэн.

3	Орон нутаг, сумын удирдлагатай Хог хаягдлын гэрээ байгуулан тогтмол хугацаанд тээвэрлэж байх	Уурхайн талбайд	3’600’000	Хог хаягдлын гэрээ байгуулан тогтмол хугацаанд тээвэрлэсэн байна.	2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргатай Хог хаягдлын гэрээ байгуулсан. Гурвансайхан сумын татварын орлогын дансанд 3,600,000.0 төгрөгийг төвлөрүүлсэн.
4	Энгийн, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж орон нутгийн дахивар авах цэгт тушаах	Уурхайн талбайд	200’000	Орон нутгийн дахивар авах цэгтэй хамтран ажилласан байна.	Дахивар боловсруулах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж орон нутгийн дахивар авах цэгт тушаах ажлын хүрээнд 1120 кг ундаа усны хуванцар савыг төвлөрүүлж, преслэж Дундговь аймагт үйл ажиллагаа явуулдаг “Баялаг төв”-д нийлүүлсэн.

5	Аюултай хог хаягдлын нэгдсэн тооллого зохион байгуулж, бүртгэлжүүлэх	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Тооллого судалгааг хийсэн байна.	Аюултай болон дахин боловсруулах боломжтой хог хаягдлын төвлөрсөн цэгт хуримтлагдсан хог хаягдлын тоо хэмжээ: Хаягдал тос-25тн Хаягдал дугуй-1260 ширхэг Хаягдал төмөр-28тн Байгаль орчны журмуудын хүрээнд үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудын үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлыг хавсралт маягтын дагуу тоон мэдээллийг сар, улирал, бүтэн жилээр гаргаж нэгдсэн тоон мэдээллийг нэгтгэж БОХ маягтын дагуу Дундговь аймгийн Байгаль орчны газарт хуулийн хугацаанд хүргүүлэн ажилладаг.
6	Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулна /үндсэн болон гэрээт, туслан гүйцэтгэгч компаниуд/	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Орчны өнгө үзэмж сайжирч, эмх цэгцтэй болно	Их цэвэрлэгээний хуваарийг уурхайн захирлаар батлуулж туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд хуваарьт талбайн цэвэрлэгээг нийт 44 удаа зохион байгуулсан.

7	Уурхайн ахуйн хог хаягдлыг Гурвансайхан сумын төвлөрсөн хогийн цэг рүү зөөж тээвэрлэх	Гурвансайхан сумын төвлөрсөн хогийн цэгт	9’850’000	Гурвансайхан сумын төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж ажилласан байна.	2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргатай Хог хаягдлын гэрээ байгуулсан. Гэрээний дагуу уурхайн хог хаягдлыг 2025 онд 1-р улиралд 9 удаа, 2-р улиралд 2 удаа 3-р улиралд 5 удаа, 4-р улиралд 2 удаа буюу нийт 17 удаа тээвэрлэлт хийж 425 тн хогийг Гурвансайхан сумын хогийн цэгт асгах, зөөн тээвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Тус ажилд Гурвансайхан сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч тогтмол хяналт тавьж хамтран ажилласан.
8	Уурхайн хогийн цэгээс хог хаягдал салхиар тархахаас сэргийлж хашаажуулах	Уурхайн талбайд	Дотоод үйл ажиллагааны зардлаар		Ахуйн хог хаягдлын цэгийг үерийн уснаас хамгаалсан шуудуу татсан, хөмсөгжүүлэн өндөрлөсөн, өндөрлөсөн хөмсөг нь дээгүүр хог хийсэхээс сэргийлж хашаа татаж, ачиж тээвэрлэхэд хялбар болгож засварласан.
9	Дундговь аймгийн Гурвансайхан сумын хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд болон нийгмийн хариуцлагын хүрээнд 20 ширхэг 3 ангилалтай ангилан ялгах хогийн сав нийлүүлэх	Гурвансайхан суманд	51 200 000		Дундговь аймгийн Гурвансайхан сумын хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Засаг даргын Тамгын газарт ангилан ялгах хогийн савыг хүлээлгэн өгсөн. Тус сумын 20 байршилд ангилан ялгах хогийн савыг байршуулсан бөгөөд дараах ач холбогдолтой. • Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах боломжийг бүрдүүлж, дахин боловсруулах үйл явцыг дэмжинэ. • Орчны бохирдлыг бууруулах, иргэдийн хандлагыг өөрчлөх, тогтвортой хэрэглээг хэвшүүлэх ач холбогдолтой. • Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийн тогтолцоог сайжруулах анхны чухал алхам болж байна.

10	Тусгай хамгаалалттай газраар дайран өнгөрөх зам дагуу болон Салхит уурхайгаас Дэлгэрцогт сум хүртэлх авто замын дагуух хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах	Технологийн зам	Дотоод үйл ажиллагааны зардлаар	Цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан байна.	2025 онд нийт 1 удаагийн их цэвэрлэгээг зохион байгуулж ажилласан.
			108’800’000		

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Эрдэнэс алт ресурс” ХХК хариуцсан. Байгаль орчны хяналт шинжилгээг тус компанийн байгаль орчны мэргэжилтэн хариуцан гүйцэтгэх эсвэл мэргэжлийн байгууллагатай хамтран ажилласан.

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2025 оны орчны хяналт шинжилгээндээ уст 8 цэгт хэмжилт шинжилгээг явуулсан бөгөөд усан хангамжийн гүний худаг, малчны худгаас ерөнхий химийн, бохирдлын шинжилгээг авч итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжилүүлсэн. Энэхүү зардалд 940.0 мян.төг, хөрсөн бүрхэвчийн шинжилгээнд нийт 8 цэгээс хөрсний ерөнхий химийн, 3 цэгээс хүнд метал, 1 цэгээс бактериологийн дээжийг жилд 2 удаа авах бөгөөд нийт 21 ширхэг дээж авч 1050.0 мян.төг, агаарын чанарын хэмжилтийн зардалд нийт тоос, SO, NO зэргийг 3 цэгт хэмжилт хийх зардалд 88.0 мян.төг төлөвлөсөн.

2025 оны Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан судалгаа, шинжилгээ дээжлэлтийн ажлын нээлттэй тендер зарлаж “Нандин байгаль” ХХК шалгарч уг ажлыг хийж гүйцэтгэж, мониторингийн ажлын үр дүнгийн тайлан боловсруулж хүлээлгэн өгсөн. Уг ажилд **44,900,000** төгрөгийг зарцуулсан. /*Тайланг БОМТ-ний хэрэгжилтийн тайлангийн хавсралтад хавсаргав*/

Хүснэгт 1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Агаарын чанар, дуу чимээ						
SO_2 NO_2 Нийт тоос PM_{10} дуу чимээ	6үзүүлэлт*4 байршил	Үйлдвэрийн бутлуурын хэсэг, тээвэрлэлтийн зам, ил уурхайн карьер, хаягдлын далан, шатахуун	Жилд 2 удаа	1 байршил 20 минутын хэмжилт 36.0 мян.төг	**MNS 4585:2007** Агаарын чанар. Техникийн ерөнхий Шаардлага **MNS 3384:1982**	PM2.5- 50 мкг/м^3 24 цаг, 25 мкг/м^3 жил PM10- 100 мкг/м^3

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо	Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		түгээх станц, Аглаг кемп, Сидар кемп, ЭСР кемп		Нийт 4 байршилд жилд 2 удаа 288.0 мян.төг Томилолтын зардал 600.0 мян. төв лабораторийн төг Нийт 888.0 [1]Байгаль орчны хэмжилзүйн лаборатори	Сорьц авахад тавих ерөнхий шаардлага **MNS 4048:1988** Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга **MNS 0017-2-5-11:1988** Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох Фотоколориметрийн арга **MNS 5013:2009** Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга	24 цаг, 50 мкг/м^3 жил SO2-20 мкг/м^3 24 цаг, 10 мкг/м3 жил NO2-40 мкг/м^3 24 цаг, 30 мкг/м3 жил CO-30000мкг/м^3 1 цаг, 1000 мкг/м^3 8 цаг Pb-1 мкг/м3 24 цаг, 0.5 мкг/м3 жил
Усан орчин						
Усны ерөнхий хими, бактерлогийн шинжилгээ(р	107.004 107.004 106.97	45.8703 45.8703 45.878	1, 2, 4-р худаг, 1-р усан сан, 3-р усан сан, хаягдлын далан,	Усны ерөнхий химийн шинжилгээ 46000 төг,	**MNS 4586:1998** Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага	PH-6.5-8.5 NH4-N 0.5 мгN/л, NO2-N 0.2 мгN/л,

[1] Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 05 сарын 06 –ны өдрийн А/164 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Орчны чанарын хяналт шинжилгээний ажил, үйлчилгээний үнэ тариф

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо		Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
H, EC, TDS, нийт шүлтлэг, pH, Cl, SO_4, NO2, NO3, CO3, HCO3) Ахуйн хаягдал усны ерөнхий хими, бактерлогийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, pH, хүнд металлын шинжилгээ (As, U, Pb, W, Th, Sn, Cs, Cd, Nb, Se, Zn, Zr)	5	4	Аглаг кемп, Сидар кемп, Эрдэнэс силвер ресурсын кемп, бохир усны хаягдал, малчны худаг/	Жилд 2 удаа	Цэвэрлэгдсэн бохир усны шинжилгээ 48000 10 цэгт *2 удаа* 94 төг 1,880,0	**MNS 0900:2005** Ундны усны стандарт **MNS (ISO) 4867:1999** Усны чанар. Дээж авах, хадгалах, хамгаалах арга **MNS 3534-83** (Усны шинжилгээнд зориулж дээж авах) Усны анхан шатны тоо бүртгэл хөтлөх журам Усны тоо бүртгэлийн тайлан гаргах журам	NO3-N 9.0 мгN/л, PO4-P 0.1 мгP/л , Cl 300мг/л, F 1.5 мг/л, SO4 100мг/л, Mn 0.1 мг/л, Ni 0.01 мг/л, Cu 0.01 мг/л, Mo 0.25, Cd 0.005 мг/л, Co 0.01 мг/л, Pb 0.01 мг/л, As 0.01 мг/л, Cr 0.05 мг/л, Cr6+ 0.01 мг/л, Zn 0.01 мг/л, Hg 0.1 мг/л, Эрдэс тос 0.05 мг/л, фенол 0.001 мг/л, ГИНБ 0.1 мг/л, Benzo(a) pyren 0.005 мкг/л
	106.987	45.8505					
	106.987	45.8503					
	106.992	45.8473					
	106.986	45.8495					
	107.001	45.8611					
	106.999	45.8716					
	107.001	45.8716					
Хөрсний чанар							
Ялзмаг, pH, давсжилт,	106.987	45.85	\ Үйлдвэрийн урд 2, хаягдлын	Жилд 1 удаа	25.0	**MNS 5850:2008** Хөрс бохирдуулагч бодис,	Хар тугалга (Pb) 100,

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо		Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
P_2O_5, K_2O, Ширхэгийн бүрэлдэхүүн	106.987	45.8489	далангийн урд, баруун, баруун хойно, зүүн, хойно тус бүр 1, колонкын урд 1, 2 дугаар постны баруун урд 1, аглаг кемпийн урд 1, уурхайн зүүн хойно 1 /		25.0*10= 250.0	элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт **MNS5914:2008** Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт **MNS5915:2008** Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал **MNS5917:2008** Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт **MNS5916:2008** Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт, **MNS5918:2008** Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага **MNS5546:2005** Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага	Кадмий (Cd) 3, Мөнгөн ус (Hg) 2, Мишъяк (As) 6, Хром (Cr) 150, Зургаан валентат хром (Cr6+) 4, Цагаан тугалга (Sn) 50, Стронций (Sr) 800, Ванадий (V) 150, Зэс (Cu) 100, Никель (Ni) 150, Кобальт (Co) 50, Цайр (Zn) 300, Молибден (Mo) 5, Селен (Se) 10, Бор (B) 25, Фтор (F) 200, Цианид (Cn) 25 мг/л, Тиофенол, фенол 4, газрын тосны бүтээгдэхүүн 2 мг/кг
Хөрсний биологийн бохирдлын үзүүлэлт	106.99	45.8477					
	106.992	45.8474		Жилд 1 удаа	40.0		
	106.994	45.846			40.0*10=400.0		
Хөрсний хүнд металлын бохирдол (Pb), (Cr), (Zn), (Ni), (Cd), (ГЗХ, БОХЗТЛ)	106.998	45.8473					
	106.997	45.8334					
	106.986	45.8448					
	106.986	45.8494					
	107.003	45.8603					
	107.007	45.8726		Жилд 1 удаа	50.0		
					50.0*10=500.0		

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Дээж авах цэгийн тоо		Дээж авах байршил	Хугацаа ба давтамж	Нэгж өртөг, жилийн нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ургамлан нөмрөг							
Ургамлан нөмрөгийн тархалт, бүрэлдэхүүн, хэвшинж, төрөл зүйлийн бүтцийг тодорхойлох	106.986	45.8449	Тээвэрлэлтийн зам дагуу 1, үйлдвэрийн урд 1, үйлдвэрийн хойно 1, уурхайн өдөр тутмын үйл ажиллагааны замын урд 1, уурхайн хашааны гадна 1 дээж талбай сонгосон.	Жилд 1 удаа	Хээрийн судалгаа, суурин судалгаа	Мод үржүүлгийн талбайд тарималжуулж болох нутгийн унаган ургамлын үрийг түүх	
	106.985	45.8451					
	106.986	45.8453					
	106.995	45.8363					
	106.994	45.8355					
НИЙТ ЗАРДАЛ					**11’394’000**		

БҮЛЭГ 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ		Нийт төсөв	Биелэлт
	Өгсөн зөвлөмж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ		
1	Цөлжилтийг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ан амьтдын амьдрах орчныг сайжруулах, хамгаалах талаар сум орон нутгийн байгууллагуудтай зөвшилцөн төлөвлөж ажиллана.	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан байгаль хамгаалах ажлыг зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан байгаль хамгаалах ажлыг зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн.
2	Дундговь аймгийн Гурвансайхан, Дэлгэрцогт сумдын төвлөрсөн хогийн цэгийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлнэ.	25’200’000	Дундговь аймгийн Гурвансайхан сум болон Дэлгэрцогт сумын төвлөрсөн хогийн цэгийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг “Дорнын байгаль” ХХК-аар гүйцэтгүүлж тайланг нь тус 2 сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.
3	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад уурхайн үйл ажиллагааг цаг үеийн байдалтай уялдуулан орон нутгийн албан ёсны цахим хаягаар танилцуулах	Байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлж буй цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүрт мэдээлэл бэлтгэж цахимаар танилцуулан ажиллана.	100’000	Эрдэнэс алт ресурс ХХК-ийн вэб сайт болон фэйсбүүх пэйж хуудсаараа дамжуулан 2025 онд байгаль орчны чиглэлээр хийгдсэн ажлуудыг тухай бүр сурталчилж ажилласан.

№	Төлөвлөсөн арга хэмжээ		Нийт төсөв	Биелэлт
	Өгсөн зөвлөмж	**Авч хэрэгжүүлэх арга хэмжээ**		
	иргэдийг мэдээллээр сайтар хангах, www.erdenesgold.mn, компанийн пэйж хуудсаар болон орон нутгийн фэйсбүүк группүүдээр дамжуулан			

№	Төлөвлөсөн арга хэмжээ		Нийт төсөв	Биелэлт
	Өгсөн зөвлөмж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ		
4	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайланг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	Байгаль орчны аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг тендер шалгаруулж гүйцэтгүүлнэ.	47 930 000	“Аватар” ХХК-аар 2025 оны 07 дугаар сард газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг гүйцэтгэтгүүлж Газар зохион байгуулалт геодези зурагзүйн ерөнхий газраар батлуулсан. Нийт уурхайн бүсийн 242.66 га талбайг хамруулсан.
			73’200’000	

БҮЛЭГ.12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах зардал, төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
1	Дундговь аймгийн Гурвансайхан сумын Чулуут багийн иргэдийн өдөрлөгт оролцож мэдээлэл хүргэх эсхүл орон нутгийн албан ёсны цахим хаягаар дамжуулан иргэдийг мэдээллээр хангах	100’000	Байгаль орчны хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үйл ажиллагааны танилцуулга мэдээлэл өгөх	Дундговь аймгийн Гурвансайхан сумын зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн цахим хуудсуудаар дамжуулан хийж хэрэгжүүлж буй ажлуудын талаарх мэдээллийг тогтмол хүргүүлж ажилласан. Мөн орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад хүсэлт гаргаж Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хурал зохион байгуулах бүрт оролцож мэдээллээр хангаж ажилласан. Дундговь аймгийн Засаг дарга болон иргэдийн төлөөлөгч нарт үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгч ажилласан
2	Гурвансайхан сумын ЗДТГ, ИТХ, багийн	1’400’000	Уурхай, үйлдвэрлэлийн	Дундговь аймгийн Гурвансайхан сумын зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийн цахим хуудсуудаар дамжуулан хийж

	иргэдийн төлөөллүүдийг уурхайн үйл ажиллагаатай танилцуулах		үйл ажиллагааг газар дээр нь танилцуулах	хэрэгжүүлж буй ажлуудын талаарх мэдээллийг тогтмол хүргүүлж ажилласан. Мөн орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад хүсэлт гаргаж Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хурал зохион байгуулах бүрт оролцож мэдээллээр хангаж ажилласан.
3	Уурхайн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны БОМТ хэрэгжилтийн тайланг ажлын хэсгийн гишүүдэд газар дээр нь танилцуулах	500’000	Уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг газар дээр нь танилцуулах	Дундговь аймгийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нь газар дээр шалгах ажлын хэсэгт танилцуулах ажлын хүрээнд Байгаль орчны газарт 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн.
4	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг орон нутгийн захиргаанд хүргүүлэх, танилцуулах	-	Тайлан боловсруулж, төлөвлөгөөг батлуулсан байна.	Дундговь аймгийн Байгаль орчны газарт 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн.
		2’000’000		

БҮЛЭГ 13. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮГНЭЛТ

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн батлсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Салхитын мөнгө-алтны ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсрууллаа.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож оруулсан.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, усны нөөцөд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг буурулах төлөвлөгөө зэрэг хийх ажлуудыг тусгаж өгсөн.

Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас ирүүлсэн албан бичигт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тодорхой хэмжээ бүхий эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хийлгүүлэх талаар тусгасны дагуу хэрэгжилтийг ханган ажилласан.

Уурхайн явцын болон хаалтын нөхөн сэргээлтийн төлөвлөлт, зураглалыг боловсруулж, 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэсэгт тусгаж 2025 онд Салхит уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан техникийн нөхөн сэргээлтийг 23,8 га талбайд хийж гүйцэтгэсэн бөгөөд 388,380.24 м3 уулын цулыг түрж тэгшилсэн. Салхиты уурхайн хаягдлын овоолго 1, 2-ыг **11^0-16^0** градус налуужуулсан. Явцын техникийн нөхөн сэргээлтийг ажлын “Гранд сити” ХХК хийж гүйцэтгэсэн. Техникийн нөхөн сэргээлтийн ажилд **1,500,000,000** төгрөгийг зарцуулсан.

Харин биологийн нөхөн сэргээлтийн ажлыг Салхит уурхайн 1 дүгээр отволны дээд талын хэсэгт 5 га талбайд нийт 7700 $м^3$ шимт хөрсний дэвсэлтийг ажлыг зохион байгуулсан.

Сайжруулсан алтан харганыг 7 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд суулгацаар 15500, үрээр 20000 ширхэгийг тариалж, усалгаа, арчилгааг хийсэн. 2026 онд суулгацаар 14500, үрээр 30000 тарилт хийхээр төлөвлөсөн.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг Шинэ эхлэл групп ХХК-иар гэрээний дагуу хийж гүйцэтгүүлсэн. Уг ажилд нийт **893,107,000** төгрөг зарцуулсан.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд тус оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Их газрын чулуу байгалийн цогцолборт газарт Зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулах, хамгаалах ажлын хүрээнд биотехникийн арга хэмжээ авахад шаардлагатай өвсийг худалдан авч хүлээлгэн өгөх, цаг үеийн шинж чанартай байгаль хамгаалах, тооллого судалгаа, хүн хүч, машин техникийн туслалцаа үзүүлэх зэрэг ажлуудыг Их газрын хамгаалалтын захиргаатай тухай бүр харилцан тохиролцож хамран зохион байгуулж ажилласан.

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон, нөхөн сэргээлт хийгдэх шаардлагатай газруудын нөхөн сэргээлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилготойгоор орон даяар тодорхой үе шаттайгаар зохион байгуулж нөхөн сэргээлтийн ажлын арга хэмжээний хүрээнд Дундговь аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, хүлээж авах ажлын хэсгийн зүгээс эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх ажлыг “Эрдэнэс алт ресурс” ХХК-д даалгасны дагуу 2025 онд 3 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн орон нутагт актаар хүлээлгэн өгсөн.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Далай багийн нутаг дэвсгэрт байрлах “Хайрханы ар” нэртэй хууль бусаар ухагдаж эвдрэлд орсон, эзэн холбогдочгүй байгаа талбайд хэрэгжүүлэхийг санал болгосны дагуу 2025 онд 50,000,000 төгрөгөөр Алхими ХХК-аар техникийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийж орон нутагт актаар хүлээлгэн өгсөн. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын явцад Дундговь аймгийн Байгаль орчны газар, Сайнцагаан сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Дундговь аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн, Сайнцагаан сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, Далай багийн Засаг дарга, Дэлгэрцогт сумын нутгийн иргэд ажлын үе шат бүр хамтарч хяналт тавин ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилгоор “Эрдэнэс алт ресурс” ХХК нь нийт туслан гүйцэтгэгч компаниудадтайгаа хамтран 2025 оны Хаврын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдээр буюу 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрүүдэд Салхит уурхайн “Эрдэнэс төгөл”-д 41000 ширхэг хайлаас мод, Намрын бүх нийтээр мод тарих үндэсний өдрүүдэд 3,3000 ширхэг хайлаас модыг тус тус Салхит уурхайн “Эрдэнэс төгөл” болон №1-р постны урд тарьсан. 2025 онд нийт жилийн эцсийн байдлаар 74000 ширхэг хайлаас модыг тарьсан.

Хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдлыг тусад нь хадгалах зэрэг үйл ажиллагаанууд хэрэгжүүлэх шаардлагатай. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог

хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар баталсан хог хаягдлыг ангилан ялгах менежментэд хэвшүүлэх ажилчдад хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдал, ахуйн хаягдлыг мэргэжлийн компанитай гэрээ байгуулан, тээвэрлэж устгах ажлыг компанийн хог хаягдал, байгаль орчны бусад журмуудын дагуу зохион байгуулж ажилласан.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Эрдэнэс алт ресурс” ХХК нь зохион байгуулж ажилласан.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **195,878,000** төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож **97,939,000** төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтанд зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулж ажилласан.

“Салхитын мөнгө алтны орд” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж тайлагнасан бөгөөд Дундговь аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тайлагнаж ... **%-**ийн үнэлгээтэйгээр дүгнэгдсэн.

Салхитын мөнгө-алтны ордын олборлолт, уулын баяжуулах үйлдвэр, геологи эрэл хайгуулын ажил болон бусад үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойшхи хугацаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2025 оны Байгаль орчныг хамгаалах ажилд **3’159’777’000** төгрөгийг зарцуулсан байна.

БҮЛЭГ 14. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН ЗАРДЛЫН ЗАДАРГАА ХҮСНЭГТ

№	ЗАРДЛЫН УТГА	НИЙТ ЗАРДАЛ, ТӨГ
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	129’720’000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний ажлын зардал	2’393’107’000
	Нөхөн сэргээлт, Ногоон байгууламж, Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	275’250’000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	131’800’000
4	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	500’000

5	Осол эрдслийн менежментийн төлөвлөгөөний зардал	500’000
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	108’800’000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	44’900’000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний ажлын зардал	73’200’000
9	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал	2’000’000
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		**3’159’777’000**

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төсвийн задаргаа

№	Үйл ажиллагааны төрөл	Дүн(Төгрөг)
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	106’000’000
2	Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	1’720’000
3	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	500’000
4	Ургамлын аймаг, ургамлан нөмрөг үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	1’000’000
5	Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн зардал	20’500’000
НИЙТ ЗАРДАЛ		**129’720’000**

---oOo---

“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “САЛХИТ МӨНГӨ-АЛТНЫ ОРД”-ЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Хянасан огноо	
Хянасан мэргэжилтний хувийн дугаар	
Дүгнэлт	
Шийдвэрийн төсөл	
Ололт, амжилттай тал	
Дутагдалтай сул тал	
Шаардлага	

НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг *“хамааралгүй”* гэж бөглөнө.
- 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	Эрдэнэс алт ресурс ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	Гэрчилгээний дугаар:000156316 Хувийн хэргийн дугаар: 9011734009

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Бизнесийн зөвөлгөө
	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 17 “Блю Скай тауэр” 607 тоот
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Гүйцэтгэх захирал Э.Уганбаяр, утас: 75351111 www.info@erdenesgold.mn
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Байгаль орчны мэргэжилтэн Г.Анх-Амгалан утас: 89008524 цахим шуудангийн хаяг: ankh-amgalan.g@erdenesgold.mn Байгаль орчны мэргэжилтэн Ш.Намсрайжав утас: 88080733 цахим шуудангийн хаяг: namsraijav.sh@erdenesgold.mn
1.2	1. Төслийн нэр	Салхитын Мөнгө-Алтны орд
	2. Төслийн харъяаллын байршил	Дундговь аймгийн Гурвансайхан сум, Чулуут баг, Салхитын мөнгө-алтны уурхай
	3. Төслийн ангилал	Уул уурхай
	а. нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт	Мөнгө, алт
	б. ил уурхай, далд уурхай, шороон орд	Ил уурхай
	в. баяжуулах үйлдвэр	Баяжуулах үйлдвэр
	4. Төсөл эхэлсэн огноо	2019 он
	5. Төсөл хэрэгжих хугацаа	5 жил /цаашид хугацаа сунгагдана/
	6. Уурхайн хаалт эхлэх огноо	Тодорхойгүй
	7. Хаалтын дараах зориулалт	Бэлчээрийн зориулалтаар

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

	8. ТЭЗҮ баталсан огноо	Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 074 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын орд ашиглалтын Техник-Эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) хүлээн авах журам, Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаал 2025 оны 06 дугаар сарын 23
	9. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	Баяжуулах 1 дүгээр үйлдвэр нь 2020.05.01-ээс, 2 дугаар үйлдвэр нь 2022.09.01-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 1, 2 үйлдвэр 505,350.51 тн хүдэр, 8,060.04 тн тн баяжмал үйлдвэрлэсэн.
	10. Ажилчдын тоо	145
	11. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	-
	12. Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	-
	13. Замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл	-
	14. Шатахуун түгээгүүрийн тоо	2 хошуу бүхий 1 түгээгүүртэй
	15. Шатахууны агуулахын агууламжийн хэмжээ	50 тонны /м^3/ багтаамжтай 2 ширхэг хэвтээ савтай нийт 100 тонн багтаамжтай.
	16. Тэслэх, дэлбэлэх бодисын агуулахын хүчин чадал гэх мэт	Тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийн агуулах нь нийт 8 контейнертэй. 40 тонн багтаамжтай 7 контейнер 20 тн багтаамжтай 1 контейнертэй.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

· Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

· Тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын нөөц, ТЭЗҮ баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах

· Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах баганад хавсралтын нэрийг оруулах

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/ Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	Ашигт малтмалын ашиглалт MV-021483 2049.10.17 2887.85 га
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/ Дугаар Хүчинтэй хугацаа	Импортлох, ашиглах 0001670 2023.12.24-2027.12.31
	3. Химийн бодисын агуулахад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	Дундговь аймгийн мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагчийн 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 13-04-023/77 тоот дүгнэлт
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	Галын аюулын дүгнэлт, зөвшөөрлийг 2025 оны 09 дүгээр сарын 23-нд гаргуулсан. 2026 оны 09 дүгээр сарын 23-нд дуусна. Дундговь аймгийн Онцгой байдлын газар
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр 13/4913, Байгаль орчин, аялал жуулчлалын яам
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2022 оны 12 дугаар сарын 05-ний өдөр, Байгаль орчин, аялал жуулчлалын яам
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	Усны газар 2025.01.13
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	2025 оны 02 дугаар 10 өдөр

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

	9. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтыг хавсаргах			Хавсаргав:
	10. Нөхөн сэргээлт	Төлөвлөгдсөн. Төлөвлөгдсөн.	тайлант онд гүйцэтгэсэн	Салхитын уурхай лицензийн талбайд 23,8 га, Сайнцагаан сум, Хайрханы ар гэх газарт 3 га нийт 26.8 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн.
			төлөвлөгөөт онд гүйцэтгэх	
	11. ТХГН-ын тухай хууль, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар тогтоосон хамгаалалтын бүсийн хилийн заагтай давахцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах			www.eic.mn –ээс Кадастрын лавлагааг цахимаар татан авч хавсаргав.

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрын А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтанд тусгагдсанг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах
- Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/
- Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт **“хангалттай”** гэсэн дүгнэлтийг оруулна.
  - урьдчилан сэргийлэх арга хэмжээ
  - эрсдлийн үед авах арга хэмжээ
  - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ
  - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	Нийт 7 төрлийн химийн бодис ашигладаг. -Натрийн бутил ксантогенат - Натрийн карбонат -Нарсны тос -Аммонийн дибутил дитиофосфат -Зэсийн сульфат - Флокулянт-полиакриламид -Шохой
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө - урьдчилан сэргийлэх арга хэмжээ - эрсдлийн үед авах арга хэмжээ - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ	-
3.2	1. Шатах тослох материалын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр төрөл, хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Дизелийн түлшний 50 тонны / м3/ багтаамжтай хэвтээ 2 ширхэг савтай нийт 100 тонн багтаамжтай зөөврийн ШТС-тай. Тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийн агуулах нь нийт 8 контейнертэй. 40 тонн багтаамжтай 7 ширхэг контейнер, 20 тн багтаамжтай 1 ширхэг контейнертай. 2025 онд нийт 2 төрлийн 475,9 тн тэсрэх бодис ашигласан. Үүнд: Анфо-276,7 тн, Эмульс-199,2 тн Үлдэгдэл: байхгүй
3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж тонн/ · Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ · Дахин ашиглагдах хог хаягдал	- 425 тонн 24 тонн тос, 766 дугуй 41,2 тонн

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

	· Аюултай, хортой хог хаягдал	
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн тухайн жилийн арга хэмжээнд зарцуулсан зардал	108’800’000 төгрөг

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ТУХАЙН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЙИН ТАЙЛАНГИЙН ДАГУУ ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ

- Доорх хүснэгтийн 4.12 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хэсэг
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	**Нийт төсөв- 3’159’777’000 төг**
	2. Сөрөг өлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	**129’720’000**
	3. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	2’393’107’000
	4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	131’800’000
	5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	2’000’000
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	73’200’000
	7. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	500’000
	8. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	44’900’000

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

	9. Осол эрдслийн менежментийн төлөвлөгөө	500’000
	10. Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	108’800’000
	11. Ногоон байгууламж, Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	275’250’000

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.
- Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

№	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах хэсэг
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	Тосгон	
	Хог хаягдлын цэгийн байршил	
	Аюултай хог хаягдлын агуулахын байршил	
	Хаягдлын далан	
	Химийн бодисын агуулахын байршил	
	Орчны хяналт шинжилгээний дээж авах	
	Хяналтын цэгийн байршил	
	Тухайн жилд хуулах хөрс	
	Гадаад, дотоод овоолго	
	Техникийн нөхөн сэргээлтийн талбай	
	Биологийн нөхөн сэргээлтийн талбай	
	Гүний худгийн байршил	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

	Дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил	

ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь багананд **“тодорхойлсон”**, **“тодорхойлоогүй” “хамааралгүй”** гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөл-лийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г.Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
6. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл · Бохирдуулах · Эвдэх · Доройтуулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл · Бохирдуулах · Нөөцийг бууруулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

6. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл · амьдрах орчинг хуваах · амьдрах орчинг дороЙтуулах · амьдрах орчинг хомсдуулах · нөөцийг бууруулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6. Агаарт үзүүлэх нөлөөлөл · Бохирдуулах · тоос	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
6. Түүх соёлын дурсгалт эд зүйлс · Хамгаалах · Нүүлгэн шилжүүлэх	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	

ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн **“А”** багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн **“Б”, “В”,** багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд **“тийм”, “үгүй”** хариулт өгнө.
- Доорх хүснэгтийн **“Г”** багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтэнгүүд **“хангалттай” “хангалтгүй”** гэсэн дүгнэлт өгнө.

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г.Дүгнэлт
7. Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлуулах арга хэмжээ	5	Тийм	Тийм	
7. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	5	Тийм	Тийм	
7. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ · техникийн/ га эзэлхүүн · биологийн /га	1	Тийм	Тийм	
7. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	6	Тийм	Тийм	
7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	4	Тийм	Тийм	
7. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	
7. Байгаль орчны менежментинй удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	5	Тийм	Тийм	

НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

- Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг **“А, Б, В, Г”** баганад байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж (удаа)	Г. Төсөв (төг)

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

1. Хөрс	10	Үйлдвэрийн урд 2, хаягдлын далангийн урд, баруун, баруун хойно, зүүн, хойно тус бүр 1, колонкын урд 1, 2 дугаар постны баруун урд 1, аглаг кемпийн урд 1, уурхайн зүүн хойно 1 /	3	-
2. Ус	10	Шүүрлийн ус, хаягдлын далан, малчны өрөмдлөг худаг, кемпийн ундны ус, ажирхай, 1, 2, 4-р худаг, 1-р усан сан, 3-р усан сан, хаягдлын далан, Аглаг кемп, Уулын кемп, Эрдэнэс силвер ресурсын кемп, бохир усны хаягдал, , карьер/	4	-
3. Амьтан	4	Орчны бүсийн Их газрын чулууны БЦГ-т 4 цэг сонгосон. /Ерлөгийн уулын хойно 1, урд 1, Ёрвон хайрхан 1, Баян ууланд 1 замналын дээж талбай сонгосон/	2	-

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

4. Ургамал	5	Тээвэрлэлтийн зам дагуу 1, үйлдвэрийн урд 1, үйлдвэрийн хойно 1, уурхайн өдөр тутмын үйл ажиллагааны замын урд 1, уурхайн хашааны гадна 1 дээж талбаы сонгосон.	2	-
5. Агаар	1	Үйлдвэрийн бутлуурын хэсэг, тээвэрлэлтийн зам, оффис орчим хаягдлын далан, шатахуун түгээх станц, Аглаг кемп, уулын кемп, ЭСР кемп	1	-
				-

-0-

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг /...../
огноо /..... он .... сар .. өдөр /

МОНГОЛ УЛС

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000156316

2018.03.23	9011734009
/ Бүртгэсэн он,сар,өдөр /	/ Хувийн хэрэгийн дугаар /
	6289754
	/ Регистрийн дугаар /

Эрдэнэс алт ресурс — Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, харьяалагдах хэлбэр /

Дүрэм

/ Үүсэн байгуулах баримт бичиг /

Тогтоол	6	2018.03.13
/ шийдвэрийн нэр /	/ дугаар /	/ он, сар, өдөр /

8299	Бизнесийн зөвлөгөө
/ код /	/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код / — / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй	1	100,000.0
/ хугацаа /	/ ширүүдийн тоо /	/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Чингисийн эрэн чөлөө, 15-р байрлалд, 15 давхарт, Утас1: 0, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, үлсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Сумъяа овогтой Эрдэнэбулган-д Гүйцэтгэх захирлын үүрэгийг түр орлон гүйцэтгэгч-р томилсныг бүртгэв.	2018.03.23	Б.Пүрэвсүрэн
1	Дорж овогтой Ариунболд -д Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.05.03	Б.Пүрэвсүрэн
	2 . Дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэв.	2018.07.09	Ж.Намдорж
3	Болдбаатар овогтой Ачитсайхан -д Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.03.05	Г.Алтай
4	Дүрмийн 1.2, 5.1, 6.1, 7.2, 7.3.1, 7.3.5, 7.3.7, 7.3.9, 7.3.12, 7.3.13, 11.1, 11.2, -т оруулсан өөрчлөлтийг бүртгэв.	2022.11.28	Ш.Очирсүрэн
5	Дүрмийн 5.1 заал-т оруулсан өөрчлөлтийг бүртгэв.	2023.01.09	Ш.Очирсүрэн
6	Шинэчилсэн дүрэм бүртгэв.	2023.05.22	С.Баясандулам
7	Эрдэнэчулуун овогтой Уганбаяр-г Гүйцэтгэх захирлын үүрэгийг түр орлон гүйцэтгэгч-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2023.10.18	С.Баясандулам
12	08900 Улс төрийн талбайд хүний завсан нөхцөл, шаардлагын дагуу мэдээг мэдээлэл ашиглах, олж олох /2023.11.03-2049.10.17/ үйл ажиллагаа шинээр бүртгэв. 09909 Гэрээгээр өөрийлөг хийх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 09900 Үүл үүрхайн чиглэлээр зөвлөгөө өгөх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2023.11.06	Ш.Очирсүрэн
13	09901 Мэдээг мэдээллийн хадгалуул /2023.08.27-2024.08.27/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2023.11.03	Ш.Очирсүрэн
14	Эрдэнэчулуун овогтой Уганбаяр-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2024.08.08	Г.Хишигжаргал

МОНГОЛ УЛС

.... он 12 сар 11 өдөр Бүртгэлийн № 1143

Нийслэлийн тойргийн нотариатч

Д.Амаржаргал би энэ хуулбарын

үнэн зөвийг гэрчлэв.

Нотариатч .....

САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЛИЙГ АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 он

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС

САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЛИЙГ АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021483

Регистерийн дугаар: 6289754

ХЯНАСАН:

САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЗАХИРАЛ — Ч.БОЛДБААТАР

САЛХИТ УУЛЫН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН АХЛАХ ИНЖЕНЕР — О.ЯНДАГ

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН — Ш.НАМСРАЙЖАВ

2025 оны 11 сарын 01

“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЛИЙГ АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.11.01 Салхит уурхай

№	Үл нийцэл болон авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд	Гүйцэтгэх хугацаа	Хүрэх үр дүн	Төлөвлөгөөний биелэлт	Биелэлтийн хувь
ХУУЛИЙН ЕРӨНХИЙ НИЙЦЭЛ					
1	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажилд нэмэлт тодотгол хийлгэх	2025 оны 2, 3 дугаар улиралд	Мэргэжлийн компаниар газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажилд нэмэлт тодотгол хийлгүүлсэн байна.	Аватар ХХК-аар 2025 оны 07 дугаар сарын 25-нд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг гүйцэтгэтгүүлж Газар зохион байгуулалт геодези зурагзүйн ерөнхий газраар батлуулсан. Нийт уурхайн бүсийн 242.66 га талбайг хамруулсан.	100%
2	Орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулж, жил бүр гэрээг дүгнэж акт үйлдэж явах	2024, 2025 онд	Орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулж, жил бүр гэрээг дүгнэж акт үйлдсэн байна.	2024 оны орон нутагтай хамтран ажиллах гэрээг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр дүгнэж, акт үйлдсэн. 2025 оны хамтран ажиллах гэрээг 2025 оны 03 сарын 12-нд орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулж хэрэгжилтийг 100% ханган ажилласан.	100%
УСНЫ НӨӨЦ, ЧАНАР					
3	Хүчинтэй хугацаа дуусгавар болсон усны тоолуур баталгаажуулалтын гэрчилгээнүүдийг сунгуулах	Жилийн турш	Тоолуурын бүртгэл судалгааг хийж, хугацаа дууссан гэрчилгээнүүдийг	2024 оны 4 дүгээр улиралд Салхит уурхайн худаг, усан сангуудыг бүрэн тоолууржуулах ажлын хүрээнд тооллого, бүртгэл судалгаа хийсэн. Тус судалгаагаар нийт 11 усан сан, 16 худаг байдгаас	100%

				8 усан сан тоолууртай, 3 нь тоолуургүй, 14 худаг тоолууртай, 2 худаг тоолуургүй гэж бүртгэгдсэн. 2025 онд дутуу, хугацаа дууссан худгуудыг шинээр тоолууржуулж гэрчилгээжүүлж дууссан.	
4	Уурхайн төв кемпийн ахуйн хэрэглээний усны эх үүсвэрийн орчмын 50 м бүс дотор буй бохирдуулагч эх үүсвэрүүдийн (уурын зуухны үнсний сан, кемпийн саарал усны сан, уулын хүн машин механизмын зогсоол) байршлыг нүүлгэн шилжүүлэх	Жилийн турш	Усны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Уурхайн төв кемпийн хашаанд ажилчдын кемп байгуулан ажиллаж байсан туслан гүйцэтгэгч “Сидар” ХХК-ийн ажилчдын кемпийг буулгаж, ашиглагдахгүй техник, хэрэгслийг зориулалтын зогсоолын талбайд байрлуулах шаардлага тавьж байршлыг шилжүүлсэн. Халаалтын уурын зуух болон ахуйн бохир усны хаягдлын сан зэргийг байршлыг нь өөрчлүүлэхээр төсвийн төсөлд тусгаж шийдвэрлүүлэхээр болсон. Үүнтэй холбогдуулан уурын зуухны үнсний санг ахуйн хог хаягдлын цэгийн хажууд зориулалтын талбайг бэлтгэн худаг усан санд дулаалга хийх зорилгоор байршуулан ажилласан.	90%
5	Ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийн ажиллагааг сайжруулж саарал усны найрлагыг MNS 4943 : 2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартын шаардлагад нийцүүлсний дараа хөрсөнд зайлуулах	Жилийн турш	MNS 4943 : 2015 стандартыг мөрдөж, стандартын шаардлагад нийцүүлсний дараа хөрсөнд зайлуулах арга хэмжээг авч ажилласан байна.	2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн цэвэр болон бохир усны шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангахгүй байгаа талаар дүгнэлт тайлан ирсэн тул уг дүгнэлтийн дагуу арга хэмжээг яаралтай авч ажиллах талаар чиглэл өгч ажилласан. Тус ажлын хүрээнд цэвэрлэх байгууламж дээр хлоржуулах төхөөрөмж, вакум насос, элсэн филдерийг хэвийн ажиллагаанд оруулсан. Цөөрөм хүртэл саарал усыг стандартад нийцүүлэн хаядаг болсон. Цөөрмийн саарал усыг 2025 онд эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсаны үндсэн дээр бохир соруулах ажлыг 7 удаа гүйцэтгүүлсэн. Цаашид цөөрмийн их	100%

				засварыг 2026 онд хийхээр худалдан авах ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.	
6	Флотацийн эргэлтийн усан сангийн шүүрэл нэвчилтийг хянах хаягдлын сангийн үзлэгийн хуудас хөтөлж явах	Байнга мөрдөх	Үзлэгийн хуудасыг хөтлүүлж, хяналт тавьж ажилласан байна.	1 дүгээр үйлдвэрийн 3 дугаар эргэлтийн усан сан нь төмрөн доторлогоотой, 2 үйлдвэрийн эргэлтийн усан сан нь бүрэн цутгамал тул нэвчилт үүсэх боломжгүй байдаг. Хаягдлын сангийн үзлэгийн хуудсыг тогтмол хөтөлсөн. Цаашид шүүрэл нэвчилт хянах зорилгоор эргэлтийн усан санд хяналтын цооногтой болох судалгааг хийхээр төлөвлөсөн.	100%
7	Баяжуулах үйлдвэрийн шингэн хаягдлын далангийн шүүрэлт, нэвчилт явагдаж буй эсэхийг хянах хяналт тавих	Жилийн турш	Хяналт мониторингийн цооногуудын аюулгүй ажиллагаанд байнгийн хяналт хийж ажилласан байна.	2022 онд Энх өрнөл ХХК нь байгаль орчны цооног 3 ширхэг, хяналтын цооног 2 ширхэг, 2023 онд PSST компани 4 хяналтын цооног, 2024 оны хаягдлын далангийн өргөтлийн ажлын хүрээнд дахин 4 хяналтын цооног өрөмдүүлж, тоноглуулсан. Мөн 2015 онд гарсан байгаль орчны 2 цоонгоос Нандин байгаль ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу улирал бүр дээж авахуулж итгэмжлэгдсэн лабораторт хүнд металын шинжилгээг хийлгүүлж ажилласан. Шинжилгээгээр нэвчилт, шүүрэлт явагдаагүй гэж үзсэн. Соёолон интернэшнл ХХК, Аглаг хангайн уулс ХХК-уудад хаягдлын далангийн хяналтын бүртгэлийг тогтмол хөтлүүлж, хяналтыг тогтмол тавьж ажилласан.	100%
8	Ахуйн бохирыг цэвэршүүлсний дараа үүсч буй саарал усны сангийн байгууламжийн байршлыг өөрчилж сайжруулах	2025	Цэвэрлэх байгууламжийн хадгалах сангийн байгууламжийг шинэчилж засвар	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж буй “Дулаан сэнтий” ХХК туслан гүйцэтгэгч компанид цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг хэвийн явуулах, дутагдал зөрчлийг арилгах, засвар үйлчилгээ,	

			үйлчилгээг хийж ажилласан байна.	шаардлагатай материал, хэрэгслийг бэлэн байлгаж стандартын дагуу үйл ажиллагаа явуулах талаар албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Дулаан сэнтий ХХК нь цэвэрлэх байгууламжтай холбоотой мэргэжлийн байгууллагад хандаж цэвэрлэх байгууламжийг стандартын дагуу засварлаж сайжруулах талаар зөвлөмж авч, шаардлагатай зардлыг тодорхойлуулах ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Мөн бага хэмжээний засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Цаашид цөөрмийн их засварыг 2026 онд хийхээр худалдан авах ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.	
9	Унд ахуйд хэрэглэж буй усны шинжилгээний дүнгээр олон удаагийн давтамжтай натри, кали тогтмол өндөр илэрч стандартаар зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрч байвал шүүгчийг сайжруулах эсхүл солих	2024, 2025	Унд ахуйн стандартаас зөвшөөрсөн хэмжээнээс хэтэрч байвал шүүгчийг сайжруулах эсхүл солих ажлыг зохион байгуулж ажилласан байна.	2024, 2025 онуудын орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг “Нандин байгаль” ХХК-тай гэрээ байгуулсаны үндсэн дээр улирал бүр усны дээжийг итгэмжлэгдсэн лабораторт хүргүүлж шинжлүүлсэн. Уг шинжилгээний үр дүнгээр ахуйн усны стандарт шаардлагад нийцэлтэй гарсан.	100%
ХӨРС ХАМГААЛАЛ, ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ					
10	Тос, шатахуунаар бохирдсон хөрсийг хуулж тусгаарлах материал дэвсэж засаж тохижуулсан талбайд хадгалах боломжтой тохиолдолд	Жилийн турш	Төвлөрсөн хогийн цэгт тос, шатахуунаар бохирдсон хөрсийг хадгалах	2024 онд хаягдал тоснуудыг цэгцлэх ажлын хүрээнд нийт туслан компаниас гарсан тосны хаягдлуудыг 25 тонны ёмкосьт юүлэх ажлыг Сидар ХХК, Аглаг хангайн уулс ХХК, Соёолон интернэшнл ХХК-тай хамтран төвлөрүүлж, тооллого судалгаа хийсэн. Мөн аюултай хог хаягдлын цэгийг тохижуулах ажлын хүрээнд Аз	100%

	биологийн аргаар боловсруулалт хийх		зориулалтын талбай бэлдэх	металь ХХК нь 10х20 харьцаатай цутгамал талбай, 25 тонны ёмкос, 2 пресслэгч машиныг хүлээн өгсөн. 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдөр “Об ойл индастриал” ХХК нь гэрээний дагуу 24 тонн тосыг уурхайн бүсээс өөрсдийн үйлдвэр рүү зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэж тусгай зөвшөөрлийнхөө дагуу устгах ажлыг зохион байгуулж хамтран ажилласан.	
АГААРЫН ЧАНАР, ФИЗИК НӨЛӨӨЛӨЛ					
11	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий шийдэл ашиглах талаар төлөвлөн хэрэгжүүлж явах	Жилийн турш	Тус ажлын хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Уурхайн зам талбайн гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчээр шийдсэн. Цаашид сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий оновчтой шийдлийг нэвтрүүлэх, нарийвчилсан судалгааг хийхээр төлөвлөсөн.	50%
ХОГ ХАЯГДАЛ, ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТ					
12	Ахуйн хог хаягдлын цэгийг хог хаягдал салхиар тархахаас сэргийлсэн, хур тунадасны ус хуримтлагдахаас сэргийлсэн хийцтэй болгох	2025	Хур бороогоор угаагдах болон салхинд хийсч орчныг бохирдуулах нөхцлийг хязгаарлах төмөр хийц бүхий хогийн цэгийг байгуулсан байна.	Ахуйн хог хаягдлын цэгийг үерийн уснаас хамгаалсан шуудуу татсан, хөмсөгжүүлэн өндөрлөсөн, өндөрлөсөн хөмсөг нь дээгүүр хог хийсхээс сэргийлж хашаа татаж, ачиж тээвэрлэхэд хялбар болгож засварласан.	100%

13	Ажилласан тосыг хүлээн авагч байгууллагад шилжүүлэхийн өмнө түр хадгалах цэгт хур тунадасны ус, хөрс шороотой холилдохгүй нөхцөлд битүү саванд хийж хадгалах	2024, 2025	Зөвлөмжийн дагуу хуримтлагдсан ажилласан тос, техникийн шингэнийг тусгай зориулалтын талбайд зөөвөрлөн шилжүүлэн хурааж, улмаар хоёрдогч байгууллагад тушаах ажлыг зохион байгуулж ажилласан байна.	Хог хаягдлын менежментийн хэсэгт тусгагдсаны дагуу тендер зарлаж “Аз металл” ХХК-иар 200 метр квадрат талбайг бетонжуулж хаягдал тос хаях цэгийг хөрсөнд нэвчихээс сэргийлж ажилласан. 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдөр “Об ойл индастриал” ХХК нь гэрээний дагуу 24 тонн тосыг уурхайн бүсээс өөрсдийн үйлдвэр рүү зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэж тусгай зөвшөөрлийнхөө дагуу устгах ажлыг зохион байгуулж хамтран ажилласан.	100%
3.6. Талууд устгуулахаар шилжүүлсэн аюултай хаягдлын тоо хэмжээ, нэр төрлийг Хавсралт №1-аар баталгаажуулах бөгөөд тус баталгаажуулсан баримт, Хүлээн авагч талын нэхэмжлэхийг үндэслэн гэрээний төлбөрийг ажлын 10 хоногийн дотор Хүлээн авагчид шилжүүлнэ.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:

4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг Хүлээн авагчаас шаардах эрхтэй.

4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.4.1-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгнө.

4.1.3 Үүсгэгч нь аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, Тээвэрлэгчид 1 хувь, Хүлээн авагчид 2 хувийг илгээж, Хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.

4.1.4 Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.

4.1.5 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг Хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ.

4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг

4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.1-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах эрхтэй.

4.2.2 Хүлээн авагч нь худалдан борлуулсан химийн хорт болон аюултай бодисоос үүдэлтэй хог хаягдлыг өөртөө шилжүүлэн авч, устгах, хадгалах, дахин боловсруулах ажлыг гүйцэтгэх, химийн бодисын хог хаягдалтай холбоотой аливаа асуудлаас үүсгэгчийг ангид байлгах үүрэгтэй.

4.2.3 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг Үүсгэгчид гаргаж өгнө.

4.2.4 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг шилжүүлэн авсанаас хойш түүний хадгалалт, дахин боловсруулалт, устгал зэргийг бүрэн хариуцна.

4.2.5 Үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

ТАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН АВАХ

5.1. Үүсгэгч аюултай хог хаягдлын мэдээллийг 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэн аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй.

Үүсгэгч тал: .....

Хүлээн авагч тал: .....

5.2. Хүлээн авагч нь аюултай хог хаягдлаа "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлэн хүлээн авна.

5.3. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж Хүлээн авагч тал хүлээн авна.

5.4. Аюултай хог хаягдлыг ачиж зөөх зардал, аюулгүй байдлыг Үүсгэгч тал хариуцна.

ЗУРГАА. ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖИХ

6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.

6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг Хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх Хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.

6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний эрсдэл Үүсгэгчид байх ба Хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр эрсдэл Хүлээн авагчид шилжинэ.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан алдаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.

7.2. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.3-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэлт болон хадгалалтын зардал, учирсан хохирлыг Үүсгэгчид төлнө.

7.3. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг Иргэний хууль болон энэ гэрээнд заасан журмын дагуу зохицуулна.

7.4. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт №1-д заасан тоо хэмжээ, аюултай хаягдлын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

7.5. Энэхүү гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1. Талуудын аль нэг нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Дээрх нөхцөл байдал болон түүний үр дагавар арилмагц үүргээ нэн даруй гүйцэтгэнэ. Тус нөхцөл байдалтай холбоотойгоор гэрээний хугацаанд өөрчлөлт орохоор бол хоёр тал харилцан тохиролцоно.

8.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас энэхүү гэрээ саатсан буюу хэрэгжих боломжгүй талаар хүсэлт гаргасан тал нь нотолсон тохиолдолд гэрээний нөгөө тал тус хугацааны алданги, торгууль нэмэлт үүргээс чөлөөлөгдөнө.

8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг Үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг Хүлээн авагч хариуцна.

Үүсгэгч тал: .....

Хүлээн авагч тал: .....

ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, талууд тус бүр 1 хувийг хадгална. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд зөвхөн бичгээр оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл гэх зэргээр гэрээтэй холбоотой гаргаж буй аливаа мэдэгдэл, албан бичиг, санал, хүсэлтийг зөвхөн бичгээр баталгаажуулах ба талуудын албан ёсны хаягаар бичгээр, шуудангаар эсвэл албан ёсны электрон хаягаар хүргүүлнэ.

9.4. Талууд гэрээтэй холбогдон гарсан аливаа асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
Дэд захирал

.....
Д.БАТБАЯР

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

.....
Б.ОДБАЯР

ИНЖЕНЕР
ТЕХНИКИЙН АЛБА

Үүсгэгч тал: .....

Хүлээн авагч тал: .....

"Аглаг Хангайн Уулс" ХХК. болон "Түмэн эгшиг" ХХК-ийн хооронд байгуулсан 2025 оны 02 дугаар сарын 01 -ны өдрийн ..... тоот Ашуултай хог хаягдал шилжүүлэх гэрээний Хавсралт №1

Ашуултай хог хаягдлын нэгж үнэ

№	Ашуултай хаягдлын төрөл	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нэгж үнэ /НӨАТ/
1	Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр/0,5л, 1л, 2л, 5л, 10л, 25л	тн	1	1,150,000	1,265,000
2	Химийн хуванцар торх / 100л/	ш	1	4,800	5,280
3	Химийн хуванцар торх /200л/	ш	1	7,900	8,690
4	Химийн хуванцар IBC танк /1000л/	ш	1	28,000	30,800
5	Гялгар уут, шуудай, /25кг, 50кг, 1тн big bag шуудай/	тн	1	1,250,000	1,375,000
6	Төмөр торх боошиг	ш	1	8,200	9,020
7	Химийн бодисийн шил, сав	ш	1	2,000	2,200
8	Химийн хатуу хуурай хаягдал	кг	1	5,600	6,160
9	Химийн хаягдал шингэн уусмал 1литр	л	1	6,000	6,600
10	Хаягдал аккумлятор	ш	1	4,000	4,400
11	Масло шүүр том оврийн	кг	1	2,800	3,080
12	Принтерийн хор	ш	1	2,500	2,750
13	Тосны шүүр	кг	1	2,400	2,640
14	Агаар шүүгч	кг	1	2,100	2,310
15	Хаягдал лаг	кг	1	3,800	4,180
16	Хаягдал цаас бохирдсон	кг	1	600	660
17	Хаягдал маск болон бээлий нийлэг материал	кг	1	3,000	3,300
18	Хаягдал шингээгч даавуу химийн бодистой тостой	кг	1	3,500	3,850
19	Хаягдал төмөр материал болон бусад	кг	1	2,500	2,750
20	Хаягдал лааз сав	ш	1	1,100	1,210
21	Хаягдал баттарей	кг	1	3,500	3,850
22	Ашиглаасан масло, тос	л	1	600	660
23	Хөргөлтийн шингэн тосол	л	1	1,000	1,100
24	Галын хорны баллон жижиг/ дунд	ш	1	3,500	3,850
25	Галын хорны баллон том	ш	1	4,000	4,400
26	Бохирдсон хөрс тостой	тн	1	1,600,000	1,760,000
27	Эмнэлгийн хаягдал	кг	1	5,500	6,050
28	Хаягдал дугуй	том	1кг	400	440
29	Хаягдал дугуй	жижиг	1кг	600	660
30	Хар тугалганы хаягдал	кг	1	1,200	1,320
31	Нонель гуурс	кг	1	950	1,045
32	Даралтын гидро шланг	кг	1	2,600	2,860

Үүсгэгч талыг төлөөлж:

"Аглаг Хангайн Уулс" ХХК-ийн

Дэд захирал

.....

Д.Батбаяр

Хүлээн авагч талыг төлөөлж:

"Түмэн Эгшиг" ХХК-ийн

Ерөнхий менежерийн хорт болон ашуултай бодисын хог хаягдлыг бие даан боловсруулах эко талбай

.....

Б.Отгонбаяр

ТҮМЭН ЭГШИГ ХХК МЕНЕЖЕР ТЕХНИКИЙН АЛБА

БАТЛАВ:

"СОЁОЛОН ИНТЕРИЭШНЛ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... Б.АРИУНБОЛД

"ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... /Н.БИЛГҮҮН/

ХИМИЙН БОДИС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2025 оны 05 сарын 26-ны өдөр № 61-Р-49/25 Улаанбаатар хот

Нэг талаас **"Соёолон Интериэшнл" ХХК** (РД: 5644984), (цаашид "Худалдан авагч" гэх), нөгөө талаас **"Цэцүүх трейд" ХХК** (РД: 2066521), (цаашид "Худалдагч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү Химийн бодис худалдах, худалдан авах гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г байгуулав.

Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд химийн бодис худалдах, худалдан авахтай холбогдон Худалдан авагч, Худалдагчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг энэхүү Гэрээгээр зохицуулна.

1. Худалдан авагч нь энэхүү Гэрээний Хавсралт№1. Захиалгын хуудаст заасан тоо хэмжээ, үзүүлэлт, чанар бүхий химийн бодис (цаашид "Бараа" гэх)-ийг худалдан авахаар Худалдагчтай харилцан тохиролцсон болно.

2. Барааны нийт үнэ энэхүү Гэрээний Хавсралт№1.Захиалгын хуудаст зааснаар тодорхойлогдох бөгөөд тус үнэд НӨАТ, гаалийн татвар, хураамж болон холбогдох бусад зардал, Бараг Худалдан авагчийн заасан цэгт хүргэх тээвэрлэлтийн зардал болон Гэрээгээр хүлээсэн бүхий л үүргээ биелүүлэхэд шаардлагатай бусад дагалдах үйлчилгээний зардлууд бүгд багтсан болно.

3. Худалдагч нь Бараг энэхүү Гэрээний Хавсралт №1.Захиалгын хуудаст заасан хугацаанд нийлүүлж, хүлээлгэн өгнө.

4. Энэхүү Гэрээний хугацаа нь талууд Гэрээнд гарын үсэг зурснаар эхэлж Талуудын аль нэг нь гэрээг цуцлах санал гаргасны дагуу Талууд гэрээг цуцалснаар эсвэл Талуудын нөгөө Талын өмнө энэхүү Гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг бүрэн дуусснаар Гэрээ дуусгавар болно.

5. Дор дурдсан баримт бичиг нь Гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "Гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

5.1. Гэрээний ерөнхий нөхцөл;
5.2. Гэрээний тусгай нөхцөл;
5.3. Хавсралт №1. Захиалгын хуудас;
5.4. Хавсралт№2. Бараа хүлээлцэх акт;
5.4.1. Үйлдвэрлэгчийн сертификат;
5.4.2. Гарал үүслийн бичиг;
5.4.3. Химийн бодисын хор аюулын тодорхойлолт (MSDS);
5.4.4. Үйлдвэрлэгчээс ирүүлсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг зэрэг (Үйлдвэрлэгчээс энэхүү бичиг баримтыг ирүүлээгүй тохиолдолд Монгол улс дахь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийг хүлээн зөвшөөрнө.)
5.5. Хавсралт№3. Химийн бодис нийлүүлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл;
5.6. Хавсралт№4. Худалдагчийн Улсын бүртгэлийн гэрчилгээ;
5.7. ГЕН болон ГТН-д заасан бусад шаардлагатай баримт бичиг.

6. Гэрээ нь энд дурдсан Барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцэл энэхүү Гэрээг байгуулснаар дуусгавар болно.

Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл илүү нарийвчлан заасан Гэрээний баримт бичгийн дагуу тайлбарлан шийдвэрлэнэ.

7. Худалдагч нь энэхүү Гэрээний дагуу Худалдан авагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү Гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан Бараг бүрэн нийлүүлж, доголдолтой Бараг нийлүүлсэн тохиолдолд доголдлыг өөрийн зардлаар бүрэн арилгах үүрэг хүлээнэ.

8. Худалдан авагч нь Гэрээний дагуу Худалдагчийн Бараа нийлүүлсний төлбөр буюу Гэрээний үнэ, холбогдох Гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг Гэрээнд заасан хэлбэрээр Худалдагчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, и-мэйл хаягаар харилцана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ханган нийлүүлэлтийн менежер

..... Б.Номин

Ерөнхий нягтлан бодогч

..... Б.Нарангэрэл

Хаяг: Баянзүрх дүүрэг, 43-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, Ю Би тауэр, 101 тоот

Утас: 7000 5292, 8600 5292
и-мэйл: nomin@soyolon.mn

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Санхүү хуралдаа хариуцсан захирал

..... Б.Даваажав

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 64/2 тоот

Утас: 70179777, 99057708
И-мэйл: Davaajav@tsetsuuh.mn

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

(цаашид "ГЕН" гэх)

1. Нэр томьёо	**1.1.**	Энэ Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
	(а)	"Гэрээ" гэж Талуудын хооронд байгуулсан Химийн бодис худалдах, худалдан авах гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан Гэрээ, Ерөнхий болон Тусгай нөхцөл, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
	(б)	"Гэрээний үнэ" гэж Худалдагчийн санал болгож Худалдан авагчийн зөвшөөрсөн Хавсралт№1. Захиалгын хуудаст заасан тухайн барааны нийт үнэ байна.
	(в)	"Бараа" гэж Худалдагчаас Худалдан авагчид Гэрээний дагуу нийлүүлэх Хавсралт№1. Захиалгын хуудаст заасан химийн бодисыг хэлнэ.
	(г)	"Дагалдах үйлчилгээ" гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ зэрэг Гэрээний дагуу Худалдагчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.
	(д)	"Худалдан авагч" гэж Гэрээнд заасан барааг хүлээн авах, харилцан тохиролцсон үнийг төлөх аж ахуй нэгжийг хэлнэ.
	(ж)	"Худалдагч" гэж Гэрээнд заасан барааг нийлүүлэх, худалдах болон дагалдах үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгжийг хэлнэ.
	(з)	"Хоног" гэж хуанлийн хоногийг хэлнэ.
	(и)	"Хүргэлтийн хугацаа" гэж Гэрээнд заасан нөхцөл болзлын дагуу Гэрээний хүрээнд Бараа нийлүүлэх Хавсралт№1. Захиалгын хуудаст заасан хугацааг хэлнэ.
	(й)	"Хүлээн авах цэг" гэж Хавсралт№1. Захиалгын хуудаст хуудаст тодорхойлсон Бараа хүргэгдэх газрыг, хэрэв уг газрыг тусгайлан заагаагүй бол Худалдан авагчийн Барааг хүлээн авахаар зөвшөөрсөн газрыг хэлнэ.
	(к)	"Захиалгын хуудас" гэж худалдан авах Барааны тоо хэмжээ, техникийн шаардлага, тодорхойлолт, хүргэх газар, худалдааны нөхцөл, үнэ зэргийг заасан баримт бичгийг хэлнэ.
	(л)	"Төлбөрийн нөхцөл" Худалдан авагчийн Барааны үнийг төлөх ГЕН болон ГТН-д заасан хугацаа, хугацааг хэлнэ.
2. Тайлбар	2.1.	Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид "ГЕН" гэх) болон Гэрээний тусгай нөхцөл (цаашид "ГТН" гэх) хооронд зөрчилдсөн тохиолдолд гэрээний тусгай нөхцөлийг баримтална.
3. Гэрээнд баримтлах хууль	3.1.	ГТН-д өөрөөр тусгайлан заагаагүй бол энэхүү Гэрээ түүгээр зохицуулагдах талуудын эрх, үүрэг, хариуцлага, хэрэгжилт, гүйцэтгэл болон бусад Гэрээнээс үүсэх аливаа асуудлыг Монгол Улсын хуулиар зохицуулна.
4. Гэрээнийх хэл	4.1.	Энэ Гэрээг Монгол хэл дээр байгуулсан болно.
5. Харилцах журам	5.1.	Энэхүү Гэрээнд холбогдох асуудлаар талууд зөвхөн бичгээр харилцах бөгөөд талуудын томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгчид Гэрээний тусгай нөхцөлд заасан электрон шуудангийн хаягаар харилцсан бол бичгийн хэлбэрээр харилцсанд тооцно.

	5.2.	Худалдагч нь шаардлагатай тохиолдолд дээрх 5.1 дэх хэсэгт заасан бичгийн хэлбэрээр харилцсан аливаа үйлдлийг хүлээн авагч авсан болохыг нотлох баримтыг өөрөө бүрдүүлнэ.
6. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах	6.1.	Худалдагч нь Худалдан авагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд Гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж худалдан авагчийн өгсөн мэдээлэл, зураг зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задруулахгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
	6.2.	Худалдан авагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, Худалдагч ГЕН-ийн 6.1 дэх хэсэгт дурдсан баримт бичиг болон мэдээллийг Гэрээнд зааснаас бусад зорилгоор ашиглахгүй.
	6.3.	ГЕН-ийн 6.1 дэх хэсэгт дурдсан Гэрээнээс бусад баримт бичиг Худалдан авагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв Худалдан авагч хүсвэл Худалдагч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) Худалдан авагчид буцааж өгнө.
7. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	7.1.	Энэхүү Гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх бол нэмэлт өөрчлөлтийн гэрээг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
8. Барааны гарал үүслийн улс	8.1.	Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Хавсралт№1. Захиалгын хуудаст заасан улсын гарал үүсэлтэй байна.
	8.2.	Барааны гарал үүслийн улс гэдэгт бараанд хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр ариллжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.
	8.3.	Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол Худалдагчийг Гэрээний баталгаат хугацаа болон бусад үүргээс чөлөөлөхгүй.
9. Баглаа боодол	9.1.	Худалдагч Бараанд Хүлээн авах цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх зориулалтын холбогдох стандартын баглаа боодлоор боож савласан, стандартын шаардлага хангасан англи, орос, монгол хэл дээр үйлдэгдсэн хаяг шошготой байна. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн цаг агаарын нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн температур, халуун, хүйтэн орчин, болон давс, хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэхээр чанартай, эдэлгээ даахуйц байхаас гадна тэмдэг, тэмдэглэгээтэй байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо Бараанд хүргэх Хүлээн авах цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг холбогдох бүхий л хүчин зүйлийг харгалзсан байна.
10. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	10.1.	Худалдагч нь "Хавсралт№1.Захиалгын хуудас, Үйлдвэрлэгчийн чанарын сертификатад нийцсэн, Гарал үүслийн бичиг, Химийн бодисын хор аюулын тодорхойлолт (MSDS), Үйлдвэрлэгчээс ирүүлсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичигтэй Бараанд Худалдан авагчид нийлүүлнэ. "Хавсралт №1.Захиалгын хуудас, Үйлдвэрлэгчийн чанарын сертификатад зааснаас өөр, дээрх бичиг баримтын бүрдэл дутуу Бараа нийлүүлэхгүй.

	10.2.	Энэхүү Гэрээ баталгаажмагц Худалдагч Бараа нийлүүлэлтийн үйл ажиллагааг эхлүүлнэ.
	10.3.	Худалдагч нь Гэрээнд зааснаас өөр эсхүл иж бүрдэл, дагалдах бичиг баримт дутуу, чанарын доголдолтой бараа нийлүүлсэн бол Худалдан авагч энэ талаар Худалдагчид бичгээр мэдэгдэнэ. Хэрэв Худалдан авагчийн мэдэгдэлд дурдсан хугацаанд Худалдагч нь Гэрээнд зааснаас өөр эсхүл иж бүрдэл, дагалдах баримт бичиг дутуу, чанарын доголдолтой Барааг сольж өгөөгүй тохиолдолд Худалдан авагч нь гуравдагч этгээдээс тухайн Барааг худалдан авна. Энэ тохиолдолд Худалдан авагчийн Гэрээнд заасан Барааг гуравдагч этгээдээс худалдан авахад гаргасан Барааны үнийн зөрүү болон бусад нэмэлт зардлыг Худалдагч Худалдан авагчид нөхөн төлнө.
	10.4.	Худалдагч Гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
11. Чанарын баталгаа	11.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх Бараа нь холбогдох стандарт, шаардлага, үзүүлэлтийг бүрэн хангасан, үйлдвэрлэгчийн чанарын сертификат бусад бичиг баримтад бүрэн нийцсэн байна.
	11.2.	Худалдан авагч Барааг Хүлээн авах цэгт хүлээн авч, акт үйлдсэнээс хойш тухайн Барааны 3 сар/жил-ийн баталгаат хугацааг өгөх бөгөөд Худалдан авагч тус хугацаанд Барааны чанартай холбоотой гомдлын шаардлага гарган тухайн доголдолтой барааг солиулах эрхтэй байна.
	11.3.	Худалдан авагч нь энэхүү хэсэгт заасан чанарын шаардлага хангаагүйгээс үүдэх холбогдох гомдлыг Худалдагчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
	11.4.	Худалдагч энэхүү мэдэгдлийг хүлээн авмагц тухайн мэдэгдэлд заасан хугацаанд чанарын шаардлага хангаагүй Барааг үнэ төлбөргүй, шуурхай солих үүрэгтэй.
	11.5.	Хэрэв Худалдагч чанарын шаардлага хангаагүй тухай мэдэгдэл хүлээн аваад Гэрээний дагуу Худалдан авагчийн заасан хугацаанд доголдлыг арилгаагүй тохиолдолд гарах хохирол, үр дагаврыг үл маргах зарчмаар Худалдагч өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.
	11.6.	ГТН-ийн 4.2-д заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Худалдагч нь чанарын шаардлага хангаагүй Барааг үнэ төлбөргүй нэн даруй солихоос гадна тухайн шаардлага хангаагүй Барааны үнийн дүнгийн 50 хувийг Иргэний хуулийн 232.5 дахь хэсэгт заасны дагуу торгууль болгон Худалдан авагчид төлнө.
12. Төлбөрийн нөхцөл, нэхэмжлэл	12.1.	Гэрээний дагуу Худалдагчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д нарийвчлан заасан тохиолдолд талууд ГТН-д заасан зохицуулалтыг даган мөрдөнө.
	12.2.	Худалдагч нь Гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараа төлбөр төлөхийг хүссэн хүсэлтээ төлбөрийн нэхэмжлэх болон Гэрээний Хавсралт №2-д заасан Бараа хүлээлцэх актын хамт Худалдан авагчид хүргүүлнэ.
	12.3.	ГТН-д өөрөөр заагаагүй бол Худалдан авагч төлбөрийн нэхэмжлэх хүлээн авснаас хойш Бараа хүлээлцэх актыг үндэслэн ажлын 10 (арав) хоногийн дотор төлбөрийг төлнө.

	12.4. ГТН-д өөрөөр заагаагүй бол Худалдагч төлбөрийг хүлээж авсан тухай бүр ажлын 1 (нэг) өдрийн дотор төлбөрийн и-баримт цахимаар үүсгэнэ.
13. Үнэ	13.1. Гэрээний дагуу нийлүүлсэн Барааны үнийг нэхэмжлэхдээ Хавсралт №1. Захиалгын хуудаст заасан Барааны нэгж үнийг баримтална.
	13.2. Гэрээний үнэд Гэрээний хугацаанд өөрчлөлт орохгүй болно.
14. Бараа нийлүүлэх хугацаа	14.1. Худалдагч Барааг нийлүүлэхдээ Хавсралт №1.Захиалгын хуудаст заасан хугацааны дотор Хүлээн авах цэгт хүлээлгэн өгнө.
	14.2. Худалдагч ГЕН-ийн 18-д заасан нөхцөл байдал бий болсны улмаас Бараа Хүлээн авах цэгт хүргэх хугацаа хойшлох нөхцөл байдал үүссэн тухай Худалдан авагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, мөн хойшлох нөхцөл байдал бий болсныг нотлоогүй тохиолдолд ГЕН-ийн 18.2-ыг үл харгалзах бөгөөд нийлүүлэх хугацааг сунгахгүй болно.
15. Алданги	15.1. ГТН-д өөрөөр заагаагүй бол Худалдагч нь Гэрээнд заасан Бараа нийлүүлэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Худалдан авагчид төлнө. 15.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол Худалдан авагч нь Гэрээнд заагдсан Барааны үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Худалдагчид төлнө. 15.3. Алданги тооцох тухай шаардлагыг хүлээн авсан тал хуанлийн 7 хоногийн дотор албан бичгээр хариу өгөх ба заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд алдангийг хүлээн зөвшөөрсөнд тооцно. 15.4. Нийт ногдуулах алдангийн дээд хэмжээ нь Гэрээний үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.
16. Гэрээ цуцлах	16.1. Худалдан авагч нь дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд Гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр Худалдагчид бичгээр мэдэгдсэнээр Гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:
	(а) Худалдагчийн нийлүүлсэн Бараа нь Хавсралт №1.Захиалгын хуудас, ГЕН-ийн 11-д заасан чанарын шаардлага хангаагүй;
	(б) Худалдагчийн нийлүүлсэн Бараа нь Хавсралт №1.Захиалгын хуудас, ГЕН-ийн 11-д заасан чанарын шаардлага хангаагүй , тоо хэмжээ дутуу, доголдолтой талаарх Худалдан авагчийн мэдэгдэлд заасан хугацаанд Худалдагч тухайн зөрчлийг арилгаагүй;
	(в) Худалдагч нь энэхүү нөхцөлийн 11.4-11.6 дахь хэсгүүдэд заасан үүргээ биелүүлээгүй, биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан.
	(г) Худалдагч нь Бараа Хавсралт№1.Захиалгын хуудсанд заасан хугацаанд хүргэж чадаагүй; (д) гэрээнд заасан бусад нөхцөл.
17. Маргааныг шийдвэрлэх	17.1. Худалдан авагч болон Худалдагчийн хооронд Гэрээтэй холбогдон үүссэн маргааныг зөвшилцөл болон хэлэлцээгээр шийдэхийг хичээнэ.
	17.2. Дээрх хэлэлцээ 30 хоног үргэлжлэхэд тухайн гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал шүүхэд хандах эрхтэй.

18. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал	18.1.	Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс Худалдан авагч, эсхүл Худалдагчийн гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа хоцорсон бол үүрэг гүйцэтгэх хугацааг талууд харилцан тохиролцож сунгана.
	18.2.	Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд Худалдагч нь тухайн нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар Худалдан авагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Худалдан авагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Худалдагч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан Гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
	18.3.	Худалдагч нь бий болсон Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлыг Монгол улсын худалдаа аж үйлдвэрийн танхимаас олгосон Гэнэтийн болон Давагдашгүй хүчний нөхцөл байдлын гэрчилгээгээр нотлох үүрэгтэй бөгөөд ийнхүү нотлох үүргээ биелүүлээгүй тохиолдолд энэхүү Гэрээнд заасан аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
19. Гэрээний үүргийг шилжүүлэх	19.1.	Бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
20. Үүргийн гүйцэтгэл	20.1.	Худалдагч нь гэрээний үүргээ гүйцэтгэхдээ холбогдох хууль, тогтоомж, журам, заавар, техникийн тодорхойлолтыг дагаж мөрдөнө.
	20.2.	Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

(цаашид "ГТН" гэх)

1. Бараа	Бараа нь Гэрээний Хавсралт№1. Захиалгын хуудас болон ГЕН-ийн 11-д заасан тоо хэмжээ, чанар, үзүүлэлт, стандарт, шаардлагад бүрэн хангасан байна.
2. Барааг хүлээн авах цэг	Хавсралт№1. Захиалгын хуудаст заасан газар
3. Явцын хяналт	Худалдан авагч нь Худалдагчийн захиалга болон захиалсан барааны чанар, нийлүүлэлтийн гүйцэтгэлийн явц, нийлүүлэх хугацааг баримталж буй эсэхэд тогтмол хяналт тавин ажиллана.
4. Шалгах болон турших	4.1. Худалдагч нь Барааг хүлээлгэн өгөхдөө Худалдан авагчид шалгуулж, аливаа биет байдлын доголдолгүй эрхийн зөрчилгүй байдлаар Барааны гарал үүслийн бичиг, Химийн бодисын хор аюулын тодорхойлолт (MSDS), Үйлдвэрлэгчээс ирүүлсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийг заавал дагалдуулан хүлээлгэж өгөх бөгөөд ийнхүү шалгуулан хүлээлгэн өгөөгүй тохиолдолд Худалдан авагч ут Барааг хүлээж авахгүй байх эрхтэй. 4.2. Худалдан авагч шаардсан тохиолдолд баталгаат хугацааны дотор Худалдагчийн нийлүүлсэн Бараа нь энэхүү Гэрээ болон бусад холбогдох баримт бичигт заасан чанарын болон техникийн шаардлагыг хангаж буй эсэхийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид түүврийн аргаар шинжилгээнд өгч чанарын шаардлага хангаж байгаа эсэхийг шинжлэн шалгуулах эрхтэй. Хэрэв Бараа нь Гэрээ болон бусад холбогдох баримт бичигт заасан чанарын болон техникийн шаардлагыг хангаагүй байгаа нь хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээгээр илэрсэн тохиолдолд ГЕН-ийн 11.6 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.
5. Төлбөрийн нөхцөл	5.1. Гэрээний Хавсралт №.1.Захиалгын хуудаст өөрөөр заагаагүй бол Худалдан авагч нь Барааны төлбөрийг дараах нөхцөлийн дагуу Худалдагчид төлнө. Үүнд: 5.1.1. Захиалгын хуудаст заасан Барааны нийт үнийн дүнгийн 50 хувийг энэхүү Гэрээ баталгаажсанаас хойш Худалдагчийн нэхэмжлэхийг үндэслэн ажлын 3 (гурав) хоногт. 5.1.2. Худалдагч Захиалгын хуудаст заасан Барааг заасан хугацаанд зохих журмын дагуу актаар бүрэн хүлээлгэн өгснөөс хойш Худалдагчийн нэхэмжлэхийг үндэслэн үлдэгдэл 50 хувийг ажлын 10 (арав) хоногт төлнө.
6. Худалдан авагчийн эрх, үүрэг	**6.1. Худалдан авагч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:** 6.1.1. Худалдагчид үүргээ биелүүлэхэд шаардагдах баримт бичиг болон бусад мэдээллийг өгөх, 6.1.2. Гэрээгээр тохиролцсон нөхцөл, журмын дагуу төлбөрийг хугацаанд нь төлөх, 6.1.3. Хууль тогтоомж болон энэхүү Гэрээнд заасан бусад үүрэг. **6.2. Худалдан авагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:** 6.2.1. Нийлүүлж буй Барааны чанар, нийлүүлэх явц, хугацааг баримталж буй эсэх зэрэгт хяналт тавих, 6.2.2. Нийлүүлсэн Барааны чанарын болон бусад дутагдал, доголдол илэрвэл Барааг хүлээн авахаас татгалзах, 6.2.3. Нийлүүлсэн Барааны илэрсэн зөрчил, дутагдал, доголдлыг магадлан шалгаж акт, дүгнэлт, шаардлага гаргах. 6.2.4. Барааг энэхүү Гэрээ болон бусад холбогдох баримт бичигт

	зааСан чанарын болон техникийн шаардлагыг хангаж буй эсэхийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториар шинжлүүлсэн баримт бичгийг гаргуулан авах; 6.2.5. Хууль тогтоомж болон энэхүү Гэрээнд заасан бусад эрх.
7. Худалдагчийн эрх үүрэг	**7.1. Худалдагч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:** 7.1.1. Худалдагч нь Гэрээнд заасан Бараг Гэрээнд заасан нөхцөл, хугацаанд нийлүүлэх, 7.1.2. Гэрээний үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлэх, 7.1.3. Худалдан авагчид Барааны нийлүүлэх явцын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Худалдан авагчийн шаардсан хугацаанд тогтмол танилцуулах, 7.1.4. Өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан Худалдан авагч болон бусад этгээдэд учруулсан хохирлыг бүрэн хариуцан арилгах, 7.1.5. Барааны дутагдал, бинт байдал болон эрхийн доголдол болон бусад зөрчлийг Худалдан авагчийн шаардлагын дагуу өөрийн хөрөнгөөр бүрэн арилгах, 7.1.6. Бараг импортлох, ашиглах, нийлүүлэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх, 7.1.7. Тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр бус байдлаас үүдэн гарах аливаа эрсдэл, үр дагаврыг хариуцан, арилгах, Худалдан авагчийг холбогдох эрсдэл, зардал, хохирлоос ангид байлгах, 7.1.8. Нийлүүлсэн барааНд химийн бодисын хор, аюулгүй ажиллагааны лавлах мэдээлэл, чанарын паспортыг дагалдуулан өгөх, 7.1.9. Хууль тогтоомж болон энэхүү Гэрээнд заасан бусад үүрэг. **7.2. Худалдагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:** 7.2.1. Худалдан авагчийг заасан хугацаанд Гэрээний үнийг төлөхийг шаардах, 7.2.2. Худалдан авагчийн гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгэхийг шаардах, 7.2.3. Хууль тогтоомж болон энэхүү Гэрээнд заасан бусад эрх.
8. Бараа нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	8.1. Худалдагчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: a) Барааны жагсаалт, тоо хэмжээ; b) Зарлагын баримт; c) НӨАТ-ын баримт; d) Үйлдвэрлэгчийн чанарын сертификат; e) Гарал үүслийн бичиг; f) Химийн бодисын хор, аюулгүйн тодорхойлолт MSDS; g) Үйлдвэрлэгчээс ирүүлсэн итгэмжлэгдсэн лабораторийн бичиг. 8.2. Худалдан авагч нь дээр заасан баримт бичгийг Барааны хамт худалдан авагчид хүлээлгэн өгнө. Баримт бичгийг Худалдан авагчид гарган өгөөгүйгээс гарах зардал, хохирлыг Худалдагч данГаар бүрэн хариушна.
9. Нууцлал	9.1. Гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнд бий болсон аливаа бичиг баримт, акт зэрэг нь Худалдан авагчийн өмчлөл, эзэмшилд үлдэхийг

	Худалдагч хүлээн зөвшөөрч байгаа болно. Мөн талууд энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцыг түүний зөвшөөролгүй бусдад задруулахгүй байх үүргийг хугацаагүйгээр хүлээх бөгөөд ийнхүү задруулснаас учруулсан хохирлыг бүрэн хариуцна.
10. Барааг хүлээн авах	10.1. Талууд Барааг Хавсралт№2 Бараа хүлээлцэх актын дагуу акт үйлдэн хүлээлцсэнээр Барааны өмчлөх эрх Худалдан авагчид бүрэн шилжинэ. 10.2. Худалдагч нь эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй, үйлдвэрээс гарсан савлагаа, боодолтой шинэ, холбогдох стандартын болон чанарын мөн Гэрээнд заасан нөхцөл шаардлага хангасан Барааг тогтоосон хугацаанд багтаан захиалгын хуудсанд заасан тоо хэмжээгээр холбогдох бичиг баримтын хамт Худалдан авагчийн эзэмшил, өмчлөлд актаар хүлээлгэн өгнө. 10.3. Барааг хүлээн авах үед Барааны тоо, хэмжээ дутуу, доголдолтой, стандартын болон чанарын мөн Гэрээнд заасан нөхцөл шаардлагыг хангаагүйг Худалдан авагч тогтоовол Худалдагч нь өөрийн зардлаар тухайн доголдлыг хариуцан арилгах үүрэгтэй. 10.4. Худалдагч нь Гэрээний дагуу нийлүүлэх Бараатай хамт, танилцуулга болон бусад шаардлагатай баримтуудыг иж бүрнээр Худалдан авагчид хүлээлгэн өгч, үүнтэй холбоотой нэмэлт мэдээллийг Худалдан авагчийн хүсэлтээр гаргаж өгнө. 10.5. Энэхүү Гэрээний дагуу Худалдан авалтын захиалга өгснөөс хойш Худалдан авагч барааг хүлээн авах хүртэлх хугацаанд Худалдагчаас нийлүүлсэн бараа нь Худалдан авагчаас өөр этгээдэд худалдагдаагүй, ашиглуулаагүй, бэлэглээгүй, өр төлбөрт хураалгаагүй, битүүмжлэгдээгүй ба эдгээрийн аль нэгийг бусдад амлаагүй эсхүл бусад байдлаар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн хувьд зөрчил доголдолгүй байна.
11. Хог хаягдал	12.1. Хог хаягдлын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.2-т химийн хортой болон аюултай бодис савлаж байсан, түүгээр бохирдсон сав баглаа боодол нь аюултай хог хаягдалд хамаарна. Засгийн газрын 2018 оны №116-р тогтоолын 1-р хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3.4-т өөрийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, экспортлох зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх үүрэгтэй. 12.2. Дээр дурдсаны дагуу Худалдан авагч нь хүлээн авсан химийн бодисын сав баглаа боодлыг ашиглаж дууссаны дараа баглаа боодлоо **үнэ төлбөргүй Худалдагч талд** шилжүүлж баримтаар хүлээлгэн өгнө. 12.3. Худалдагчийн нийлүүлсэн Барааны хуримтлагдаж үүссэн аюултай хог хаягдал (сав баглаа боодол)-г тээвэрлэх зардлыг Худалдан авагч тал хариуцах хог хаягдлыг Худалдан авагчаас хүлээн авч, тээвэрлэх, устгах үүргийг энэхүү Гэрээний дагуу Худалдагч хүлээнэ.
12. Хаяг	13.1. Талууд нь доор заасан хаягаар энэхүү Гэрээтэй аливаа мэдэгдлийг хүргүүлнэ. Худалдан авагч: Хаяг: УБ, Баянзүрх дүүрэг, 43-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, Ю Би тауэр, 1501 тоот

	Утас: 7000 5292, 8600 5292 и-мэйл: nomin@soyolon.mn Худалдагч: Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 64/2 тоот Утас: 70179777, 990577008 И-мэйл: davaajav@tsetsuuh.mn

"СОЁОЛОН ИНТЕРНЭШНЛ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

СОЁОЛОН ИНТЕРНЭШНЛ ХХК

Б.АРИУНБОЛД

"ТҮМЭН ЭГШИГ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.ЧИНЗОРИГ

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 03 сарын 25-ны өдөр № SI - D - 171/25 Улаанбаатар хот

Энэхүү аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол улсын Иргэний хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын **2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал** болон Байгаль орчныг аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг тус тус үндэслэн болгон:

(ҮҮСГЭГЧ) "СОЁОЛОН ИНТЕРНЭШНЛ" ХХК	(ХҮЛЭЭН АВАГЧ) "ТҮМЭН ЭГШИГ" ХХК
Монгол Улс, Улаанбаатар, БЗД, 25-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, Юү Би тауэр, 15 давхар, 1501 тоот Регистрийн дугаар: 5644984 Утас: 70005292, 86005292 **Үүсгэгчийн эрх бүхий төлөөлөгч:** Ханган нийлүүлэлтийн менежер Б.Номин nomin@soyolon.mn	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 хороо, Намьянжүгийн гудамж 44-өөрийн байр Регистрийн дугаар: 5031923 Утас: 88990428, 91918828 **Хүлээн авагчийн эрх бүхий төлөөлөгч:** Ерөнхий менежер Б.Одбаяр chemicalwasterisk@gmail.com

Үүсгэгч болон Хүлээн авагч нь (түс тусад нь "Тал", хамтад нь "Талууд" гэх) энэхүү гэрээг байгуулж, доорх нөхцөлөөр харилцан тохиролцов.

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийг зөвсан олон төрлийн хаягдал /цаашид "аюултай хаягдал" гэх/-ыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.

1.2. Аюултай хаягдал хүлээн авагч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.

1.3. Аюултай хог хаягдлын төрөл түүнийг устгах нэгж үнийг гэрээний Хавсралт №1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг баталгаажуулан энэ гэрээнд хавсаргана.

1.4. Энэ гэрээ нь 2025 оны 03 сарын 25-ны өдрөөс 2025 оны 12 сарын 31 -ны өдрийг хугацаатай байна.

ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дараах зүйлийг тэмдэглэсэн байна. Үүнд:

2.1.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээг тавьсан байх;

2.1.2. Аюултай хог хаягдлыг савласан сав бүрт ямар хаягдал байгаа талаарх нэр шошготой байх;

Үүсгэгч тал: .....

Хүлээн авагч тал: .....

Scanned with CamScanner

2.1.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хөтлөн хүлээн авагчид шилжүүлэн өгөх;

2.2 Хүлээн авагч нь аюултай хог хаягдлыг "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлэж хүлээн авах ба тээвэрлэлтийн гэрээг талууд тусад байгуулна.

2.3 Хүлээн авагч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгөх үед тавигдах шаардлага, хог хаягдлыг хэрхэн хуримтлуулах талаар үүсгэгчид шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг тухай бүр өгнө.

ГУРАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР

3.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлын үүссэн хуримтлал, цаашид хуримтлал үүсгэхэд сав баглаа боодлын хүрэлцээгүй тохиолдолд Хүлээн авагчид шилжүүлнэ.

3.2. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ Хүлээн авагчид албан бичиг, и-мэйлээр эсвэл утсаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

3.3. Хүлээн авагч нь Үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах харицуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

3.4. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах бүх зардлыг Хүлээн авагч тал харицуцна.

3.5. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зөвшөөлтийн тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэх, хүргэлтийн цэгт хүргэх тохиолдолд тээврийн үнийн саналыг Хүлээн авагчаас урьдчилан авч энэ гэрээний Хавсралт №1 баталгаажуулсан байна.

3.6. Талууд устгуулахаар шилжүүлсэн аюултай хаягдлын тоо хэмжээ, нэр төрлийг Хавсралт №1 ба Хавсралт №2-оор баталгаажуулах бөгөөд тус баталгаажуулсан баримт, Хүлээн авагч талын нэхэмжлэхийг үндэслэн гэрээний төлбөрийг ажлын 10 хоногийн дотор ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК **499085408** тоот дансанд хүлээн авагчид шилжүүлнэ.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:

4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авах, ачиж, тээвэрлэхийг Хүлээн авагчаас шаардах эрхтэй.

4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.1-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгнө.

4.1.3 Үүсгэгч нь аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, Тээвэрлэгчид 1 хувь, Хүлээн авагчид 2 хувийг илгээж, Хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.

4.1.4 Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг харицуцна.

4.1.5 Үүсгэгч нь Хүлээн авагчаар аюултай хог хаягдлыг хот дотор 200,000₮ хүртэлх мөнгөн дүнтэй тээврийн зардлаар харицуцаж тээвэрлүүлж болно.

4.1.6 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг Хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ.

4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг

4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.1-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах,ачиж, тээвэрлэх эрхтэй.

4.2.2 Хүлээн авагч нь худалдан борлуулсан химийн хорт болон аюултай бодисоос үүдэлтэй хог хаягдлыг өөртөө шилжүүлэн авч, устгах, хадгалах, дахин боловсруулах ажлыг гүйцэтгэх, химийн бодисын хог хаягдалтай холбоотой аливаа асуудлаас үүсгэгчийг ангид байлгах үүрэгтэй.

4.2.3 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг Үүсгэгчид гаргаж өгнө.

4.2.4 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг шилжүүлэн авсанаас хойш түүний хадгалалт, дахин боловсруулалт, устгал зэргийг бүрэн харицуцна.

4.2.5 Үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжиж ирэх үед харицуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

Үүсгэгч тал: .....

Хүлээн авагч тал: .....

Scanned with CamScanner

ТАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН АВАХ

5.1. Үүсгэгч аюултай хог хаягдлын мэдээллийг 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэн аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй.

5.2. Хүлээн авагч нь аюултай хог хаягдлаа "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлэн хүлээн авна.

5.3. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж Хүлээн авагч тал хүлээн авна.

5.4. Аюултай хог хаягдлыг ачиж зөөх зардал, аюулгүй байдлыг Үүсгэгч тал хариуцна.

ЗУРГАА. ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖИХ

6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.

6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг Хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх Хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.

6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний эрсдэл Үүсгэгчид байх ба Хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр эрсдэл Хүлээн авагчид шилжинэ.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.

7.2. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.3-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэлт болон хадгалалтын зардал, учирсан хохирлыг Үүсгэгчид төлнө.

7.3. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг Иргэний хууль болон энэ гэрээнд заасан журмын дагуу зохицуулна.

7.4. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болох Хавсралт №2 болон гэрээний Хавсралт №1-д заасан тоо хэмжээ, аюултай хаягдлын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

7.5. Энэхүү гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.6. Нэг талын санаачилгаар гэрээнээс татгалзах болон цуцлах тохиолдолд нөгөө талдаа 30 хоногийн өмнө мэдэгдэнэ.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1. Талуудын аль нэг нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Дээрх нөхцөл байдал болон түүний үр дагавар арилмагц үүргээ нэн даруй гүйцэтгэнэ. Түс нөхцөл байдалтай холбоотойгоор гэрээний хугацаанд өөрчлөлт орохоор бол хоёр тал харилцан тохиролцоно.

8.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас энэхүү гэрээ саатсан буюу хэрэгжих боломжгүй талаар хүсэлт гаргасан тал нь нотолсон тохиолдолд гэрээний нөгөө тал түс хугацааны алданги, торгууль нэмэлт үүргээс чөлөөлөгдөнө.

8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг Үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг Хүлээн авагч хариуцна.

Үүсгэгч тал: .....

Хүлээн авагч тал: .....

Scanned with CamScanner

ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, талууд тус бүр 1 хувийг хадгална. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд зөвхөн бичгээр оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл гэх зэргээр гэрээтэй холбоотой гаргаж буй аливаа мэдэгдэл, албан бичиг, санал, хүсэлтийг зөвхөн бичгээр баталгаажуулах ба талуудын албан ёсны хаягаар биечлэн, шуудангаар эсвэл албан ёсны электрон хаягаар хүргүүлнэ.

9.4. Талууд гэрээтэй холбогдон гарсан аливаа асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:	ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН МЕНЕЖЕР	ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
.....	.....
Б.НОМИН	Б.ОДБАЯР

Үүсгэгч тал: .....

Хүлээн авагч тал: .....

Scanned with CamScanner

БАТЛАВ:
"ЭЛЕМЕНТ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Б.ЭНХБАДРАЛ/

БАТЛАВ:
"ТРҮ ТИ АР СИ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/ С.ХАНДМАА/

ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН
ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ ХБ-25/113

2025 оны 06-р сарын 08-ны өдөр 33/25 Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Нэг талаас **"Элемент"** ХХК РД: /2100061/ /цаашид **"Гүйцэтгэгч"** гэх/ түүнийг төлөөлж, Химийн мэргэжилтэн албан тушаалтай Э.Халиун, нөгөө талаас /цаашид **"Захиалагч"** гэх/-ыг **"Трү Ти Ар Си"**ХХК РД:/6610188/ түүнийг төлөөлж Чанарын Менежер албан тушаалтай Г.Уганцэцэг нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд химийн аюултай хог хаягдлыг өөрийн хими технологийн үйлдвэрлүү ачиж тээвэрлэх, зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг устгах, захиалагч төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

1.2. Дараах баримт бичиг гэрээний хавсралт байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

1.2.1 Устгал хийх хог хаягдлын мэдээлэл, үнэ /Хавсралт №1/

1.2.2 Аюултай хог хаягдлын дагалдах бичиг

1.2.3 Захиалагч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ

1.2.4 "Элемент" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар

ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Захиалагч дараах эрхтэй:

2.1.1.Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

2.1.2.Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,

2.1.3.Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.

2.2. Захиалагч дараах үүрэгтэй:

2.2.1.Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь "Аюултай хог

хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,

2.2.2.Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,

2.2.3.Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах,

2.2.4.Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах,

2.2.5.Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,

2.2.6.Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх,

2.2.7.Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх,

2.2.8.Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтаныг байгууллага дээрээ байлгаж, хог хаягдал ачилт хийж өгөх.

2.2.9.Аюултай хог хаягдлаа гэрээний хүчинтэй хугацаанд багтаан 4.3-т заасны дагуу хүлээлгэн өгч устгуулах.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:

3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй,

3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, "аюултай" гэсэн тэмдэглэгээтэй байхыг шаардах, хаягтүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй,

3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй

3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Хог хаягдлыг захиалагчийн өгсөн захиалга, тоо хэмжээ, байршилд тулгуурлан тээвэрлэх хуваарь гарган захиалагчид мэдээлэл өгч зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх,

3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,

3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,

3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,

3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах

3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,

3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

3.2.8. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг

ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

4.1.Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед ашуултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрт тооцож нэхэмжилнэ. Ашуултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.

4.2.Энэхүү гэрээ 2025 оны 06-р сарын 09-ны өдрөөс 2026 оны 06-р сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэнэ.

4.3.Захиалагч гэрээний баталгаа болгож урьдчилгаа төлбөр болох **500,000.0 /Таван зуун мянга/** төгрөгийг Гэрээний 4.6 дахь хэсэгт заасан дансанд байршуулснаар гэрээ батлагдана. Урьдчилгаа төлбөр нь гэрээний хүчинтэй хугацаанд хийгдсэн тээвэрлэлт, устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.

4.4.4.3-т заасан урьдчилгаа төлбөр нь зөвхөн энэхүү гэрээний хүчинтэй хугацаанд үйлчилгээний төлбөрөөс хасагдаж тооцогдоно.

4.5.Ашуултай хог хаягдлыг гүйцэтгэгч ачилт тээвэрлэлт хийх үед болон устгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийх үед гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд гүйцэтгэлээр захиалагч талаас нэхэмжилнэ.

4.6.Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа гэрээнд заасан журмаар гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийн нэхэмжлэлийг үндэслэн "Элемент" ХХК-ийн **1715164140 /Голомт банк/** тоот дансанд бэлэн бусаар төлнө.

4.7.Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой обьектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ.

4.8.Төлбөр тооцоог зөвхөн Гэрээний 4.6 дахь хэсэгт заасан байгууллагын дансанд төлөх бөгөөд тус данснаас бусад хувь хүний дансандшилжүүлсэнээс үүдэх хохиролыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.

Дэрс – таанат /Н-III-3-4/ бэлчээр: Тус талбай нь уулын бэл хормой түүний тэгш хөндийгөөр тархах таана - дэрст бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 26%, 13 зүйлийн ургамал (бичиглэл-8) бүртгэгдсэн, 1м.кв. талбайд 6 зүйл ургана, ургац 1,5 ц/га байсан. Ургамлан нөмрөгийн өндөр 15 см байсан. Зонхилогч ургамлын хувьд үетнээс Гялгар дэрс, Сайрын хялгана, Зүүнгарын хазааргана, алаг өвснөөс алаг өвснөөс Ширэг улалж, Таана буюу багалгар сонгино, Коршинскийн өлөнгө, Төлөгчдүү боролзой, Хөмөл, Говийн хэрээн нүд, Дэрэвгэр хависгана, цөөн наст ургамлаас Арзгар согсоот, Үслиг манан-хамхаг ургана. Бэлчээрийн талхагдал дунд байсан. Сөөгнөөс Нарийн навчит харгана 100м.кв. талбайд 1 ширхэг тохиолдоно.

Зураг 22. 8-р бичиглэл хийсэн цэгийн ерөнхий ургамалжил, 1м^2 талбай дахь ургамалжил

Хүснэгт 26. Бичиглэл-8

Ургамлын зүйлийн бүрдэл					
№	**Ургамлын латин нэр**	**Ургамлын монгол нэр**	**Бүрхэц (%)**	**Арви**	**Амин хэлбэр**
1	*Carex duriuscula C.A.Mey.*	*Ширэг улалж*	3	Sp	Олон наст
2	*Achnatherum splendens (Trin.) Nevski*	*Гялгар дэрс*	10	Cop1	Олон наст
3	*Allium polyrrhizum Turcz. Ex rgl.*	*Таана буюу багалгар сонгино*	8	Sp	Олон наст
4	*Stipa glareosa P.Smirn.*	*Сайрын хялгана*	2	Sp	Олон наст
5	*Carex korshinskyi*	Коршинскийн өлөнгө	2	Sp	Олон наст
6	*Cleistogenes soongarica*	Зүүнгарын хазааргана	1	Sp	Олон наст
7	*Ajania acheleoides (Turcz.) Poljak.*	*Төлөгчдүү боролзой*		Sol	Олон наст
8	*Allium mongolicum Rgl.*	*Хөмөл*		Sol	Олон наст
9	*Heteropappus hispidus (Thunbg.) Less.*	*Арзгар согсоот*		Sol	Цөөн наст
10	*Caragana stenophylla Pojark.*	*Нарийн навчит харгана*		Sol	Сөөг
11	*Bassia dasyphylla (Fisch.et Mey.) Ktze.*	*Услиг манан-хамхаг*		Sol	Цөөн наст
12	*Asparagus gobicus Ivanova.ex Grub.*	*Говийн хэрээн нүд*		Sol	Олон наст
13	*Scorzonera divaricata Turcz.*	*Дэрэвгэр хависгана*		Sol	Олон наст

Дэрст / Н-III-3-5/ бэлчээр: Тус талбай нь тэгш талын хонхор элстэй хэсгээр тархах дэрст бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 16%, халцгай газрын бүрхэц 84%, 10 зүйлийн ургамал (бичиглэл-13) бүртгэгдсэн, 1м.кв. талбайд 6 зүйл ургана, ургац 1,3 ц/га байсан. Ургамлан нөмрөгийн өндөр 5 см, дэрс 20 см өндөртэй бөгөөд хоёр ярус илэрч байсан. Зонхилогч ургамлын хувьд үетнээс Гялгар дэрс, Зүүнгарын хазааргана, Сайрын хялгана, алаг өвснөөс Ширэг улалж, Таана буюу багалгар сонгино, Хөмөл, Нарийн цахилдаг, Цагаан хунчир, Царс навчит ангалзур, цөөн наст ургамлаас Толгодын бударгана ургана. Бэлчээрийн талхагдал бага байсан.

Зураг 23. 13-р бичиглэл хийсэн цэгийн ерөнхий ургамалжил, 1м^2 талбай дахь ургамалжил

Хүснэгт 27. Бичиглэл-13

Ургамлын зүйлийн бүрдэл					
№	**Ургамлын латин нэр**	**Ургамлын монгол нэр**	**Бүрхэц (%)**	**Арви**	**Амин хэлбэр**
1	*Achnatherum splendens (Trin.) Nevski*	*Гялгар дэрс*	10	Cop1	Олон наст
2	*Carex duriuscula C.A.Mey.*	*Ширэг улалж*	1	Sp	Олон наст
3	*Allium polyrrhizum Turcz. Ex rgl.*	*Таана буюу багалгар сонгино*	1	Sp	Олон наст

4	*Allium mongolicum Rgl.*	*Хөмөл*	1	Sp	Олон наст
5	*Iris tenuifolia*	Нарийн цахилдаг	1	Sp	Олон наст
6	*Astragalus galactites Pall.*	*Цагаан хунчир*		Sol	Олон наст
7	*Cleistogenes soongarica*	Зүүнгарын хазааргана	1	Sp	Олон наст
8	*Stipa glareosa P.Smirn.*	*Сайрын хялгана*		Sol	Олон наст
9	*Lagochilis ilicifolius*	*Царс навчит ангалзуур*		Sol	Олон наст
10	*Salsola collina Pall.*	*Толгодын бударгана*		Sol	Цөөн наст

Дэрс – улалжит /Н-III-3-5/ бэлчээр: Тус талбай нь уулын бэл хормой түүний тэгш хөндийгөөр тархах ширэг улалж - дэрст бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 21%, 11 зүйлийн ургамал (бичиглэл-8) бүртгэгдсэн, 1м.кв. талбайд 4 зүйл ургана, ургац 1,6 ц/га байсан. Ургамлан нөмрөгийн өндөр 15 см байсан. Зонхилогч ургамлын хувьд үетнээс Гялгар дэрс, Сайрын хялгана, Зүүнгарын хазааргана, алаг өвснөөс алаг өвснөөс Ширэг улалж, Хөмөл, Говийн хэрээн нүд, Дэрэвгэр хависгана, Хурц навчинцар ортууз, Молдав шимэлдэг, Имт гичгэнэ, Амманы сэдэргэнэ, Дагуур хүж өвс, цөөн наст ургамлаас Арзгар согсоот, Үслиг манан-хамхаг ургана. Бэлчээрийн талхагдал дунд байсан. Сөөгнөөс Тарваган харгана 100м.кв. талбайд 1 ширхэг тохиолдоно.

Зураг 24. 16-р бичиглэл хийсэн цэгийн ерөнхий ургамалжил, 1м^2 талбай дахь ургамалжил

Хүснэгт 28. Бичиглэл-16

Ургамлын зүйлийн бүрдэл					
№	**Ургамлын латин нэр**	**Ургамлын монгол нэр**	**Бүрхэц (%)**	**Арви**	**Амин хэлбэр**
1	*Carex duriuscula C.A.Mey.*	*Ширэг улалж*	5	Sp	Олон наст
2	*Achnatherum splendens (Trin.) Nevski*	*Гялгар дэрс*	15	Cop1	Олон наст
3	*Allium polyrrhizum Turcz. Ex rgl.*	*Таана буюу багалгар сонгино*	0	Sp	Олон наст
4	*Stipa glareosa P.Smirn.*	*Сайрын хялгана*	1	Sp	Олон наст
5	*Cleistogenes soongarica*	Зүүнгарын хазааргана	0	Sp	Олон наст
6	*Allium mongolicum Rgl.*	*Хөмөл*	0	Sp	Олон наст
7	*Heteropappus hispidus (Thunbg.) Less.*	*Арзгар согсоот*		Sol	Цөөн наст
8	*Caragana stenophylla Pojark.*	*Нарийн навчит харгана*	0	Sp	Сөөг
9	*Bassia dasyphylla (Fisch.et Mey.) Ktze.*	*Үслиг манан-хамхаг*	0	Sp	Цөөн наст
10	*Asparagus gobicus Ivanova.ex Grub.*	*Говийн хэрээн нүд*	0	Sp	Олон наст
11	*Scorzonera divaricata Turcz.*	*Дэрэвгэр хависгана*	0	Sp	Олон наст

8. Ургамлын нөмрөгийн ашиглалт, хамгаалалт, талхагдлын өнөөгийн байдал

Хээрийн судалгаа болон боловсруулалтын явцад бүлгэмдэлд зонхилогч, дэд зонхилогч, ерөнхий тусгаг бүрхэц, халцгай газар, хүмүүнсэг ургамлын эзлэх хувь хэмжээг харгалзан үзэж Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхлагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын дагуу бэлчээрийг талхагдлын зэргээр нь сул, дунд, хүчтэй газрын төлөв нь доройтсон ба доройтоогүй хэвийн соргог бэлчээр гэж ангилдаг бөгөөд стандартын ангиллын дагуу тодорхойлсон.

Хүснэгт 29. Бэлчээрийн талхагдлын зэрэг

Нэгж талбарын дугаар	Бэлчээрийн төрлийн нэр	MNS 5546:2005
Бичиглэл -1	Сөөг бүхий сайрын хялганат/ ЦХ-I-1-1/	сул
Бичиглэл -2	Харгана - улалжит / ЦХ-I-3-1/	сул
Бичиглэл -3	Сайрын хялгана- алаг өвст / ЦХ-I-1-1/	сул
Бичиглэл -4	Дэрст / Н-III-3-5/	сул
Бичиглэл -5	Сайрын хялгана - харганат /У-VI-1-6/	соргог
Бичиглэл -6	Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/	дунд
Бичиглэл -7	Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/	дунд
Бичиглэл -8	Дэрс – таанат /Н-III-3-4/	сул
Бичиглэл -9	Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/	соргог
Бичиглэл-10	Сайрын хялганат/ ЦХ-I-1-1/	соргог
Бичиглэл-11	Сайрын хялганат/ ЦХ-I-1-1/	сул
Бичиглэл-12	Сайрын хялгана- хазаар өвст / ЦХ-I-1-2/	сул
Бичиглэл-13	Дэрст / Н-III-3-5/	сул
Бичиглэл-14	Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/	сул
Бичиглэл-15	Таана – Монгол өвст бэлчээрийн талхлагдсан хувилбар / ЦХ-I-2-2/ улалжит	их
Бичиглэл-16	Дэрс – улалжит /Н-III-3-5/	сул
Бичиглэл-17	Харганат / ЦХ-I-3-1/	соргог
Уурхайн ухаш, овоолго, баяжуулах үйлдвэр, хаягдлын сан, засварийн төв, агуулах, ШТС, шимт хөрсний овоолго, зам, зогсоол		хүчтэй

Уурхайн ухаш, овоолго, баяжуулах үйлдвэр, хаягдлын сан, засварийн төв, агуулах, ШТС, шимт хөрсний овоолго, зам, зогсоолын ургамлан нөмрөг устсан тул хүчтэй доройтсон. Судалгааны талбайн ургамлан нөмрөгийн Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/ бэлчээр, Сайрын хялганат/ ЦХ-I-1-1/бэлчээр, Харганат / ЦХ-I-3-1/ бэлчээр **соргог**, Сөөг бүхий сайрын хялганат/ ЦХ-I-1-1/ бэлчээр, Харгана - улалжит / ЦХ-I-3-1/ бэлчээр, Сайрын хялгана- алаг өвст / ЦХ-I-1-1/ бэлчээр, Дэрст / Н-III-3-5/ Дэрс – таанат /Н-III-3-4/Сайрын хялганат/ ЦХ-I-1-1/ бэлчээр, Сайрын хялгана- хазаар өвст / ЦХ-I-1-2/ бэлчээр, Дэрст / Н-III-3-5/ бэлчээр, Сайрын хялгана-хазаар өвст / У-VI-1-2/Дэрс – улалжит /Н-III-3-5/ бэлчээр сул талхлагдсан, Сайрын хялгана-хазаар өвст / У-VI-1-2/ бэлчээр, Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/ бэлчээр **дунд**, Таана – Монгол өвст бэлчээрийн талхлагдсан хувилбар / ЦХ-I-2-2/ улалжит бэлчээр **их** талхлагдсан байна.

9. Дүгнэлт

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхитын Алт – Мөнгөний ил орд” газрын үйл ажиллагаа явуулж буй талбайд газрын төлөв байдлын чанарын хянан баталгааны

ургамлын судалгааг 2025 оны 6 дугаар сард хийж төлөв байдлыг илрүүлэв. Тус талбайг бүрэн илтгэх боломжтой 17 цэгт, байнгын мониторингийн 6 цэгт судалгаа явуулж тайлан боловсрууллаа.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхитын Алт – Мөнгөний ил орд” талбайн хэсэг нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорнод говийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).

Төслийн талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө цөлөрхөг хээрийн ургамалжилтай бөгөөд бүхэлдээ 4 хэвшилийн 17 бүлгэмдэлд хуваалаа.

Төслийн талбайд 2025 оны 6 сарын сүүлээр 25 овгийн 44 төрлийн 64 зүйл ургамал бүртгэгдсэн.

Судалгааны талбайн 2023 онд 26 овгийн 59 төрлийн нийт 86 зүйл ургамал бүртгэгдсэн (Ариунсүрэн, 2023) байсан бол 2024 онд 26 овгийн 60 төрлийн 92 зүйлийн ургамал бүртгэгдлээ. 2025 онд 4 зүйл / Agropyron desertorum - Цөлийн ерхөг, Allium anisopodium- Шувуун хөл сонгино, Iris tenuifolia- Нарийн цахилдаг, Erodium tibetanumWilld. -Түвд заан таваг/ нэмж бүртгэсэнээр Энэ талбайд нийт 26 овгийн 62 төрлийн 100 зүйл ургамал бүртгэгдсэн.

2025 оны хээрийн судалгаагаар төслийн талбайд тэмдэглэгдэж байсан цөөн наст ургамлын 90% нь тохиолдоогүй. Энэ нь 2024-2025 онд оросн хур тунадасны нөлөөгөөр ургамлан бүлгэмдлүүд сэргэж бүлгэмдэлд олон наст үет ургамлын бүрхэц, арви нэмэгдсэн байна.

2025 онд төслийн талбайн ургамлан нөмрөгийн зүйлийн бүрдэл нэмэгдсэн бол мониторингийн 2 дугаар цэгээс бусад талбайн бүрхэц, ургац багасан нь ургамал хагдарч байсантай холбоотой. Судалгааны 2 цэг бүрхэц, ургац, ургамлын өндөр 2 дахин нэмэгдсэн байгаа нь хур тунадастай холбоотой бөгөөд нөхөн сэргэх боломжийг илтгэж байна.

Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхлагдлыг тодорхойлох MNS 5546:2005 стандартын дагуу тодорхойлоход уурхайн ухаш, овоолго, баяжуулах үйлдвэр, хаягдлын сан, засварийн төв, агуулах, ШТС, шимт хөрсний овоолго, зам, зогсоолын ургамлан нөмрөг устсан тул хүчтэй доройтсон. Судалгааны талбайн ургамлан нөмрөгийн Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/ бэлчээр, Сайрын хялганат/ ЦХ-I-1-1/бэлчээр, Харганат / ЦХ-I-3-1/ бэлчээр соргог, Сөөг бүхий сайрын хялганат/ ЦХ-I-1-1/ бэлчээр, Харгана - улалжит / ЦХ-I-3-1/ бэлчээр, Сайрын хялгана- алаг өвст / ЦХ-I-1-1/ бэлчээр, Дэрст / Н-III-3-5/ Дэрс – таанат /Н-III-3-4/Сайрын хялганат/ ЦХ-I-1-1/ бэлчээр, Сайрын хялгана- хазаар өвст / ЦХ-I-1-2/ бэлчээр, Дэрст / Н-III-3-5/ бэлчээр, Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/Дэрс – улалжит /Н-III-3-5/ бэлчээр сул талхлагдсан, Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/ бэлчээр, Сайрын хялгана- хазаар өвст / У-VI-1-2/ бэлчээр дунд, Таана – Монгол өвст бэлчээрийн талхлагдсан хувилбар / ЦХ-I-2-2/ улалжит бэлчээр их талхлагдсан байна.

“Монгол орны улаан ном” (2013)-д орсон нэн ховор, ховор ургамлын зүйлүүд тэмдэглэгдээгүй.

Мониторингийн цэгүүд нь бэлчээрийн нөлөөтэй, цаг уураас хамаарсан үндсэн бүлгэмдлүүд байна.

Цаашид: Төслийн талбайн бэлчээрийн судалгааг навийвчлан хийлгэх

- Үйл ажиллагаа өргөтгөсөнтэй холбоотойгоор нөлөөллийн зэргээс хамаарсан мониторингийн цэг нэмэж байгуулах
- Мониторингийн цэг тэмдэгжүүлэх
- Ургамлан нөмрөгийн судалгааг 7 дугаар сарын 15 –наас 9 сарын 1-ны өдөр хүртэлх хур тунадас орсоны дараах 7 хоногоос хийх нь тохиромжтой.
- Хашаалсан талбайг хадах, эсвэл хагд өвс ихээр үүсч байгаатай холбоотойгоор галын аюулгүй байдлыг хангах, хээрийн түймэрээс болгоомжлох шаардлагатай.

Хаяг: “Нандин байгаль” ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
9-р хороо, Их тойруу-70,
Худэрмонх оффис 506 тоот
Утас: 99102135, 78000022
Цахим хаяг: nandinbaigali4@gmail.com

Байгаль орчны судалгаа, үнэлгээ, зөвлөх үйлчилгээний
“НАНДИН БАЙГАЛЬ” ХХК

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН АЖЛЫН ТАЙЛАН
(УСНЫ ЧАНАРЫН СУУРЬ СУДАЛГАА)

Улаанбаатар
2025 он

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН АЖЛЫН ТАЙЛАН

УСНЫ ЧАНАРЫН СУУРЬ СУДАЛГАА

БАТЛАВ:
"НАНДИН БАЙГАЛЬ" ХХК
Гүйцэтгэх Захирал: **О.БАТГЭРЭЛ**

БОЛОВСРУУЛСАН:
Шинжээч: Монгол улсын зөвлөх инженер
Доктор (Ph.D) **Ч.ЖАВЗАН**

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

Зургийн жагсаалт.....2
Хүснэгтийн жагсаалт.....2
1. Төсөл хэрэгжих орчны гадаргын болон газрын доорх ус.....3
2. Газрын доорх усны тухайд.....3
3. Гидрохимийн судалгааны ажлын арга зүй.....4
4. Уурхай орчмын усны судалгааны үр дүн.....6
5. Дүгнэлт.....25
6. Зөвлөмж.....29
7. Ашигласан материал.....29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгаанд ашиглагдах зарим багаж, хэрэглэгдэхүүн 5
Зураг 2. Усны сорьц авсан цэгүүд 7

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Усны шинжилгээний стандарт аргууд 4
Хүснэгт 2. Байгалийн усны эрдэсжилт, хатуулаг (Жавзан Ч, 2011) 5
Хүснэгт 3. Байгалийн усны pH-ийн ангилал (Жавзан, 2011) 6
Хүснэгт 4. Баяжуулах үйлдвэр-1, үйлдвэрийн хаягдлын оролт 7
Хүснэгт 5. Баяжуулах үйлдвэр-1,хаягдлын гаралт буюу эргэлтийн ус 8
Хүснэгт 6. Баяжуулах үйлдвэр-1-ийн технологийн Эргэлтийн усны дүн, мг/л 8
Хүснэгт 7. Баяжуулах үйлдвэр-1-ийн технологийн усны бичил элементүүд, мкг/л 9
Хүснэгт 8. Баяжуулах үйлдвэр-2, үйлдвэрийн хаягдлын оролт 10
Хүснэгт 9. Баяжуулах үйлдвэр-2, үйлдвэрийн хаягдлын гаралт /тунгаасан ус/ 11
Хүснэгт 10. Баяжуулах үйлдвэр-2, Эргэлтийн усан сан 11
Хүснэгт 11. Баяжуулах үйлдвэр-2-ын технологийн усны шинжилгээний дүн, мг/л 11
Хүснэгт 12. Баяжуулах үйлдвэр-2-ын технологийн усны бичил элементүүд, мкг/л 12
Хүснэгт 13. Уурхайн карьерийн шүүрлийн ус 13
Хүснэгт 14. Уурхайн карьерийн шүүрлийн усны химийн шинжилгээний дүн, мг/л 14
Хүснэгт 15. Уурхайн карьерийн шүүрлийн усны бичил элементүүд, мкг/л 14
Хүснэгт 16. Уурхайн карьерийн шүүрлийн ус 15
Хүснэгт 17. Уурхайн кэмпийн ундны усны нөөцийн сав (Уурын зуух) 16
Хүснэгт 18. Уурхайн кэмпийн гал тогоо-ролт 16
Хүснэгт 19. Уурхайн кэмпийн гал тогоо-угаах хэсэг 16
Хүснэгт 20. Уурхайн оффисын угаалтуур 16
Хүснэгт 21. Уурхайн унд, ахуйн усны химийн шинжилгээний дүн, мг/л 17
Хүснэгт 22. Уурхайн унд, ахуйн усны бичил элементүүд, мкг/л 17
Хүснэгт 23. Уурхайн ногоон байгууламжийн худаг (1-р худаг, 9-р усан сан) 19
Хүснэгт 24. Малчны худаг (гүн өрмийн 6-р худаг) 19
Хүснэгт 25. Малчны худаг (гар худаг, Ажирхай) 19
Хүснэгт 26. Уурхайн усалгаа, малчны худгийн усны химийн шинжилгээ, мг/л 19
Хүснэгт 27. Малчны (6-р) худгийн усны бичил элементүүд, мкг/л 20
Хүснэгт 28. Байгаль орчны мониторингийн цооног (БО-1) 21
Хүснэгт 29. Байгаль орчны мониторингийн цооног (БО-2) 22
Хүснэгт 30. Байгаль орчны мониторингийн шинэ цооног (БО-3) 22
Хүснэгт 31. Уурхайн мониторингийн 2 цооногийн усны химийн шинжилгээ, мг/л 22
Хүснэгт 32. Уурхайн Цэвэрлэх байгууламжийн ахуйн хаягдал бохир ус, (мг/л) (7 сар) 23
Хүснэгт 33. Уурхайн Цэвэрлэх байгууламжийн ахуйн хаягдал бохир ус, (мг/л) (9 сар) 24

УСНЫ ЧАНАРЫН СУУРЬ СУДАЛГАА

“Эрдэнэс Алт ресурс” ХХК-ийн Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт хэрэгжүүлж буй “Салхитын алт-мөнгөний үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа усны чанарыг дараах байдлаар ангилан үнэлэв. Үүнд:

- Баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэглээний
- Ажиллагсдын унд-ахуйн хэрэглээний
- Ногоон байгууламжийн, малчны худаг болон БО-ны мониторингийн цооногууд
- Цэвэрлэх байгууламжийн хаягдал ус гэсэн чиглэлээр авч үзэв.

1. Төсөл хэрэгжих орчны гадаргын болон газрын доорх ус

Тус бүс нутаг нь ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд багтах бөгөөд энд тогтмол урсацтай гол горхигүй, хур тунадас ихтэй жилд тогтдог жижиг тойрмыг эс тооцвол гадаргын ус үндсэндээ байхгүй гэж үзэж болно.

2. Газрын доорх усны тухайд

Энэ районд бүх төрлийн ус хангамжийн эх үүсвэр нь газрын доорх ус байх боловч газрын доорх ус нь ихэвчлэн эрдэслэг, хатуу устай байдаг.

Анх Салхитын мөнгөний ордыг олборлох усны хэрэглээнд зориулж 90 метрийн гүнтэй, 2.2-4.0 л/с-ийн ундаргатай 6 цооног гаргажээ.

2020 онд гидрогеологич Д.Хатанбаатар нар “Эрдэнэс Силбер Ресурс” ХХК-ийн Салхитын мөнгөний ордыг олборлоход үүсэх үйлдвэрийн технологийн усан хангамжийн нэмэлт эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын үр дүнгээр илрүүлсэн газрын доорх усны орд уурхайн төвөөс зүүн хойш 2-3 км зайд нийт 16 цооног өрөмджээ. Судалгааны талбайн хэмжээнд гидравликийн аргаар тооцсон дээрх газрын доорх усны ашиглалтын нөөцийг судалгааны ажлын түвшин, ордын геологи-гидрогеологийн нийлмэл нөхцөл болон газрын доорх усны ордын ашиглалтын нөөцийг ангилах зааврыг үндэслэн шавхалтын үр дүнгээр тооцож нийт судалгааны талбайн хэмжээнд ашиглалтын 5 жилийн хугацаанд **12.2 л/сек буюу 1054.08 м^3**/хоног хэмжээтэй газрын доорх усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн С зэрэгт ангилан Усны нөөцийн зөвлөлөөр батлуулсан байдаг. Гэвч Баяжуулах 2-р үйлдвэр ашиглалтад орсноор усны хэрэгцээ эрс нэмэгдэж, хуучин худгуудын ус нь хүрэлцэхгүй болсноос шинээр худаг нэмж гаргаад байгаа аж.

Уурхайн технологийн хэрэгцээнд зориулж гаргасан худгууд:

-2020-2021 онд “Таширын хүрээ” ХХК 8 худаг

- 2022 онд “Гивадаймонд” ХХК 8 худаг

- 2023 онд Гивадаймонд” ХХК 1 худаг

- 2024 онд Дийф Ватер Дриллинг ХХК 1 худаг гаргасан бөгөөд сүүлийн 2 худаг нь уурхайгаас зүүн хойш 17 км-т байрлана. Энэ 2 худгаас одоогийн байдлаар 15-20 тн-ийн багтаамжтай усны машинаар зөөж хэрэглэдэг ба 2025 оны 6-7 сард судалгаа хийх үед уг худаг засвартай байсан.

3. Гидрохимийн судалгааны ажлын арга зүй

Хээрийн судалгааны арга зүй: Хээрийн хэмжилт судалгаагаар мониторинг судалгаанд хамрагдсан уст цэгүүдийн байршлыг тодорхойлох, орчны бичиглэл хийж фото зураг авах, аргачлалын дагуу усны сорьц цуглуулав.

Сорьцыг боловсруулах, шаардлагатай үзүүлэлтүүдийг тодорхойлох: Сонгосон цэгүүдэд усны шинжилгээг хийхдээ усны шинж чанар, тэдгээрийн үзүүлэлтүүдийг усан дахь ууссан хий, ионуудын тэнцвэр алдагдах, органик бодисууд, бичил биетүүдийн задрал явагдахаас өмнө тодорхойлох нь шинжилгээний ажил үнэн зөв гарахад нөлөөлдөг учир усны температур, pH, цахилгаан дамжуулах чанар, нийт ууссан эрдэс, булингаршил гэх мэт амархан хувирамтгай үзүүлэлтүүдийг газар дээр нь тодорхойлж, харин үндсэн үзүүлэлтүүдийг суурин лабораторид орчин үеийн арга аргачлалаар батлагдсан стандартын дагуу задлан шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

Газар дээр нь тодорхойлсон үзүүлэлтүүд:

- ✓ Цахилгаан дамжуулах чадвар (EC), нийт ууссан эрдэс давс (TDS), усны орчин pH, температур зэрэг үзүүлэлтийг - Мультипараметр HANNA HI98195 багажаар
- ✓ Булингаршлыг – турбидитиметрээр
- ✓ Температурыг- термометрээр тус тус тодорхойлов.

Суурин лабораторид шинжилгээ хийх арга зүй:

1. Усны ерөнхий хими болон бохирдлын үзүүлэлтүүдийг ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн “Усны шинжилгээний лаборатор”-т
2. Бичил элементийн дэлгэрэнгүй шинжилгээг “SGS IMME Mongolia” ХХК-ийн лабораторид ICP80T маркийн багажаар
3. Хаягдал бохир усны шинжилгээг “БОХЗТЛ”-т тус тус шинжлүүлсэн.

Хүснэгт 1. Усны шинжилгээний стандарт аргууд

№	Тодорхойлох үзүүлэлтүүд		Тодорхойлох стандарт арга
1	Температур	T°C	MNS ISO 10523:2001
2	Усны орчин	pH	MNS ISO 10523:2001
3	ЦДЧ	EC µS/cm	MNS ISO 4810:99
4	Нийт ууссан эрдэс бодис	TDS PPM	
5	Аммони	NH_4^+	БС 02:2005
6	Нитрит	NO_2^-	MNS ISO .6777:2001
7	Нитрат	NO_3^-	MNS ISO7890-3:2001
8	Кальц	Ca^{2+}	MNS ISO 2572:1999
9	Магни	Mg^{2+}	MNS 4346:1991
10	Хлорид	Cl^-	MNS ISO 9297:2005
11	Сульфат	SO_4^{2-}	MNS ISO 9280:2001
12	Төмөр 2 валенттай	Fe^{2+}	MNS ISO 4430:2005
13	Төмөр 3 валенттай	Fe^{3+}	MNS ISO 4430:2005
14	Карбонат, гидрокарбонат	CO_3^{2-},HCO_3^-	MNS 4425-97
15	Перманганатын исэлдэх чанар	ПИЧ	MNS ISO 4818:1999
16	Бичил элементүүдийг батлагдсан стандартын дагуу ICP-MS багажаар тодорхойлох.		

EC,TDS метр (T°C)

Сорьц авалт

Автомат, хагас автомат титрлэгч


Суурин pH метр

Усны орчин хэмжигч

Булингар хэмжигч

Зураг 1. Судалгаанд ашиглагдах зарим багаж, хэрэглэгдэхүүн

Ур дүнд боловсруулалт хийх

Усны чанарыг дараах байдлаар ангилан үнэлэв.

Усны химийн найрлагын ангилал.

Байгалийн усны химийн найрлагыг анион, катионы харьцаагаар нь дараах байдлаар ангилдаг. Үүнд:

- Анионы зонхилох байдлаар нь 1 ба 2-р зонхилогч ионыг хооронд нь ялгаж 50 мг-экв/%-аас дээшхийг нэгдүгээр зонхилогч, харин нэгдүгээрээс 10 мг-экв/%-аас багагүй хэмжээгээр найрлагад нь оролцсон ионуудыг дараагийн зонхилогчид дэс дараалан тооцож, хоорондын ялгаа нь 10 мг-экв/%-аас бага байх тохиолдолд холимог ангид тооцдог.

- **HCO_3** /гидрокарбонатын ангийн ус. Энэ ангид эрдэсжилт багатай гол, горхи, нуур, газар доорх цэнгэг ус орно/

- **SO_4** /сульфатын ангийн ус. Энэ ангид гидрокарбонат ба хлорын ангийн завсрын шинж чанарыг хадгалсан бүх төрлийн ус орно/

- **Cl** /хлорын ангийн усанд тэнгис далайн болон эрдэсжилт ихтэй газар доорх ус ихэвчлэн ордог/

Харин катионын хувьд дээрхийн адил зонхилохоор нь кальцийн, магнийн, натрийн, холимог гэж 4 бүлэг /групп/-т хуваадаг бөгөөд анион катионы харгалзах байдлаар нь дараах төрөл /тип/-д хуваадаг ба нэгж нь мг-экв/л байна.Үүнд:

- *1-р төрөл:* $HCO_3^- > Ca^{2+} + Mg^{2+}$
- *2-р төрөл:* $HCO_3^- < Ca^{2+} + Mg^{2+} < HCO_3^- + SO_4^{2-}$
- *3-р төрөл*: $HCO_3^- + SO_4^{2-} < Ca^{2+} + Mg^{2+}$
- *4-р төрөл*: $HCO_3^- = 0$

Хүснэгт 2. Байгалийн усны эрдэсжилт, хатуулаг (Жавзан Ч, 2011)

№	Эрдэсжилтийн зэрэг	Эрдэсжилт, г/л	Хатуулгийн зэрэг	Хатуулаг, мг-экв/л
1	Нэн цэнгэг	< 0.20	Маш зөөлөн	<1.50
2	Цэнгэг	0.21-0.50	Зөөлөн	1.51-3.00

3	Цэнгэгдүү	0.51-1.00	Зөөлөвтөр	3.01-5.00
4	Давсархаг	1.01-3.00	Хатуувтар	5.01-7.00
5	Давстай	3.01-7.00	Хатуу	7.01-9.00
6	Шорвог	>7.01	Маш хатуу	>9.01

Хүснэгт 3. Байгалийн усны pH-ийн ангилал (Жавзан, 2011)

pH	Нэршил	pH	Нэршил
<3.5	Хүчтэй хүчиллэг	6.9-7.2	Саармаг
3.6-5.5	Хүчиллэг	7.3-8.5	Сул шүлтлэг
5.6-6.8	Сул хүчиллэг	8.6-10.0	Шүлтлэг
pH>10.1 бол Хүчтэй шүлтлэг гэж pH-аар 7 ангилж үздэг.			

Усны чанарын судалгааны үр дүнг боловсруулахдаа:

- Үйлдвэрийн технологийн зориулалттай усыг “Усны чанарыг үнэлэх ангилал”-аар үнэлж, зарим голлох үзүүлэлтүүдийг “*Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 6148:2010* стандарт
- Худгийн (унд ахуйн) усыг “*Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018* стандарт
- Ахуйн хаягдал бохир усыг *“Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 6561:2015* стандарттай тус тус харьцуулав.
- Мониторингийн цооногийн усбг “Байгалийн ус”-ны ангиллаар ангилж, цаг хугацаанаас хамааруулан үр дүнгүүдийг хооронд нь харьцуулна.

4. Уурхай орчмын усны судалгааны үр дүн

Судалгааны объект

“Эрдэнэс Алт ресурс” ХХК-ийн Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт хэрэгжүүлж буй “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд Усны чиглэлээр газар дээр нь 3 удаа очиж, сорьц материал цуглуулж, шинжилгээ хийж, үр дүнгээр тайлан бичлээ. Судалгаа хийх бүрдээ ХАБ зааварчилгаа авч, тусгай хамгаалах хэрэгсэл өмсөж, уурхайгаас томилсон хүэнтэй хамт явж хэмжилт хийж, сорьц авч байлаа.

“Эрдэнэс Алт ресурс” ХХК-ийн Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн Ш.Намсрайжавтай ярилцсаны үндсэн дээр баяжуулах 2 үйлдвэрийн хаягдал усны оролт, гаралт, эргэлтийн усан сан, унд, ахуй хэрэглэж буй ус, малчны худаг, БО-ны мониторингийн цооног болон ахуйн хаягдал бохир уснаас сорьц авч, хэмжилт хийхээр болов.

“Эрдэнэс Алт Ресурс” ХХК-ийн Салхитын мөнгө-алтны орд орчмын усны хэмжилт судалгааг 2025 оны 06 сарын 15-17, 07 сарын 07-09, 9 сарын 23-24-ний өдрүүдэд 3 удаагийн давталттайгаар хийж гүйцэтгэв.

6 сарын сорьц авахад БО-ны мэргэжилтэн Ш.Намсрайжав, 7 сарын судалгаанд тус компаний сантехник хариуцсан ажилтан Б.Төрбат, 9 сарын сорьц авахад БО-ны мэргэжилтэн Ш.Намсрайжав, хөндлөнгийн хяналт хийхэд малчин Ё.Хонгорзул байлцав.

Кэмпийн ахуйн бохир ус авахад Соёолон ХХК-ний машинист Д.Өсөхбаяр бидэнтэй хамт явав.

Зураг 2. Усны сорьц авсан цэгүүд

1. Баяжуулах үйлдвэрийн технологийн ус

А. Баяжуулах 1-р үйлдвэрийн технологийн ус

Салхитын уурхайн Баяжуулах 2 үйлдвэр нь үйлдвэрийн технологиос гарсан усаа зузаан хар плёнкоор доторлосон Хаягдлын далан руу шахаж, тунасан уснаас эргүүлэн авч, технологийн усанд ашигладаг байсан бол энэ жилээс 1-р үйлдвэр нь үйлдвэрийнхээ дэргэд усан сан руу хаягдал усаа шахаж, тунгаагаад эргүүлэн ашиглаж байна.

Баяжуулах үйлдвэр-1 нь ”Аглаг Хангайн уулс” ХХК-ний харьяанд үйл ажиллагаа явуулдаг байна. Тус үйлдвэрийн технологид 3 болон 7-р усан сангаас ус төвлөрүүлэн хэрэглэхээс гадна үйлдвэрийн дэргэдэх 2-р усан сангаар дамжуулан хаягдлын далангийн усыг эргүүлэн ашигладаг.

Хүснэгт 4. Баяжуулах үйлдвэр-1, үйлдвэрийн хаягдлын оролт

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт		
			16/VI	08/VII	24/IX
	Ө - 45°51'03.26" У- 106°59'10.53"	pH	7.33	7.24	7.33
		EC (µS/cm)	**8815**	**8974**	**6080**
		TDS (ppm)	**5185**	**5244**	**3648**
		t°C	23.5	24	23
		Булингаршил (NTU)	**Маш их**	**Маш их**	**Маш их**

Баяжуулах үйлдвэр-1-ийн хаягдлын сан руу нийлүүлж байгаа усыг газар дээр нь хэмжихэд булингаршлыг хэмжих боломжгүй маш их тунадастай, бор өнгөтэй, саармаг орчинтой (pH:7.24-7.33), маш их эрдэстэй (цахилгаан дамжуулах чанар EC: 6080-8974 µS/cm, нийт ууссан эрдэс давс TDS: 3648-5244 ppm) байгаа ба бага утга нь хамгийн сүүлийн буюу 9 сарын 24-нд авсан сорьц байна. Эндээс харахад Баяжуулах үйлдвэр-1-ийн хаягдлын сан руу нийлүүлж байгаа усны эрдэсийг өмнөх оны дүнтэй харьцуулахад бараг 2 дахин нэмэгдсэн боловч 9 сарын хэмжилтээр буурч байна.

Хүснэгт 5. Баяжуулах үйлдвэр-1,хаягдлын гаралт буюу эргэлтийн ус

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт		
			16/VI	08/VII	24/IX
	Ө - 45°51'03.05" У- 106°59'11.94"	pH	7.16	6.94	7.13
		EC (µS/cm)	**8420**	**8640**	**5670**
		TDS (ppm)	**4950**	**5184**	**3402**
		t°C	23	22.6	18.6
		Булингаршил (NTU)	55	38.2	23.9

Булингартай хаягдал усыг тунгаагаад эргүүлэн ашиглаж байгаа ба усны булингаршил нь сайн бууж тунгалагшсан (булингаршил 24-55 NTU, бага утга нь 9 сарын хэмжилт), бусад үзүүлэлтийн хувьд анхны хаягдал устайгаа ойролцоо утгатай, эрдсийн хэмжээ нь ялиимгүй бага байна. Харин 3 удаагийн хэмжилтийг хооронд нь харьцуулахад 9 сард харьцангуй сайн буурсан дүнтэй байна.

Хүснэгт 6. Баяжуулах үйлдвэр-1-ийн технологийн Эргэлтийн усны дүн, мг/л

Сорьц авсан хугацаа	Нийт эрдэсжилт	Хатуулаг мг-экв/л	Бохирдол			Найрлага	Үндсэн элементүүд					
			ПИЧ	NH_4^+	NO_2^-/ NO_3^-		CO_3^{2-} /HCO_3^-	Cl^-	SO_4^{2-}	Na^+	Ca^{2+}	Mg^{2+}
”Аглаг Хангайн уулс” ХХК, Эргэлтийн усан сан												
2025.06.16	**5194.2**	**28.30**	**14.40**	0.3	0.0/2.2	Cl^{Na}_{II}	0/213.5	**1633.0**	**1610.0**	**1259.5**	**334.7**	**141.1**
2025.07.08	**5787.0**	**30.45**	**12.16**	0.3	0.0/2.2	Cl^{Na}_{II}	0/189.1	**1758.7**	**1902.0**	**1422.2**	**368.7**	**146.5**
2025.09.24	**3856.1**	**21.15**	**4.64**	0.5	0.03/1.2	SCl^{Na}_{II}	0/128.1	**1032.7**	**1420.0**	**911.1**	**267.5**	**94.8**
MNS 6148:2010	-	-	-	**3.0**	**1.0/50.0**	-	-	**350**	**500**			

Баяжуулах 1-р үйлдвэрийн Эргэлтийн усан сангийн технологийн усны шинжилгээний дүнгээс харахад химийн бүрэлдэхүүний хувьд анионуудаас ихэнхдээ хлорын ион давамгайлж, анионы харьцаа $Cl^->SO_4^{2-}>HCO_3^-$, катионуудаас натрийн ион дангаараа давамгайлж, катионы харьцаа $Na^++K^+>Ca^{2+}>Mg^{2+}$, 2-р төрлийн, чанарын хувьд давстай (эрдэсжилт 3856-5787 мг/л), маш хатуу (хатуулаг 21.15-30.45 мг-экв/л) устай байгаа ба бага утга нь 9 сарын сорьц байна.

Баяжуулах үйлдвэрийн технологийн усыг “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 6148:2010 стандарттай харьцуулахад бохирдлын үзүүлэлт нь стандартаас даваагүй ч эрдэс ихтэй, уг стандартад заасан химийн үндсэн үзүүлэлт болох хлорын ион 6-7 сард 4.7-5.0 дахин, 9 сард 3 дахин, сульфатын ион 6-7 сард 3.2-3.8 дахин 9 сард 2.4 дахин тус тус давсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. Баяжуулах үйлдвэр-1-ийн технологийн усны бичил элементүүд, мкг/л

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	MNS 6148:2010	Хаягдал усны оролт		Хаягдал усны гаралт /эргэлтийн ус/	
			2025.07.08	2025.09.24	2025.07.08	2025.09.24
1	Ag (Мөнгө)	-	<0.2	<0.2	<0.2	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	22	154	23	104
3	As (Хүнцэл)	-	**49**	**114**	**47**	**27.4**
4	Ba (Бари)	2000	80	62	72	56
5	Be (Биндэр)	1	<0.1	0.2	<0.1	<0.1
6	Bi (Висмут)	-	<0.01	<0.01	<0.01	<0.01
7	Cd (Зөөлөн цагаан)	3	0.78	2.08	0.47	0.45
8	Ce (Цери)	-	<0.05	**2.67**	<0.05	<0.05
9	Co (Албин)	-	2.48	5.67	1.94	0.98
10	Cr (Хром)-нийт	70	<10	<10	<10	<10
11	Cs (Цези)	-	**14.6**	**11.8**	**17.5**	7.23
12	Cu (Зэс)	1000	<5	<5	<5	<5
13	Dy (Диспрози)	-	<0.001	0.336	<0.001	<0.001
14	Er (Эрби)	-	0.015	0.201	0.012	0.038
15	Eu (Европи)	-	0.01	0.142	0.008	0.012
16	Fe (Төмөр)	300	<50	<50	<50	<50
17	Ga (Галли)	-	0.14	2.85	0.14	0.08
18	Gd (Гадолини)	-	<0.003	0.42	<0.003	<0.003
19	Hg (Мөнгөн Ус)	2	<0.5	<0.5	<0.5	<0.5
20	Hf (Гафни)	-	<0.004	0.453	<0.004	0.042
21	Ho (Гольми)	-	<0.001	0.06	<0.001	<0.001
22	In (Инди)	-	0.003	0.006	0.003	<0.001
23	La (Лантан)	-	0.09	**1.57**	0.05	<0.01
24	Lu (Лютеци)	-	<0.002	0.032	<0.002	<0.002
25	Mn (Манган)	100	**2973**	**5850**	**2408**	**1080**
26	Mo (Анзан)	40	**451**	**208**	**254**	**183**
27	Nb (Ниоби)	-	0.006	0.31	0.018	0.01
28	Nd (Неодим)	-	0.02	**2.12**	<0.01	<0.01
29	Ni (Диц)	100	27.9	44.6	20.3	12.9
30	P (фосфор)	1300	**2773**	217	607	725
31	Pb (Хар тугалга)	50	7.6	**252**	0.6	1.2
32	Pr (Празеодим)	-	<0.006	**0.72**	<0.006	<0.006
33	Rb (Рубиди)	-	**265**	**165**	**229**	**88.6**
34	Sb (Хэврэг цагаан)	6	6.5	9.4	6.6	5
35	Sc (Сканди)	-	2	12	2	<1
36	Se (Селен)	40	**127**	**76.3**	**132**	**66.6**
37	Sm (Самари)	-	<0.002	0.33	<0.002	<0.002
38	Sn (Цагаантугалга)	-	<0.1	0.3	<0.1	<0.1
39	Sr (Стронци)	-	**5480**	**4020**	**6482**	**4086**
40	Ta (Тантал)	-	0.056	0.077	0.094	0.006
41	Tb (Терби)	-	<0.002	0.05	<0.002	<0.002
42	Te (Теллур)	-	0.8	0.4	0.8	4
43	Th (Тори)	-	<0.002	0.909	<0.002	0.036
44	Ti (Титан)	-	<10	<10	<10	<10
45	Tl (Талли)	-	**0.294**	**2.2**	**0.41**	**0.535**
46	Tm (Тули)	-	<0.001	0.031	<0.001	<0.001
47	U (Уран)	20	2.56	9.12	8.64	7.2
48	V (Ванади)	60 (V_2O_5)	<10	<10	<10	<10
49	Y (Иттри)	-	0.132	**1.48**	0.108	0.038
50	Yb (Иттерби)	-	<0.001	0.269	<0.001	<0.001
51	W (Вольфрам)	-	**0.99**	**1.18**	**0.78**	0.39
52	Zn (Цайр)	5000	32	21	19	32
53	Zr (Циркони)	-	0.11	**15.3**	0.15	0.11

2025 оны 7 сард биднийг судалгаа хийхээр очиход Баяжуулах 1-р үйлдвэрийн технологийн Хаягдлын оролтын усыг үйлдвэрийнхээ дэргэд байран дотроос авч өгсөн бол 9 сард очиход хаягдлын далан руу хоолой татаж нийлүүлж байгаа уснаас сорьц авсан.

Хаягдлын оролт, гаралтын аль алинд нь илэрсэн бичил элементүүдийг "*Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 6148:2010* стандарттай харьцуулахад оролтын усанд Манган (Mn) 29.7-58.5 дахин, Анзан (Mo) 5.2-11.3 дахин, Селен (Se) 1.9-3.2 дахин тус тус давсан бөгөөд бага утга нь 9 сард, гаралтын усанд Манган (Mn) 10.8-24 дахин, Анзан (Mo) 4.6-6.3 дахин, Селен (Se) 1.7-3.3 дахин тус тус давсан ба хаягдлын оролтын усыг гаралт буюу эргэлтийн устай харьцуулахад үзүүлэлтүүд нь буурсан дүнтэй байгаа ба 2 удаагийн хэмжилтийг өөр хооронд нь харьцуулахад бичил элементүүдийн агууламж ерөнхийдөө буурах хандлагатай байна.

Хаягдлын усанд Хүнцэл (As 27-114 мкг/л), Стронци (Sr 4020-6482 мкг/л), Рубиди (Rb 88.6-265 мкг/л) зэрэг хэд хэдэн элементүүд харьцангуй өндөр илрэлтэй байна. 9 сард авсан оролтын усанд Хартугалга (Pb 252 мкг/л) дээрх стандартаас 5 дахин их илэрсэн боловч гаралт буюу Эргэлтийн усанд агууламж нь буурсан байна.

Б. Баяжуулах 2-р үйлдвэрийн технологийн ус

Баяжуулах үйлдвэр-2 нь "Соёолон" ХХК-ний харьяанд үйл ажиллагаа явуулдаг байна. Тус үйлдвэрийн технологид нэгдсэн 1-р усан сангаар дамжуулан үйлдвэрийн дэргэдэх 6-р усан санд усаа татдаг бөгөөд 4, 5, 8-р усан сангаас 1-р усан санд ус төвлөрүүлдэг. Үйлдвэрийн дэргэдэх Эргэлтийн усан санд хаягдлын далангийн усыг эргүүлэн татаж ашигладаг.

Салхитын уурхайн Баяжуулах 2-р үйлдвэр нь үйлдвэрийн технологиос гарсан усаа Хаягдлын далан руу шахаж, тунасан уснаас эргүүлэн авч, технологийн усанд ашигладаг.

Хүснэгт 8. Баяжуулах үйлдвэр-2, үйлдвэрийн хаягдлын оролт

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт		
			16/VI	08/VII	24/IX
	Ө - 45°50'53.48" У- 106°59'48.89"	pH	7.92	7.94	7.38
		EC (µS/cm)	**8895**	**8989**	**5410**
		TDS (ppm)	**5276**	**5380**	**3246**
		t°C	23.9	24.5	22.5
		Булингаршил (NTU)	Маш их	Маш их	Маш их

Баяжуулах 2-р үйлдвэрийн хаягдлын сан руу нийлүүлж байгаа усыг газар дээр нь хэмжихэд булингаршлыг хэмжих боломжгүй маш их тунадастай, бор өнгөтэй, сул шүлтлэг орчинтой (pH:7.38-7.94), маш их эрдэстэй (цахилгаан дамжуулах чанар EC: 5410-8989 µS/cm, нийт ууссан эрдэс давс TDS: 3246-5380 ppm) байгаа ба бага утга нь хамгийн сүүлийн буюу 9 сарын 24-нд авсан сорьц байна. Эндээс харахад Баяжуулах үйлдвэр-2-ын хаягдлын сан руу нийлүүлж байгаа усны эрдэсийг өмнөх онтой харьцуулахад бараг 2 дахин нэмэгдсэн боловч он дотроо 3 удаагийн хэмжилтээр сүүл рүүгээ буюу 9 сарын хэмжилтээр буурсан дүнтэй байна.

Хүснэгт 9. Баяжуулах үйлдвэр-2, үйлдвэрийн хаягдлын гаралт /тунгаасан ус/

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт	
			16/YI	08/YII
	Ө - 45°50'54.71" У- 106°59'29.48"	pH	7.10	7.18
		EC (µS/cm)	**8860**	**8930**
		TDS (ppm)	**5010**	**5358**
		t°C	23.9	24
		Булингаршил (NTU)	25	29.8

Баяжуулах 2-р үйлдвэрийн хаягдлын сан дотроо тунгаасан уснаас 2 удаа сорьц авсан бөгөөд хаягдал анхны устай харьцуулахад булингарын хэмжээ эрс буурсан харин эрдсийн хэмжээ төдийлэн буураагүй байсан ба 9 сард эндээс сорьц аваагүй болно.

Хүснэгт 10. Баяжуулах үйлдвэр-2, Эргэлтийн усан сан

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт		
			16/YI	08/YII	24/IX
	Ө - 45°51'03.28" У- 106°59'12.96"	pH	7.0	7.06	7.40
		EC (µS/cm)	**8088**	**8200**	**5610**
		TDS (ppm)	**4870**	**4920**	**3478**
		t°C	23.3	24	22
		Turbidity (NTU)	3.98	4.35	11.17

Баяжуулах 2-р үйлдвэр нь Эргэлтийн усан санд Хаягдлын далангийн тунасан уснаас усаа татаж үйлдвэрийн технологид хэрэглэдэг ба газар дээр нь хэмжихэд боровтор өнгөтэй, булингаршил 4-11.2 NTU, саармагаас сул шүлтлэг орчинтой (pH:7.0-7.40), их эрдэс давстай (цахилгаан дамжуулах чанар EC: 5610-8200 µS/cm, нийт ууссан эрдэс давс TDS:3478-4920 ppm), эрдсийн хэмжээг өмнөх оны дүнтэй харьцуулахад 2 дахин нэмэгдсэн дүнтэй боловч 2025 оны 3 удаагийн хэмжилтийг өөр хооронд нь харьцуулахад сүүл рүүгээ /9 сард/ буурсан дүнтэй байна.

Хүснэгт 11. Баяжуулах үйлдвэр-2-ын технологийн усны шинжилгээний дүн, мг/л

Сорьц авсан хугацаа	Нийт эрдэсжилт	Хатуулаг мг-экв/л	Бохирдол			Найрлага	Үндсэн элементүүд					
			ПИЧ	NH_4^+	NO_2^-/ NO_3^-		CO_3^{2-} /HCO_3^-	Cl^-	SO_4^{2-}	Na^+	Ca^{2+}	Mg^{2+}
”Соёолон” ХХК, Хаягдал усны гаралт буюу тунгаасан ус												
2025.06.16	**5125.4**	**28.10**	**13.28**	1.3	0.1/1.6	Cl^{Na}_{II}	1/140.3	**1739.5**	**1510.0**	**1256.1**	**342.7**	**133.8**
2025.07.08	**5694.7**	**30.60**	**12.80**	0.15	0.0/0.2	Cl^{Na}_{II}	0/128.1	**1945.4**	**1690.0**	**1414.5**	**366.7**	**149.6**
”Соёолон” ХХК, Эргэлтийн усан сан												
2025.06.16	**5060.6**	**27.45**	**11.04**	1.30	0.1/1.6	Cl^{Na}_{II}	1/140.3	**1679.2**	**1530.0**	**1241.6**	**337.7**	**128.9**
2025.07.08	**5724.0**	**29.85**	**11.52**	1.55	0.1/0.6	Cl^{Na}_{II}	0/128.1	**1715.7**	**1960.0**	**1410.8**	**366.7**	**140.4**
2025.09.24	**3860.6**	**21.05**	3.52	1.20	0.02/1.0	ClS^{Na}_{II}	0/134.2	**1062.2**	**1385.0**	**916.8**	**264.5**	**95.5**
MNS 6148:2010	-	-	-	**3.0**	**1.0/50.0**	-	-	**350**	**500**			

Баяжуулах 2-р үйлдвэрийн Эргэлтийн усан сангийн технологийн усны шинжилгээний дүнгээс харахад химийн бүрэлдэхүүний хувьд анионуудаас хлорын ион

давамгайлж, анионы харьцаа $Cl^{-}>SO_4^{2-}>HCO_3^{-}$, катионуудаас натрийн ион дангаараа давамгайлж, катионы харьцаа $Na^{+}+K^{+}>Ca^{2+}>Mg^{2+}$, 2-р төрлийн устай байна. Чанарын хувьд давстай (эрдэсжилт 3860-5724 мг/л), маш хатуу (хатуулаг 21.05-29.85 мг-экв/л) устай байна. Баяжуулах үйлдвэрийн технологийн усыг "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 6148:2010 стандарттай харьцуулахад уг стандартад заасан бохирдлын үзүүлэлт нь стандартаас даваагүй ч эрдэс ихтэй, уг стандартад заасан химийн үндсэн үзүүлэлт болох хлорын ион 6-7 сард 4.8-4.9 дахин, 9 сард 3 дахин, сульфатын ион 6-7 сард 3.1-3.9 дахин, 9 сард 2.8 дахин тус тус давсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 12. Баяжуулах үйлдвэр-2-ын технологийн усны бичил элементүүд, мкг/л

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	MNS 6148:2010	Хаягдал ус			Эргэлтийн усан сан	
			Оролт/7 сар	Гаралт/7сар	Оролт / 9сар	08/YII	24/IX
1	Ag (Мөнгө)	-	<0.2	<0.2	<0.2	<0.2	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	34	<10	150	57	94
3	As (Хүнцэл)	-	**49**	**47**	**25.1**	**49**	**22.3**
4	Ba (Бари)	2000	<10	76	69	85	45
5	Be (Биндэр)	1	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1
6	Bi (Висмут)	-	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
7	Cd (Зөөлөн цагаан)	3	0.78	0.62	0.1	0.86	0.31
8	Ce (Цери)	-	<0.05	<0.05	<0.05	<0.05	<0.05
9	Co (Албин)	-	1.64	1.68	1.13	2.25	0.77
10	Cr (Хром)-нийт	70	<10	<10	<10	<10	<10
11	Cs (Цези)	-	**21**	**15.7**	**12.3**	**17.2**	5.46
12	Cu (Зэс)	1000	<5	<5	<5	<5	6
13	Dy (Диспрози)	-	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001
14	Er (Эрби)	-	0.015	0.01	0.004	0.014	0.009
15	Eu (Европи)	-	0.014	0.008	0.013	0.012	0.008
16	Fe (Төмөр)	300	<50	<50	<50	<50	<50
17	Ga (Галли)	-	0.15	0.16	0.1	0.18	0.08
18	Gd (Гадолини)	-	<0.003	<0.003	<0.003	<0.003	<0.003
19	Hg (Мөнгөн Ус)	2	<0.5	<0.5	<0.5	<0.5	<0.5
20	Hf (Гафни)	-	<0.004	<0.004	0.023	<0.004	0.011
21	Ho (Гольми)	-	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001
22	In (Инди)	-	<0.001	0.001	0.001	0.006	0.001
23	La (Лантан)	-	0.17	0.06	<0.01	0.03	<0.01
24	Lu (Лютеци)	-	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002
25	Mn (Манган)	100	**1547**	**2204**	**1200**	**2499**	**1177**
26	Mo (Анзан)	40	**255**	**257**	**183**	**250**	**146**
27	Nb (Ниоби)	-	0.017	0.020	<0.005	0.021	<0.005
28	Nd (Неодим)	-	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
29	Ni (Диц)	100	18.5	19.6	10.6	28.9	12.6
30	P (фосфор)	1300	539	560	960	568	373
31	Pb (Хар тугалга)	50	0.6	1.3	0.6	1	<0.5
32	Pr (Празеодим)	-	<0.006	<0.006	<0.006	<0.006	<0.006
33	Rb (Рубиди)	-	**237**	**210**	**134**	**217**	**89.2**
34	Sb (Хэврэг цагаан)	6	**8**	**6.4**	4.8	**8.2**	3.2
35	Sc (Сканди)	-	2	1	<1	2	<1
36	Se (Селен)	40	**132**	**134**	**69.2**	**126**	**63.1**
37	Sm (Самари)	-	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002
38	Sn (Цагаантугалга)	-	<0.1	<0.1	<0.1	<0.1	<0.1
39	Sr (Стронци)	-	**5743**	**6399**	**3340**	**6328**	**3636**
40	Ta (Тантал)	-	0.058	0.077	0.005	0.081	0.001
41	Tb (Терби)	-	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002
42	Te (Теллур)	-	1	0.8	0.4	0.9	0.9

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	MNS 6148:2010	Хаягдал ус			Эргэлтийн усан сан	
			Оролт/7 сар	Гаралт/7сар	Оролт / 9сар	08/YII	24/IX
43	Th (Тори)	-	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002
44	Ti (Титан)	-	<10	<10	<10	<10	<10
45	Tl (Талли)	-	**0.808**	**0.576**	0.236	**0.712**	0.331
46	Tm (Тули)	-	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001
47	U (Уран)	20	7.31	9.47	4.45	9.31	7.9
48	V (Ванади)	60 (V_2O_5)	<10	<10	<10	<10	<10
49	Y (Иттри)	-	0.244	0.111	0.036	0.093	0.036
50	Yb (Иттерби)	-	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001
51	W (Вольфрам)	-	**0.63**	**0.57**	**0.97**	**0.51**	0.29
52	Zn (Цайр)	5000	12	17	56	16	8
53	Zr (Циркони)	-	0.28	0.14	0.08	0.12	<0.05

Баяжуулах 2-р үйлдвэрийн технологийн Хаягдлын оролт, гаралтын аль алинд нь илэрсэн элементүүдийг "*Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 6148:2010* стандарттай харьцуулахад Манган (Mn) 11.8-25 дахин, Анзан (Mo) 3.6-6.4 дахин, Селен (Se) 1.6-3.3 дахин тус тус давсан ба хаягдлын оролтын усыг гаралт буюу эргэлтийн устай харьцуулахад үзүүлэлтүүд нь буурсан дүнтэй байна. Мөн 2 удаагийн хэмжилтийг өөр хооронд нь 9 сард ерөнхийдөө буурах хандлагатай байна.

Хаягдлын усанд Хүнцэл (As 22-49 мкг/л), Стронци (Sr 3636-6399 мкг/л), Рубиди (Rb 89-237 мкг/л) зэрэг хэд хэдэн элементүүд харьцангуй өндөр илрэлтэй байна.

B. Уурхайн карьерийн шүүрлийн ус

Салхитын уурхайн харьерийн шүүрлийн уснаас өмнөх жилүүдэд усны сорьц авч байгаагүй бөгөөд энэ жлийн ажлын даалгаварт шинжилгээнд хамруулахаар тусгасан байна. Биднийг судалгаа хийх үед уурхайн карьерт багахан хэмжээний ус шүүрч байснаас сорьц авч, хэмжилт хийсэн, харин 9 сарын судалгааны үед карьерт тэсэлгээ хийсэн учир сорьц авах боломжгүй байв.

Хүснэгт 13. Уурхайн карьерийн шүүрлийн ус

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт	
			16/YI	08/YII
	Ө - 45°51'24.77" У- 107°00'09.76"	pH	7.66	7.60
		EC (µS/cm)	1180	1232
		TDS (ppm)	690	739
		t°C	20	24.2
		Булингаршил (NTU)	3.50	3.28

Газар дээр нь хэмжихэд шүүрч байгаа ус нь өнгөгүй тунгалаг, булингаршил 3.3-3.5 NTU (машин техникийн хөдөлгөөнөөр булингартдаг), сул шүлтлэг орчинтой (pH:7.60-7.66), цахилгаан дамжуулах чанар EC: 1180-1232 µS/cm, нийт ууссан эрдэс давс TDS:690-739 ppm байна.

Хүснэгт 14. Уурхайн карьерийн шүүрлийн усны химийн шинжилгээний дүн, мг/л

Сорьц авсан хугацаа	Нийт эрдэсжилт	Хатуулаг мг-экв/л	Бохирдол			Найрлага	Үндсэн элементүүд					
			ПИЧ	NH_4^+	NO_2^-/ NO_3^-		CO_3^{2-} /HCO_3^-	Cl^-	SO_4^{2-}	Na^+	Ca^{2+}	Mg^{2+}
2025.06.16	878.0	**7.85**	4.00	0.55	0.1/2.0	CS^X_{II}	0/335.5	71.0	240.0	107.0	67.1	**54.7**
2025.07.08	922.1	**7.91**	4.16	0.6	0.15/2.2	SC^X_{II}	0/335.5	71.0	270.0	120.1	67.1	**55.4**
MNS 6148:2010	-	-	-	**3.0**	**1.0/50.0**	-	-	**350**	**500**			

Шүүрлийн усны шинжилгээний дүнгээс харахад химийн бүрэлдэхүүний хувьд анионуудаас 6-р сард гидрокарбонат-сульфатын ион давамгайлж, анионы харьцаа $HCO_3^- > SO_4^{2-} > Cl^-$ байсан бол 7 сарын хэмжилтээр анионы харьцаа $SO_4^{2-} > HCO_3^- > Cl^-$, катионуудаас бүх тохиолдолд давамгайлсан элементгүй, холимог, катионы харьцаа $Na^+ + K^+ > Mg^{2+} > Ca^{2+}$, 2-р төрлийн устай байна. Чанарын хувьд цэнгэгдүү (эрдэсжилт 878-922 мг/л), хатуу (хатуулаг 7.85-7.91 мг-экв/л) устай байна. Шүүрлийн усыг “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 6148:2010 стандарттай харьцуулахад уг стандартын шаардлагыг химийн үндсэн үзүүлэлтүүд нь хангаж байна.

Хүснэгт 15. Уурхайн карьерийн шүүрлийн усны бичил элементүүд, мкг/л

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	MNS 6148:2010	Карьерийн ус
1	Ag (Мөнгө)	-	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	40
3	As (Хүнцэл)	-	75
4	Ba (Бари)	2000	23
5	Be (Биндэр)	1	<0.1
6	Bi (Висмут)	-	<0.01
7	Cd (Зөөлөн цагаан)	3	0.47
8	Ce (Цери)	-	<0.05
9	Co (Албин)	-	12.8
10	Cr (Хром)-нийт	70	<10
11	Cs (Цези)	-	9.11
12	Cu (Зэс)	1000	<5
13	Dy (Диспрози)	-	<0.001
14	Er (Эрби)	-	0.002
15	Eu (Европи)	-	0.001
16	Fe (Төмөр)	300	<50
17	Ga (Галли)	-	0.1
18	Gd (Гадолини)	-	<0.003
19	Hg (Мөнгөн Ус)	2	<0.5
20	Hf (Гафни)	-	<0.004
21	Ho (Гольми)	-	<0.001
22	In (Инди)	-	0.002
23	La (Лантан)	-	<0.01
24	Lu (Лютеци)	-	<0.002
25	Mn (Манган)	100	435
26	Mo (Анзан)	40	138
27	Nb (Ниоби)	-	0.049
28	Nd (Неодим)	-	<0.01
29	Ni (Диц)	100	5.1
30	P (фосфор)	1300	<50
31	Pb (Хар тугалга)	50	5.9
32	Pr (Празеодим)	-	<0.006

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	MNS 6148:2010	Карьерийн ус
33	Rb (Рубиди)	-	24.3
34	Sb (Хэврэг цагаан)	6	22.2
35	Sc (Сканди)	-	3
36	Se (Селен)	40	27
37	Sm (Самари)	-	<0.002
38	Sn (Цагаантугалга)	-	<0.1
39	Sr (Стронци)	-	1420
40	Ta (Тантал)	-	0.172
41	Tb (Терби)	-	<0.002
42	Te (Теллур)	-	<0.1
43	Th (Тори)	-	<0.002
44	Ti (Титан)	-	<10
45	Tl (Талли)	-	0.759
46	Tm (Тули)	-	<0.001
47	U (Уран)	20	61.7
48	V (Ванади)	60 (V_2O_5)	<10
49	Y (Иттри)	-	0.027
50	Yb (Иттерби)	-	<0.001
51	W (Вольфрам)	-	0.26
52	Zn (Цайр)	5000	28
53	Zr (Циркони)	-	0.1

Уурхайн карьерийн усанд тодорхойлсон 53 бичил элементийн шинжилгээний дүнг "*Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 6148:2010* стандарттай харьцуулахад Манган (Mn) 4.3 дахин, Анзан (Mo) 3.4 дахин, Хэврэг цагаан (Sb) 3.7, Уран (U) 3.1 дахин тус тус их гарсан байна. Түүнчлэн Хүнцэл (As), Цези (Cs), Талли (Tl), Вольфрам (W) зэрэг элементүүд харьцангуй өндөр агууламжтай илэрч байна.

Гэрээнд заасны дагуу уурхайн шүүрлийн уснаас сорьц авч, шинжилгээг БОХЗТЛабораторид өгч шинжлүүллээ.

Хүснэгт 16. Уурхайн карьерийн шүүрлийн ус

Фото зураг	Үзүүлэлтүүд	MNS 6561:2015	Үр дүн 08/ҮП
	pH	**6-9**	7.85
	Жинлэгдэх бодис (мг/л)	**400**	<0.1
	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч-ХХХ (мг/л)	**800**	1.5
	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч-БХХ$_5$ (мг/л)	**400**	2.6
	NH_4-N (мг/л)	**15**	0.54
	NO_2-N (мг/л)	**-**	0.464
	NO_3-N (мг/л)	**-**	5.97
	$N_{нийт}$ (мг/л)	**30**	6.97
	$P_{нийт}$ (мг/л)	**5**	0.006

Уурхайн карьерийн шүүрлийн усны бохирдлын үзүүлэлтүүдийг "*Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны чанар. Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 6148:2010* стандарттай харьцуулахад бүгд илрэл багатай байгаагаас үзэхэд уг ус нь цэвэрхэн ус болохыг харуулж байна.

2. Уурхайн унд, ахуйн ус

Уурхайн ажилчдын унд, ахуйд хэрэглэж байгаа Уурын зуухны цэвэр усны нөөцийн сав, Кэмпийн гал тогооны оролт, Кэмпийн гал тогооны гаралт, Оффисын угаалтуур 4 уснаас сорьц авч, хэмжилт хийсэн.

Хүснэгт 17. Уурхайн кэмпийн ундны усны нөөцийн сав (Уурын зуух)

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт		
			16/YI	08/YII	24/IX
	Ө - 45°52'18.22" У- 107°00'00.12"	pH	8.0	7.86	7.83
		EC (µS/cm)	**1730**	**1786**	**1745**
		TDS (ppm)	**1032**	**1071**	**1048**
		t°C	18.5	21.0	20.6
		Turbidity (NTU)	0.98	1.28	1.05

Хүснэгт 18. Уурхайн кэмпийн гал тогоо-оролт

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт		
			16/YI	08/YII	24/IX
	Ө - 45°52'18.52" У- 107°00'00.05"	pH	7.99	7.86	7.86
		EC (µS/cm)	**1780**	**1826**	**1780**
		TDS (ppm)	**1054**	**1096**	**1068**
		t°C	22.6	23	19
		Turbidity (NTU)	1.50	1.94	1.01

Хүснэгт 19. Уурхайн кэмпийн гал тогоо-угаах хэсэг

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт		
			16/YI	08/YII	24/IX
	Ө - 45°52'18.52" У- 107°00'00.05"	pH	7.98	7.80	7.82
		EC (µS/cm)	**1778**	**1820**	**1767**
		TDS (ppm)	**1052**	**1092**	**1060**
		t°C	22.5	23	20.3
		Turbidity (NTU)	1.78	2.15	1.58

Хүснэгт 20. Уурхайн оффисын угаалтуур

Фото зураг	Солбицол	Үзүүлэлтүүд	Хэмжилт	
			08/YII	24/IX
	Ө - 45°52'17.41" У- 106°59'59.18"	pH	7.82	7.73
		EC (µS/cm)	**1822**	**1756**
		TDS (ppm)	**1092**	**1054**
		t°C	20	21.5
		Turbidity (NTU)	1.68	1.70

Уурхайн кэмпийн ундны зориулалтаар хэрэглэж усны газар дээр нь хийсэн хэмжилтээр бүгд өнгөгүй тунгалаг (булингаршил 0.98-2.15 NTU), харьцангуй эрдэслэг (EC: 1730-1826 µS/cm, TDS: 1032-1096 ppm), сул шүлтлэг орчинтой (pH 7.80-8.0) устай байна. 3 удаагийн хэмжилтийн дүн өөр хоорондоо ойролцоо утгатай байна.

Хүснэгт 21. Уурхайн унд, ахуйн усны химийн шинжилгээний дүн, мг/л

Харьцуулах стандарт	Нийт эрдэсжилт	Хатуулаг мг-экв/л	Бохирдол			Индекс	Үндсэн элементүүд					
			ПИЧ	NH_4^+	NO_2/NO_3		CO_3^-/HCO_3^-	Cl^-	SO_4^{2-}	Na^+	Ca^{2+}	Mg^{2+}
MNS 0900:2018	1000.0	7.00	10.0	1.5	1.0 /50.0		-	350	500	200	100	30
Уурын зуухны доторх цэвэр усны нөөцийн сав												
2025.06.16	**1253.0**	4.40	2.56	0.6	0.0/2.2	X^{Na}_1	3/402.6	220.1	245.0	**312.9**	33.1	**33.4**
2025.07.08	**1281.2**	4.45	2.24	0.6	0.0/2.2	X^{Na}_1	0/414.8	225.8	250.0	**320.2**	34.5	**33.2**
2025.09.24	**1284.9**	4.40	3.52	0.6	0.0/45	X^{Na}_1	6/402.6	196.0	250.0	**317.9**	34.1	**32.8**
Кэмпийн нэгдсэн гал тогооны ус, оролт (хоол унд хийх хэсэг)												
2025.06.16	**1265.8**	4.45	2.56	0.0	0.0/2.4	X^{Na}_1	3/411.8	220.1	245.0	**316.1**	34.1	**33.4**
2025.07.08	**1231.7**	4.42	2.40	0.0	0.0/2.4	X^{Na}_1	0/414.8	204.5	240.0	**303.1**	33.5	**33.4**
2025.09.24	**1288.8**	4.32	4.16	0.0	0.0/46	X^{Na}_1	6/390.4	198.1	260.0	**322.4**	34.1	**31.9**
Кэмпийн нэгдсэн гал тогооны ус, гаралт (аяга таваг угаах хэсэг)												
2025.06.16	**1263.9**	4.45	2.56	0.0	0.0/2.2	X^{Na}_1	3/414.8	216.6	245.0	**314.9**	34.1	**33.4**
2025.07.08	**1239.3**	4.43	2.56	0.0	0.0/2.2	X^{Na}_1	0/420.9	204.1	240.0	**304.9**	33.9	**33.3**
2025.09.24	**1292.3**	4.40	3.36	0.0	0.0/45	X^{Na}_1	6/408.7	197.0	248.0	**320.6**	34.1	**32.8**
Оффисын байрны угаалтуур												
2025.07.08	**1318.3**	4.63	2.56	0.0	0.0/2.4	X^{Na}_1	0/427.0	198.1	295.0	**325.1**	36.7	**34.0**
2025.09.24	**1277.1**	4.35	7.84	0.0	0.0/46	X^{Na}_1	6/396.5	195.3	250.0	**317.4**	33.1	**32.8**

Уурхайн кэмпийн ажилчдын унд, ахуйн усны шинжилгээний дүнгээс харахад ус нь химийн бүрэлдэхүүний хувьд анионуудаас давамгайлсан ионгүй холимог, анионы харьцаа ихэвчлэн $HCO_3^->Cl^->SO_4^{2-}$, катионуудаас натрийн ион дангаараа давамгайлж, катионы харьцаа $Na^++K^+>Mg^{2+}>Ca^{2+}$, 1-р төрлийн устай байна. Чанарын хувьд давсархаг (эрдэсжилт 1231-1318 мг/л), зөөлөвтөр (хатуулаг 4.35-4.63 мг-экв/л, хатуулаг дотроо магнийн ион зонхилсон бөгөөд стандартаас давсан) устай байна. Уурхайн кэмпийн ундны зориулалттай усны химийн үндсэн үзүүлэлтүүдийг "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандарттай харьцуулахад ерөнхий эрдэсжилт, натри, магнийн ионууд уг стандартаас давж байгаа учир хүний унданд цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх хэрэгтэй. Эсвэл үйлдвэрийн савласан устай тодорхой харьцаагаар хольж давсан элементүүдийг бууруулж хэрэглэж болох юм.

Хүснэгт 22. Уурхайн унд, ахуйн усны бичил элементүүд, мкг/л

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	MNS 0900:2018	Цэвэр усны нөөцийн сав		Гал тогоо, оролт	
			08/VII	24/IX	08/VII	24/IX
1	Ag (Мөнгө)	100	<0.2	<0.2	<0.2	<0.2
2	Al (Хөнгөнцагаан)	500	<10	149	42	144
3	As (Хүнцэл)	10	**16**	**14.2**	**13**	**14.9**
4	Ba (Бари)	700	<10	<10	<10	<10
5	Be (Биндэр)	0.2	<0.1	<0.1	<0.1	<0.1
6	Bi (Висмут)		<0.01	<0.01	<0.01	<0.01
7	Cd (Зөөлөн цагаан)	3	0.11	0.02	0.09	0.04
8	Ce (Цери)		<0.05	<0.05	<0.05	<0.05

№	Шинжилсэн үзүүлэлтүүд	MNS 0900:2018	Цэвэр усны нөөцийн сав		Гал тогоо, оролт	
			08/VII	24/IX	08/VII	24/IX
9	Co (Албин)		0.51	0.21	0.32	0.22
10	Cr (Хром)-нийт	50	<10	<10	<10	<10
11	Cs (Цези)		0.56	0.461	0.52	0.547
12	Cu (Зэс)	2000	6	<5	<5	<5
13	Dy (Диспрози)		<0.001	<0.001	<0.001	<0.001
14	Er (Эрби)		<0.001	<0.001	0.001	<0.001
15	Eu (Европи)		<0.001	<0.001	<0.001	<0.001
16	Fe (Төмөр)	300	<50	<50	<50	<50
17	Ga (Галли)		0.05	<0.02	0.07	<0.02
18	Gd (Гадолини)		<0.003	<0.003	<0.003	<0.003
19	Hg (Мөнгөн Ус)	1.0	<0.5	<0.5	<0.5	<0.5
20	Hf (Гафни)		<0.004	0.028	<0.004	0.017
21	Ho (Гольми)		<0.001	<0.001	<0.001	<0.001
22	In (Инди)		<0.001	<0.001	<0.001	<0.001
23	La (Лантан)		<0.01	<0.01	<0.01	<0.01
24	Lu (Лютеци)		<0.002	<0.002	<0.002	<0.002
25	Mn (Манган)	100	11	15	<5	18
26	Mo (Анзан)	70	38.9	37.9	37.3	35
27	Nb (Ниоби)		0.058	<0.005	0.065	<0.005
28	Nd (Неодим)		<0.01	<0.01	<0.01	<0.01
29	Ni (Диц)	20	1.3	<0.3	1.5	<0.3
30	P (фосфор)	1142	<50	85	<50	<50
